ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 10 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-8

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-78

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Засгийн газар 2026.09.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх/*** 12-34

2.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг/*** 34-40

3.Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд */Засгийн газар 2026.08.31-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг****, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./* 40-78

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 06-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 16 минутад Төрийн ордны "Их эзэн Чингис хаан" танхимд эхлэв.

Томилолттой: О.Номинчимэг, У.Отгонбаяр;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир;
Тасалсан: Д.Батлут, Х.Баттулга, Э.Батшугар, Б.Дэлгэрсайхан, Д.Пүрэвдаваа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжиний асуусан асуултад Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар хэлэлцэх асуудлын гуравдугаар асуудал болох Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/-ийг хойшлуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17

76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргаж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам тайлбар хийв.

Нэг.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүд */Засгийн газар 2026.09.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Г.Тэмүүлэн, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга О.Оюунзул, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Ч.Батбямба, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хуул зүй, дотоод хэргийн сайд Г.Тэмүүлэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, С.Эрдэнэболд, Б.Тулга, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Хуул зүй, дотоод хэргийн сайд Г.Тэмүүлэн, Хуул зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: 1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл */Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, мөн комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Ч.Батбямба, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, С.Уянга нар байлцав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын тавьсан асуултад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хууль ёсны” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, “буюу” гэснийг “, эсхүл” гэж, “тохиолдолд энэ тухайгаа нотлох баримт сэлт” гэснийг “бол өөрт байхгүй холбогдох нотлох баримт сэлтийг энэ хуулийн 6.2-т заасан байгууллагад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “2” гэснийг “7.2” гэж, “холбогдох” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын тавьсан асуултад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын асуусан асуултад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн хариулж, тайлбар хийв.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “3” гэснийг “12.3” гэж өөрчлөх эсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд */Засгийн газар 2026.08.31-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг****, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Г.Тэмүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Үндэсний аудитын газрын Нийцлийн

аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал Ч.Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер М.Наранжаргал, Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер Д.Цэгмэддорж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Д.Мөнхзориг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, мөн хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Мөнх-Алдар, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор Д.Чулуунбат, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оростогоо, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Г.Базаргүр, Цагдаагийн ерөнхий газрын дарга Ж.Болд, мөн газрын Тэргүүн дэд дарга Б.Ганчулуун, мөн газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, мөн албаны Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч М.Ралдийжамц, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Төсвийн орлогын ахлах мэргэжилтэн Г.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Т.Ихтамир, мөн газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах референт Л.Баттулга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, мөн комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч Ж.Бямбасүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга А.Намсаманд, мөн газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Г.Цэргийнхүү, Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дабааням, мөн газрын Тамгын газрын дарга Л.Нямдаваа, Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Н.Ганбаяр, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Н.Алтансүх, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхсүх, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонгоо, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Н.Жамъянхүү, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Уранчимэг, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга Т.Ганзориг, мөн төвийн Захиргаа удирдлагын газрын Санхүү, ар талын

тасгийн дарга Н.Уянга, Дотоод хэргийн их сургуулийн захирал Т.Сүхболд, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Гантулга, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Т.Нарантуяа, мөн эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Л.Уянга, ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Буянбат, “Чингис хаан баялгийн сан нэгдэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Ч.Батбямба, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, С.Уянга нар байлцав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, П.Сайнзориг, Л.Соронзонболд, С.Эрдэнэболд, О.Алтангэрэл, С.Одонтуяа, Ж.Баярмаа, Г.Уянгахишиг, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Г.Тэмүүлэн, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор Д.Чулуунбат, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч Ж.Бямбасүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Г.Цэргийнхүү, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Н.Ганбаяр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дабааням, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Буянбат, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Т.Нарантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 58 минут үргэлжилж, ирвэл зохих 28 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 60.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 10 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 16 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

Байнгын хорооны гишүүд олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Гонгорын Дамдинням, Салдангийн Одонтуяа, Буяагийн Тулга, Дамдины Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд, Баярмагнайн Баярбаатар, Лхагвын Мөнхбаатар, Пүрэвжавын Сайнзориг, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Жудгийн Баярмаа, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн нар хүрэлцэн ирсэн байна. Ирц танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүгдэд танилцуулъя. 4 асуудал хэлэлцэхээр байгаа.

Нэгд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх хуралдааныг хийнэ.

Хоёрт, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Гуравдугаарт, Байнгын хорооны төсөл байгаа. Энэ бол “Ажлын хэсэг байгуулах тухай” юм.

Дөрөвд, Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүд, Засгийн газар өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ. Энэ хэлэлцсэн тухай танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлэх юм.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Байна уу?

Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Хоёр асуудал байна. Нэгдүгээрт нь уул нь даргын зөвлөл дээр ярьсан юм Эрүүгийн хуулийн төсөл Хууль зүйн байнгын хороон дээр байгаад байгаа байх аа. Бараг өргөн баригдаад жил болж байна. Хэлэлцэхгүй явсаар байгаад өнгөрсөн хаврын чуулганаар хэлэлцээд хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн. Тэр хууль дээр мэтгэлцээн юм уу, эсвэл байр суурь тодруулах юм уу, танилцуулга юм уу нэг юм хийе гэж яриад байсан. Тэгээд тэрийгээ эртхэн шиг хийгээд хуулиа урагшлуулмаар байна.

Хоёр дахь нь болохоор энэ 27 оны төсөвтэй холбогдуулаад нөгөө гүйцэтгэх ажилтай холбоотой, нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой тэр хэсэг чинь яаж байгаа юм? Төсвийн хэлэлцүүлэг чинь тэр хэсэггүйгээр цаашаа явж чадахгүй шүү дээ. Хуучин бол Аюулгүй байдал дээр тэр тэрүүгээр явчихдаг. Хууль зүйн байнгын хороо их яадаггүй байсан. Одоо Хууль зүйн байнгын хороо хоёр дахь хэлэлцүүлэг гэдэг чинь тэр чинь яах юм? Дэд хороо чинь байгуулагдаагүй байна. Төсвийн хоёрдугаар хэлэлцүүлэг чинь явах юм уу? Явахгүй шүү дээ. Тусгай хяналтын дэд хороо чинь байгуулагдаагүй шүү дээ.

Тэгэхлээр одоо энэ хэлэлцэх асуудлаас энэ хоёрдугаар хэлэлцүүлгээсээ хэлэлцэх асуудлаа бараг хойш нь тавьсан нь дээр шүү дээ. Хууль зөрчиж хэлэлцэж болохгүй шүү дээ.

Л.Мөнхбаатар: Тэмүүжин гишүүн энэ нэр бүхий гишүүдийн өргөн барьсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэсэн байгаа Хууль зүйн байнгын хороон дээр. Үүнтэй холбоотойгоор мэтгэлцээн гэх юм уу, байр сууриа нэгтгэх тийм зорилготой арга хэмжээ авъя гэж байгаа. Энэ асуудлаа бол даргын зөвлөл дээр яригдсан. Ирэх долоо хоногийн Байнгын хороон дээр яг ямархуу хэлбэртэй байх вэ гэдгээ бол шийдээд явъя. Байнгын хорооныхоо энэ асуудлаараа хэлэлцэх асуудалдаа оруулчих даргын зөвлөлөөр. Одоо 5 дахь өдөр шийдэхэд энэ уг асуудлыг Байнгын хорооны хэлэлцэх асуудалд оруулаад явъя гэж бодож байна.

Дараагийнх нь буюу хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Тусгай хяналтын дэд хороо байгуулах асуудал Байнгын хороогоор орж хэлэлцэгдсэн. Өнгөрсөн долоо хоногийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх товд орсон, орж хэлэлцэгдэж эхэлсэн. Гэхдээ энэ 4 дэх өдөр санал хураалт явагдаж эцэслэн байгуулагдана. Ингээд байгуулагдангуут энэ дэд хороо үйл ажиллагаагаа явуулах нэгдүгээрт бүрэн эрхтэй болно. Энэ хүрээндээ төсөвтэй холбоотой, төсвийн холбогдох зүйлүүдтэй холбоотой асуудлаа хэлэлцээд явчихна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэргэд ажиллаж байгаа Тусгай хяналтын дэд хороо ч гэсэн бас мөн адил яг ижилхэн ингээд явна. Одоогоор бол аль аль нь хуралдаагүй байгаа гэдгийг хэлье. Тэгээд ирэх долоо хоногт хэлэлцээд байх бүрэн боломжтой гэдгийг хэлье.

Би энд горимын санал гаргачихъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүнийг сонгон шалгаруулах тухай журам бий. Энэ журамд заасны дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцох албан тушаалтнуудын нэрсийг холбогдох байгууллагуудаас

ирүүлэхээр заасан. Үүний дагуу нэр ирүүлэх боломжтой бүх бай байгууллагууд руу хуульд заасан, журамд заасан байгууллагууд руу албан бичгээ явуулсан.

Одоогийн байдлаар зарим байгууллагуудаас нэрс бас бүрэн ирээгүй байгаа. Тийм учраас энэ өнөөдрийн хэлэлцэх асуудлаас энэ “Ажлын хэсэг байгуулах тухай” асуудлыг хойшлуулж ирэх долоо хоногт ирэх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх ийм саналтай. Горимын санал гаргаж байна. Гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдье.

Айн харин байгуулагдаад явна шүү дээ. Тэгээд байгуулагдангуутаа хэлэлцээд явчихна. 4 дэх өдөр тийм. Тамгын газраас энэ дээрээ лавлагаа өгчхөөрэй. Одоо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэргэдэх Тусгай хяналтын дотроо ч гэсэн бас мөн адил хуралдаагүй байгаа. Энэ бол төсөв танилцуулж байгаа үе шат. Хоёрдугаар хэлэлцүүлэг гэдэг маань төсвийг танилцуулж байгаа үе шат. Бид төсөвтэй танилцсан тухайгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Гуравдугаар үе шатад бол яг хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналуудаа хураагаад явдаг гэдгийг та бүхэн бас мэднэ.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Идэвхжүүлсэн үү? Энэ санал хураалтад нь гараад ирэг тээ. Баярмаа гишүүн идэвхжүүлсэн үү? Энэ хойшлуулж байгаа юм. Ажлын хэсэг байгуулахыг ирэх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцье гэсэн ийм горимын санал гаргаж байгаа юм шүү. Санал хураалт гишүүд ээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 76.5 хувь нь дэмжсэн байна. Уг асуудлыг ирэх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа ороод явъя. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 09 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэрийн сайд Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Тэмүүлэн гишүүн түр байж байгаарай. Тэмүүлэн сайд. Тэмүүжин гишүүний микрофоныг өгчихье. Яах вэ Тамгын газраас хүн ирж байгаа. Тайлбар өгнө одоо. Одоо бол шууд, одоо бол зөвхөн нөгөөдөх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хэлэлцэх гэж байна шүү.

Х.Тэмүүжин: Энэ төсвийн хоёрдугаар хэлэлцүүлэг чинь танилцуулах байхгүй юу. Тэгэхээр энэ төсвүүд дээр аль хувьд нь нөгөө ажиллагааны чинь төсөв явж байгаа юм, ямар дүнтэй явж байгаа юм, өмнөх төсвөөс ямар хэмжээгээр дээшээ, доошоо болж байгаа юм гэх мэтчилний чинь танилцах ёстой байхгүй юу. Тэгээд энэ танилцах процесс дээр энэ дэд хороо чинь оролцох ёстой. Тэгэхгүй бол хоёрдугаар хэлэлцүүлэг дээр дэд хороогоо байгуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байж байж бид нар араас нь нөхөж хийх боломж байхгүй шүү дээ. Энэ дээрээ танилцаад танилцсаныхаа дараа дараагийнхаа хэсэг дээр, задаргаанууд

дээр нь ажиллаад өөрчлөлт орох юм уу, орохгүй юм уу яах юм, санал, гишүүд санал гаргах юм уу, үгүй юм уу гээд тэн дээрээ ярих ёстой уул нь. Тэгэхлээр өмнөх энэ шат чинь байхгүй болчихоор асуудал үүсэх учраас өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлаас энэ төсвийн хэлэлцүүлгийг хойшлуулъя гэдэг горимын санал гаргаж байна. Энэ горимын санал дээр санал хураагаад өгөөрэй.

Л.Мөнхбаатар: Тамгын газраас бол тодорхой бас юу авах нь зүйтэй, тайлбар авах нь зүйтэй. Яагаад гэвэл энэ төсвийн хэлэлцүүлгийн үе шат, түүн дэх Байнгын хороодын болоод дэд хороодын энэ оролцоог илүү тодорхойлсон байдлаар Тамгын газраасаа ямар ч байсан тайлбарыг нь сонсчхоод гишүүд бас саналаа өгөх хэрэгтэй шүү дээ. Тийм. Тамгын газраас хүн ирсэн үү? Холбогдох эрх бүхий албан тушаалтныг нь дуудчих. Тэр тайлбарыг сонссоны дараа горимын саналын тухай яригдана шүү дээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан бас гишүүдээс Улсын Их Хурлын Тамгын газраас тайлбар авах нь зүйтэй гэж үзсэн. Үүний дагуу Улсын Их Хурлын Тамгын газар холбогдох тайлбарыг өгье.

Энэ бол төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг. Энэ хэлэлцүүлгийн үед бол Байнгын хороогоор хэлэлцэнэ гэсэн дэгийн заалттай. Гурав дахь хэлэлцүүлэг бол нь Байнгын хороо болон дэд хороо хэлэлцээд явдаг ийм дэгтэй гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ асуудлаар яг албан ёсных нь тайлбарыг Улсын Их Хурлын Тамгын газар өгье. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье.

Ж.Бямбадулам: Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Бямбадулам. Хууль сахиулах ажиллагааны Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний асуудал өнгөрсөн долоо хоногийн Баасан гараг буюу 10 сарын 02-ны нэгдсэн хуралдаанаар тов, дараалалд орсон байсан. Энд санал хураалгаж амжаагүй учраас энэ долоо хоногийн Пүрэв гаргийн эхний асуудал болж орсон байгаа.

Төсөвтэй холбоотой асуудлаар Дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлээр төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэрхэн хийх талаар зохицуулалт орсон. Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон бусад Байнгын хороо төсвийн төсөлтэй танилцаж хуралдаанаар хэлэлцэнэ гэсэн ийм дэгтэй байгаа. Өөрөөр хэлбэл дэд хорооны асуудлаар тусгайлан зохицуулсан зохицуулалт байхгүй байгаа. Авлигын эсрэг хууль болон Цагдаагийн алба ны тухай хуулиар Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороогоор тухайн байгууллагуудын төсвийг хянуулах, санал өгөх байдлаар зохицуулалт орсон байгаа учраас төсвийн гурав дахь хэлэлцүүлгээс Дэд хороонд эрхлэх асуудлынхаа хүрээгээр санал гаргах ийм боломж дэгийн зохицуулалттай байгаа.

Л.Мөнхбаатар: Ойлголоо. Ингээд уг асуудлын дараа бас гишүүдээс удаа дараа энэ саналууд гарсан учраас нэг мөр ойлголттой боллоо гэж ойлголоо. Тэгэхээр хоёр дахь хэлэлцүүлгийн үед бол Байнгын хороогоор хэлэлцэнэ гэсэн дэгийн хуульд заасныхаа дагуу гурав дахь хэлэлцүүлгээс дэд хороогоор хэлэлцэнэ гэж ойлголоо шүү дээ. Тэгээд дэд хороо бол нь энэ 4 дэх өдөр байгуулагдаад уг асуудлыг хэлэлцээд явах боломжтой гэдгийг хэлье.

Ингээд хэлэлцэх асуудлаа баталъя. Дараагийнхаа асуудалд оръё.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэрийн сайд Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Тэмүүлэн сайдын микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Байнгын хороон дарга, гишүүддээ бас энэ өдрийн мэндийг хүргэе.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаар бас та бүхэндээ товч танилцуулъя. Бид бүхний зүгээс одоогийн энэ эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдаж байгаа зарим асуудлуудыг шийдвэрлэх үүднээс, нөгөө талдаа бол том зургаараа Иргэний шүүхийн ачааллыг зохистой болгох, Иргэний шүүх шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах зорилгоор бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бол боловсруулсан байгаа.

Хуулийн төсөлд би агуулгаар нь үндсэндээ 4 том асуудал байгаа. Энийг бас бүрчлэн та бүхэндээ танилцуулаад явъя.

Нэгдүгээрт, Монгол Улсад анх удаа үндсэндээ энэ 2024 онд дүүргийн эрүү болоод иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатын тойргийн шүүхийг Шүүх байгуулах тухай хуулийн дагуу байгуулсан. Ингээд 24 оны 10 сараас эхлээд энэ шүүх үйл ажиллагаа бол эхэлсэн байгаад байгаа. Тус хялбар ажиллагааны шүүх нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээш бүхий үнийн дүнтэй буюу тухайн үед бол 15.8 сая төгрөгөөс доош мөнгөн хөрөнгө гаргуулах иргэний хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэдэг болсон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 мянга байхад буюу 2024 онд 1 шүүгчид 619 хэрэг ноогдож байсан бол 2025 оны хөдөлмөр хөлсний доод хэмжээ 792 мянга болж нэмэгдсэнээр үндсэндээ 1 шүүгчид ноогдох хэргийн тоо 619-өөс 1456 болж ингээд шүүхийн ачаалал бол 2.5 дахин нэмэгдсэн байгаа.

Яг одоогийн байдлаар буюу сая энэ оны 8 сарын байдлаар бол шүүгчид ногдох хэргийн тоо 1559 болж жил ирэх тусам бол өсөж байгаа. Энэ нь шүүх ерөнхий зөвлөлөөс тогтоосон 1 шүүгчид ноогдох нөгөө зохист ачааллыг 336 гэж тогтоосноос бол үндсэндээ 4.3 дахин их болсон байна. Тэгэхээр цаашид хөдөлмөр хөлсний хэмжээ нэмэгдэх бүрд бол энэ ачаалал өөрөө нэмэгдэхээр байна гэсэн судалгааг бол бас манай Хууль зүйн үндэсний хүрээлэн болоод мэргэжлийн судлаач нар бол гаргаж ирээд ингээд үзсэн байгаа.

Хоёрт, энэ сүүлийн жилүүдэд энэ цахим зээлийн гэрээ байгуулах явдал нэмэгдсэнтэй холбоотойгоор яг энэ төрлийн маргаан бол үндсэндээ нийт хялбаршуулсан шүүхээр, горимоор шийдэж байгаа энэ шүүх ажиллагааны явцад нийт шийдэгдэж байгаа нэхэмжлэл хэргийн бараг 80 орчим хувийг бол эзэлж байгаа. Энэнтэй холбоотойгоор үндсэндээ шүүхийн ачааллыг нэмэгдүүлж байгаа энэ асуудлын бас нэг асуудал нь бол үндсэндээ тухайн тэр зээлдэгчийн мэдээлэл,

хаяг, тухайн баталгаажуулалт өөрөө байхгүй байгаагаас болоод шүүх үйл ажиллагаа бас уддаг ийм асуудал бол байна.

Дээрээс нь хоёрдугаарт бол бид бүхний хувьд энэ хялбар ажиллагааны шүүх нь өөрөө бага үнэ дүнтэй хэргийг 45 хоногийн дотор хурдан шуурхай шийдвэрлэж давж заалдах шатын журмаар хянуулах боломжтой байгаагаар хууль зохицуулсан боловч хялбар ажиллагааны шүүх харьяаллын бус хэргийг хүлээн авсан тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож байгаад байгаа.

Тэгэхээр нөгөө иргэн маань бол нэг нэхэмжлэл, гомдол гаргаад дахиад юу гэдэг юм хэрэгсэхгүй болгочхонгуут дахиад гаргах ийм зайлшгүй шаардлага гаргаад байдаг. Шинээр харьяаллынхаа дагуу шүүхэд хандах ёстой болчхоод байдаг. Иргэд дээр ачаалал ирээд байдаг асуудал байгаа. Тэгэхээр энийг бол практикийн хувьд бол бид нар зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай юм байна. Иргэдэд энэ цаг, хугацаа болоод тухайн энэ процесс нэмж байгаа энэ асуудлууд дээр бол шуурхай шийдвэрлэж, ингээд шүүх бол харьяалах шүүхэд нь шилжүүлэх энэ процессыг бол гаргуулж ирье гэдэг энэ зохицуулалтыг бол ингээд хийсэн.

Гуравдугаарт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд ажиллагаанд шүүхийн мэдэгдэх хуудсыг хэргийн оролцогчдод, ялангуяа хариуцагчдад хүргүүлэх ажиллагаа бол цахимжуулж, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж байгаа асуудлыг шийдвэрлэх бол зайлшгүй шаардлага үүсээд байгаа.

Өнөөдөр шүүхийн мэдэгдэх хуудсыг Монгол шуудангаар хүргүүлэхэд жилд ойролцоогоор 300 орчим сая төгрөг зарцуулдаг. 85 орчим хувьд нь бол гардуулалт амжилтгүй болж байгаа. Харин шүүхийн бичиг хэрэгчээр гүйцэтгэл хүргүүлэхэд бас 85 орчим хувьтай байгаа ч 6 дүүрэг бүрд 1 бичиг хэрэгч ажиллаж байгаа нь нэг талдаа ингээд хангалтгүй, хүртээмжгүй ийм асуудлууд байна.

Тэгэхээр бид нар энэ мэдэгдэх хуудсыг хаягаар хүргүүлэх, үндэсний цахим шуудан болон бусад цахим хэлбэрээр хүргүүлэх, цахим хүргэлт амжилтгүй болсон тохиолдолд шүүхийн албан ёсны хуудсаар хүргүүлсэн талаар нийтэд мэдээлэх, тодорхой хугацааны дараа мэдэгдэх, хуудсыг хүргүүлсэнд тооцож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх зохицуулалтыг бас энэ хуулийн төсөл дээр бол бий болгож байгаа.

Эдгээр өөрчлөлтийг Иргэний хэрэг хянан шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагавар, үнэлгээний тайланд үндэслээд ингээд Улсын дээд шүүхийн шүүгчид, хуульчид, өмгөөлөгчдийг оролцуулаад тэдгээрийн саналыг авч бол ингээд боловсруулсан ийм зүйл байгаа.

Хуулийн төслийг дагалдуулаад боловсруулсан энэ Банк эрх бүхий хууль ийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн төслөөр зээлдэгчийн хаягийг баталгаажуулах үүргийг бол зээл олгож байгаа банк, санхүүгийн байгууллага өөрөө хариуцахаар, цахим хэлбэрээр байгуулах зээлийн гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг шүүхэд гаргах тохиолдолд бол энэ баримтыг зээл олгож байгаа банк, санхүүгийн байгууллага

шүүхэд нотлох баримтаар ирүүлэх үүрэгтэй байхаар ингээд зохицуулалтыг хийсэн байгаа.

Тэгэхээр эдгээр энэ 4 зохицуулалт бол үндсэндээ ингээд энэ хууль дээр хийгдсэнээрээ энэ хуулийн төсөл хэрэв батлагдвал шүүхийн ачаалал бол илүү бас зохистой түвшиндээ очих, ингээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай болгох, иргэдийн шүүхэд хандах болоод шударга шүүхээр шүүлгэх эрхийг бас хангах ийм боломж бололцоо маань бол бүрдэнэ гэж бол бас үзэж байгаа. Тэгээд Байнгын хорооны гишүүдэд бас холбогдох танилцуулга, мэдээллүүдийг бас хүргүүлсэн байгаа. Тэгээд та бүхэн маань хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Ажлын хэсэгт Хууль зүй, дотоод хэрийн сайд Тэмүүлэн, Хууль зүй, дотоод хэрийн дэд сайд мөн Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дондогмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Итгэлсүрэн нар оролцож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай болон хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Соронзонболд, Алтангэрэл гишүүнээр, Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүнийг нэмчих. Тулга гишүүн. Тулга гишүүн, Тулга гишүүнийг оруулъя. Ингээд Тулга гишүүнээр тасаллаа шүү. Гишүүд асуултаа асууя. Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Би бас энэ хуулийн төсөл дээр Монгол Ардын намын бүлэг дээрээ бас тодорхой мэдээлэл авч байсан. Зарим саналуудаа ч хэлж байсан. Яах вэ зүгээр энэ хялбар ажиллагааны гэж яригдаад байгаа энэ Шүүхийг байгуулаад тодорхой үр дүнд хүрч байгаа гэж боловч бас яг бодит байдал дээр эрүү, иргэний асуудлууд нь холилдоод 1 шүүгч тэр төрөлжсөн биш ингээд холилдож шүүгдээд явж байгаа зүйлүүд ч бас ингээд мэр сэр гарчихсан, маш их хэмжээний ачаалал овоорчихсон байгаа юм байна лээ.

Тэгээд ер нь зүгээр аливаа энэ шинэ зохицуулалтуудыг оруулж ирэхдээ нэр томьёо болон агуулгыг зөв оруулж ирэхгүй бол логикийн алдаа гарчихсан юм. Ерөөсөө процесс ажиллагаагаар шүүх нэрлэдэггүй. Жишээ нь шүүхийг бол иргэний шүүх, оюуны өмчийн шүүх, дампуурлын шүүх гээд явдаг байхгүй юу. Эдгээр шүүхүүд дээр буюу ердийн хэрэг дээр ч гэсэн хялбар ажиллагаа байж болно. 2 этгээд хоорондоо нэхэмжлэл гаргаад нэхэмжлэгч, хариуцагчаар явж байгаад эвлэрээд явах юм бол хялбар ажиллагаа л болно. Тэгээд энэ доор аваачаад тодорхой үнийн дүнгээс доошоо юмыг хялбар ажиллагаа гэдэг ийм буруу ойлголт өгөөд явчхаж байгаа юм.

Бусад оронд бол яах вэ зүгээр энэ бол процесс нь бол мэдээж хялбар байгаа, зардал багатай байгаа, цаг хугацаа хэмнэлттэй байгаа. Илүү их юу гэдэг юм оролцогч мэргэжлийн өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа авах гэхээсээ илүүтэйгээр. Би энгийн жишээ ярья. Хими цэвэрлэгээнд хувцас өглөө, муухай

болголоо, агшаачихлаа гэвэл бараг хими цэвэрлэгээнд өгсөн талонтойгоо агшсан хувцастайгаа шүүгчийн өмнө барьж зогсоод л тэдэн төгрөгийн хохирол гээд л цохиод цохиод гаргадаг л юм.

Тэгээд ийм зүйлүүдийг ингээд бас шийдэх ёстой байтал ингээд буруу орчхоод байгаа юм. Тэгээд энийг цаашдаа Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн бас шинэчилсэн найруулгыг хийнэ гэж бас дэд сайд хэлж байсан. Энэ дээрээ бас анхааранд уг нь зөв болгомоор байгаа юм. Тэгээд энэ процессын ажиллагаанууд дээр чинь нөгөө ялгамжтай байдлууд байхгүй учраас бас хэцүү байгаа байхгүй юу. Business to business буюу бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаан дээр аливаа өмгөөлөгч сольж байна, ингэж байна тэгж байна гэж зогсох ёсгүй. Яагаад гэхээр мэргэжлийн оролцогч өөрөө хариуцлагаа ухамсарлаж байгаа гэх зэрэг ингээд бодох юм бол маш олон зүйлүүдийг хийгээд өгвөл энэ бизнес, мөнгөний харилцаа чинь үнэ цэнээ хадгална. Шүүх, хуулийн байгууллагыг ашиглаж бизнесийн үйл ажиллагаанууд царцанги байдал руу ордгоо болино л гэж хэлэх гээд байгаа юм.

Тэгээд бас энэ ташрамд бас хэлчихмээр байна. Уг нь энэ шүүхийн ачааллыг бас ярьсан. Шүүхийн ачааллыг ярихаар бас манай Засгийн газар шууд оролцох бололцоогүй боловч бас энэ дээрээ хэлж яримаар байгаа юм. Сая давж заалдах шатын шүүх дээр өнгөрсөн жил 10 шүүгч нэмэгдсэн. Энэ хаана нэмэгдсэн гээч Захиргааны хэргийн шүүх дээр. Гэтэл Иргэний шүүх дээр хэрэг овоороод байхад тийшээ өгдөггүй. Жилдээ 30-60 хэрэг шийддэг захиргааны шүүх дээр дахиад 10-ыг нэмж байгаа байхгүй юу. Ингээд 20-иод шүүх. Ийм байдлаар ингээд Шүүхийн ерөнхий зөвлөл нь хүртэл энэ ажил, ачааллыг хуваарилаад байхаар энэ яаж явах вэ дээ л гэдэг зүйл байх юм…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд тэгээд нэг зүйл байна. Энэ зээлийн аппликэйшнийг ашигладаг ч гэдэг юм уу, банк, санхүүгийн байгууллагууд, энэ зээл өгч байгаа этгээдийнхээ баталгаажуулалт буюу дутуу, дулимаг юмаа хийгээд хэт их энэ ашгийн төлөө улайрсан үйл ажиллагааг нь бид нар төр мөнгө гаргаж хуулиар ингэж засаж болохгүй. Энэ бол өнөөдрийн практикаараа бол шууд шүүх дээрээ хэрэг үүслээ гэхэд тэр гэрээ хүчин төгөлдөр бусад тооцуулаад банк, санхүүгийн байгууллага хариуцлагаа хүлээх ёстой байхгүй юу. Ингээд явах ёстой. Ингэж байж эд нар чинь хэт ашгийн төлөө биш бизнесийг бас хэн зээлээ өгөх гэж байгаагаа таньдаг. Одоо бараг мэдэхгүй нэг хүний иргэний үнэмлэх явуулчхаад бараг тэрүүгээр нь зээл олгочхоод байгаа байхгүй юу. Ингээд дараа нь шүүх дээр аваачиж бөөн ачаалал. Тэгээд улсын тэмдэгтийн хураамж гэж шалихгүй юм төлнө. 37 мянган цаас. Тэгээд л ингээд л шүүхийг ачаалуулаад л ингээд л явж байгаа. Тэгэхээр бид хэд энийг хаа хаанаасаа бас жоохон энэ шүүхийг бас үнэгүйдүүлж болохгүй. Энэ шүүхийн үйлчилгээг авах гэж байгаа этгээдийг бас бас зарим зүйлүүдийг нь ойлгуулдаг байх хэрэгтэй байгаа юм тэгээд…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Сайнзориг гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Тэмүүлэн сайд бас маш чухал энэ хуулийн өөрчлөлт оруулж ирж байгаа юм байна гэж харж байгаа. Яагаад гэхээр миний хувьд 8 сард Дорнод аймгийн хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан.

Энэ үеэр болохоор ерөнхийдөө цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, шүүх, прокурор дээр ажиллагсдынх нь ажлын ачааллын бараг 60-70 хувийг нь зөвхөн энэ аппликэйшний зээлийн асуудал эзэлж байгаа тухай бол тухайн ажиллагсад бол ярьж байсан. Тэгэхээр бол энэ бол үнэхээр цаг үеэ олсон асуудал орж ирсэн байна гэж харж байгаа.

Тэгээд энэ шийдвэрлэх арга дээр ингээд харахаар бас энэ дээр юм бас тодруулах юм байгаад байгаа юм. Энэ зээлдэгчийн баталгаажуулалтыг нэгдсэн байдлаар зайлшгүй хийдэг байх үүрэг даалгаврыг бол хуулиар өгч байна гэж байгаа тээ? Тэгээд энэ уншаад харахаар болохоор цаанаа тухайн зээлдэгчийн болоод тухайн хувь хүний цахим шуудангийн хаягийг баталгаажуулсны дараагаар зээлдэгчтэй цахим зээлийн гэрээ байгуулна гэсэн ийм заалт тусгасан байна лээ. Тэгэхээр энэ нэмж байгаа яах вэ зээлдэгчийг баталгаажуулахыг бол хийгээд байгаа ер нь нөгөө банк ч болов уу банк бус санхүүгийн байгууллагууд. Энэ цахим шуудангийн хаягжуулалтын баталгаажуулалтыг хийх нь өөрөө цаанаа хэдий хэмжээний төсөв мөнгө шаардсан ямар хугацааны ажил болохуйц ажил байгаа вэ гэдэг дээр тодорхой судалгаа хийсэн зүйл байна уу? Ялангуяа энэ дээр бол бас Санхүүгийн зохицуулах хорооноос оролцож байгаа юм байна. Энэ тал дээр мэдээлэл цуглуулсан зүйл байна уу гэж асуух гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Тэмүүлэн сайд, дараа нь Санхүүгийн зохицуулах хорооноос асуулт асуучихлаа. Бэлтгэж байгаарай. Тэмүүлэн сайд хариулъя.

Г.Тэмүүлэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Тэгээд өнөөдөр үндсэндээ бид бүхний энэ оруулж ирж байгаа хуулийн нэмэлт, өөрчлөлт маань бол яг энэ 2024 оны 10 сараас хэрэгжсэн Хялбар ажиллагааны шүүхтэй холбоотойгоор яг шүүх дээр үүсэж байгаа ачаалал, хүндрэл, бэрхшээлийг, практик дээр үүсээд байгаа асуудлуудыг бол шийдвэрлэх зорилгын хүрээнд бол оруулж ирж байгаа ийм зохицуулалтууд. Тэгэхээр нэг талдаа бол энэ бид нар ямар шинэ харилцааг бол оруулж ирээгүй. Үндсэндээ одоогийн практик дээр үүсэж байгаа энэ асуудлыг шийдвэрлэх ийм зохицуулалт хүрээд байгаа юм.

Саяын Соронзонболд гишүүний хэлж байгаа энэ цахим залилан болоод цахим зээлтэй холбоотой асуудал бол нийт шүүхийн маргаан нэхэмжлэлийн бараг дийлэнх хувь нь гэдэг нь бол үнэн байгаа. Өнөөдөр үндсэндээ яг иргэний хэргийн нэхэмжлэл, маргааны бараг 80 орчим хувь нь бол банк, банк, санхүүгийн байгууллагын энэ нэхэмжлэл, маргаантай холбоотой асуудлууд байдаг. Энэ дотроо бүр энэ 80 хувь дотор нь аваад үзэх юм бол яг 70 хувь нь бол банк, санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой маргааны асуудлууд байгаад байгаа юм.

Үнийн дүн нь бол үндсэндээ их бага хэмжээний, дийлэнх 50 орчим хувь нь бол 3.5 сая төгрөгөөс доошоо хэмжээний зээлүүд байдаг. Тэгээд 53 хувь нь 3.5 саяас. Ингээд дийлэнх 80, 90 хувь нь бол 10 саяас доош хэмжээний ийм асуудлууд байгаад байгаа юм. Энэ дээр бид нарын хувьд яг тухайн тэр зээлдэгч буюу банк, санхүүгийн байгууллагуудыг тэр нь М банк байна уу, эсвэл та ямар аппликэйшн байна уу тухайн тэр аж ахуйн нэгж байгууллагыг бол тухайн зээлдүүлэгчээ урьдчилан баталгаажуулах үүргийг бол хуулираа зохицуулалт бий болгож өгч байгаагаараа онцлогтой байгаад байгаа юм.

Яагаад вэ гэхээр үндсэндээ нэх шүүх дээр ирж байгаа нэхэмжлэл гаргах болгонд хаяг нь олдохгүй гэдэг асуудлууд гарч ирдэг. Ингээд хаяг нь олдохгүйгээс болоод бид нар тухайн хүнийг нь тодруулах гэж шүүх маш олон процесс, үйл ажиллагаа, цаг хугацаа ордог. Ингээд эсвэл юу гэдэг юм магадгүй заримдаа залилангийн байдлаар өөр хүний нэрээр авсан ийм шалтгаантай асуудлууд байдаг. Тэгэхээр энэ эрсдэлтэй нөхцөл, байдлуудыг бол тухайн тэр зээлдэгч этгээд дээрээ бид нар үүрэг, хариуцлагаа бий болгоод хариуцлагатай байх зохицуулалтыг бас энд хийж өгөөд тухайн зээл олгох үедээ бол зээлдүүлэгч нь зээлдэгчийг өөрөө мөн эсэхийг баталгаажуулах зохицуулалтыг бас энэ хуулийн өөрчлөлтөөр бол оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр тэр тухайн тэр хувийнх нь, хувийн цахим шуудангийнх нь хаяг нь үнэн, зөв юм уу эсэхийг нь баталгаажуулах үүрэгтэй болно. Дээрээс нь иргэнийх нь үнэмлэхтэй зураг, эс үгүй бол түүнтэй адилтгах тэр мэдээлэл болоод цахим шуудангаар илгээсэн баталгаажуулах кодоор ингээд ашиглаж баталгаажуулдаг гэдэг юм уу. Ингээд энийгээ баталгаажуулсан хойноо бол нөгөө шүүхэд нэхэмжлэл, гомдлоо гаргахдаа тухайн тэр баталгаажуулсан мэдээллүүд, баримт, нотлох баримтуудаа бол заавал хавсаргах энэ үүргийг бол зохицуулж өгч байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ бид бүхний хувьд бол хялбаршуулсан горимоор, хялбар ажиллагааны шүүхээр тухайн энэ цахим зээлтэй холбоотой аппликэйшнтэй холбоотой асуудлуудыг бол түргэн шуурхай шийдвэрлээд байх боломж, бололцоо маань бол үүгээр бүрдэнэ гэж бол харж байгаа. Тэгээд ийм байдлаар бол энэ зохицуулалтуудыг хийсэн. Нэмээд ажлын хэсгээс бол бас яг тодорхой нөгөө тухайн зүйл, заалтынх нь яг нарийвчилсан зохицуулалтуудаар бас нэмж бас хариулж болно шүү.

Л.Мөнхбаатар: Санхүүгийн зохицуулах хороо хариулах уу? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгчихье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Б.Итгэлсүрэн: Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Итгэлсүрэн. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Банк бус санхүүгийн байгууллагууд аппликэйшнээр зээл олгохдоо бол уг нь харилцагчаа танин баталгаажуулалтыг бол өөрсдийн түвшинд хийж байгаа. Зарим нь Амазон гээд олон улсын зах зээл дээр гаргасан ийм компаниудын танин баталгаажуулалтыг хүртэл ашиглаад явж байгаа. Тэндээ тодорхой хэмжээний шимтгэлүүд төлж байгаа ийм тохиолдлууд ч байгаа. Тэгэхээр юу гэдэг юм хууль батлагдсанаараа энэ банк бус санхүүгийн байгууллагуудын тэр аппликэйшн рүү ОРТ код илгээгээд аваад явахад бол энэ нь бүрэн боломжтой. Илүү нөгөө харилцагчаа танин баталгаажуулалт дээр асуудал үүсэхгүй гэдгийг хэлье.

Тэгээд ер нь бол энэ манай дээр ирж байгаа энэ цахим зээлийн энэ залилантай холбоотой өргөдөл, гомдлуудыг харахаар дийлэнхдээ нөгөө иргэд маань өөрийн хувийн мэдээллээ алдчихдаг. Тэндээсээ дамжуулаад уг нь бол энэ цахим зээлийн ап…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг гүйцээгээд харуулчихъя. Итгэлсүрэн 1 дүгээр микрофоноо өгчих.

Б.Итгэлсүрэн: Тухайн иргэний арилжааны банканд байгаа нэр дээрх харилцах данс руу зээл нь мөнгөн хэлбэрээр орсноор, зээл олгосноор тооцогдоод явж байгаа. Тэгэхээр нөгөө энэ цахим залилан маань өөрөө давхар цаашаа арилжааны банкин дахь харилцах дансны мэдээллийг хүртэл авчихсан хэлбэрээр явж байгаа ийм кэйсүүд байгаа. Мөн ганц, нэг банк бус санхүүгийн байгууллагууд зээл аваад түүнийгээ цахим хэтэвч рүү хөрвүүлэх байдлаар зээлийг нь бусад ийм төлбөр, тооцоо гүйцэтгэх боломжийг олгож байсан. Энэ дээр бол бас ийм ганц нэг хүний нэрийг ашиглаад цахим мөнгө рүү шилжүүлээд, хэтэвч рүү шилжүүлээд бусдын гуравдагч этгээд рүү төлбөр, тооцоо гүйцэтгэсэн ийм ашиглангийн хэлбэрүүд бас гарсан ийм тохиолдлууд байж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Энэ бол яах вэ энэ аппликэйшн зээлтэй холбоотой хэсэг дээр л байна шүү дээ тэр? Тэгэхээр хялбаршуулах шүүх дээр шүүгч болон шүүгчийн туслахын хийгдэж байгаа ажил тийм үү процесс байгаа шүү дээ тэр ажлаас нь сайжруулж, хялбаршуулж байгаа, автоматжуулж байгаа ямар заалт орж байгаа вэ? Энэ өөрчлөлтөөр?

Л.Мөнхбаатар: Хэн Мөнх-Эрдэнэ хариулах уу? Ажлын хэсгийн 3 уу 4 үү? 4 дүгээр микрофоныг өгчихье.

Д.Мөнх-Эрдэнэ: Хууль зүй, дотоод хэрийн дэд сайд Мөнх-Эрдэнэ. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр, одоо байгаа хуулиар бол энэ шүүх, шүүхийн зүгээс бол тухайн зээлдэгч иргэний хаягаар, баталгаат шуудангаар эс үгүй бол шүүхийн ажилтнаар биечлэн хүргэдэг. Ингээд хаяг тодорхойгүй, оршин суудаггүй үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдийн албан ёсны хаягийг бол улсын бүртгэлээс тодруулж шүүх санаачилгаараа энэ тэр ирүүлсэн хаягийнхаа хаяг руу хүргүүлдэг.

Ингээд болохгүй бол E-Mongolia-д байгаа тухайн байгууллагын, тухайн байгууллага, иргэний албан ёсны цахим шуудангийн хаягаар хүргүүлж байгаа. Энэ бол өнөөдөр үйлчилж байгаа процесс. Бид нар шинээр юу оруулж ирж байгаа вэ гэхлээр ингээд ингээд энэ…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг гүйцээгээд хариулъя. 4 номерын микрофоныг өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Ингээд ингээд бол энэ нэхэмжлэл гардуулах ажиллагаа бол амжилтгүй болж байгаа. Үүний илрэл нь бол 2025 онд 51 мянган, 51038 нэхэмжлэл хүлээн авч, 28611 хэрэг шийдвэрлэснээс энэ шийдвэрлэгдэж байгаа хэргийн 9978 хэрэг буюу 34.9 хувь нь хариуцагч хаягтаа байхгүй гэдэг энэ үндэслэлээр хэрэгсэхгүй болж байгаа юм. Яг энэ үзүүлэлт 26 оны 09 сарын 30-ны байдлаар мөн энэ үзүүлэлт бол 8823 хэрэг буюу 24 хувь хүрч байгаа юм. Тэгэхлээр бид одоо ингэж цаашдаа энэ шүүхийн ажиллагаанд үр ашиггүй зардалтай ийм байдлыг халах зорилгоор шинэ оруулж ирж байгаа нэмэлт зохицуулалт бол түрүүний хэлсэн 3 ажиллагаа явсны дараа болохгүй бол тухайн шүүх өөрийн цахим хуудсан дээрээ энэ нийтэд ил тод нээлттэй мэдэгдсэнээр нэхэмжлэл, мэдэгдлийг гардуулсан гэж…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Яг энэ цахим гэмт хэрэг бол нэлээн дийлэнх хувийг эзэлж байгаа гэдэг нь үнэн. Ер нь ч өсөх хандлагатай. Сүүлийн КОВИД-оос хойш яг энэ цахимын тэсрэлт бол дундаж хурдаараа 1 жилд өмнөх КОВИД-ын өмнөх жилийн хурд нь 6-12 дахин өсчихсөн байгаа. Тэгээд энэтэй холбогдуулаад ер нь яг энэ цахим гэмт хэргийн залилангийн асуудал бол тодорхойлоход маш төвөгтэй, санкц буюу ямар нэгэн байдлаар зүйлчлэхэд маш их эрсдэлтэй болчихсон байгаа. Энэнтэй зэрэгцээд би би зүгээр танин мэдэхүйн зарчмын асуулт асуух гээд байгаа нь одоо хууль зүйн нэр томьёоны шинэ тутам үүсэж байгаа цахимтай холбоотой тэр тайлбар Abbreviation код гэж хэлдэг. Энэ товчлол гаргасан уу? Гаргасан бол ингэхдээ яаж гаргаж байгаа вэ? Төрийн хэлний зөвлөлтэй холбогдож энэ дээр тодорхойлолт авч байгаа юу? Шинжлэх ухааны академийн Хэлний зөвлөлтэй болон энэ их сургууль, институцүүдтэй холбогдож энэ чиглэлээр авч байгаа юу? Манайд болохлоор хуулийн бичилтийн хувьд бол сая жишээлбэл мопед гээд бичлээ гэхэд зарим нь яг кирилл галигаараа бичингүүт зарим нь бол скүүтер гэдгийг сая хуульд оруулахдаа дуудлагаараа галиглачихсан оруулчхаж байгаа юм. Хэрвээ кириллээр галиглана гэвэл “Ү” үсэг байхгүй байх жишээтэй. Тэгэнгүүт бид нар яаж байна гэхлээрээ хууль зүйн хувьд ингээд өөр өөр журмаар галиглаад явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ тохиолдолд яаж байна гэхлээрээ жишээлбэл бид нар аппликэйшн гэж ярьж байгаа цахим хэрэглэгдэхүүнийг гэх мэтээр яг энэ уг нь бол тэр Баатархүү, Батшугар нарыг Цахимын сайд байхад нь энэ талаар бол зөндөө хэлж байсан.

Өөрөөр хэлбэл, цахимтай холбоотой нэр томьёоны хууль зүйн яг тайлбар гараад тэн дээрээс нь үндэслэж Улсын дээд шүүхээс тухайн хуулийг яаж хэрэглэхтэй холбоотой тайлбар гарах ёстой байгаа. Тэгэхээр энэ процесс энэ хуулийн үзэл санаатай явж байгаа юу? Явж байгаа бол ямар түвшинд явж байгаа вэ? Яваагүй бол яагаад явахгүй байна вэ гэдэг асуулт Хууль зүйн яамнаас асууя.

Л.Мөнхбаатар: Хууль зүй, дотоод хэрийн дэд сайд Мөнх-Эрдэнэ хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Энэ хууль зүйн нэр томьёотой холбоотой асуудлаар албан ёсны тодорхойлолт тайлбар гаргаж байгаа субъект бол манай Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр хууль зүйн нэр, томьёоны зөвлөл ажилладаг. Энийг бол Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал толгойлж бас холбогдох эрдэмтэн мэргэд энэ бүрэлдэхүүнд нь орж ажилладаг ийм бүтэц байгаа. Яг энэ манай энэ аппликэйшний зээл гэж би яриад байгаа энэ асуудал бол бид бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт бол тогтоод хэлбэржчихлээ. Энэ бол нөгөө цахим хэлбэрээр олгосон зээл гэсэн нэр томьёо ингээд яваад байгаа. Бид энгийн яриан дээрээ бол аппликэйшний зээл гэж яриад байгаа боловч хууль дээрээ бол цахим хэлбэрээр олгосон зээл гэж ингэж томьёолж ингэж хэрэглээд практикт тогтчихож байгаа юм. Тийм.

Л.Мөнхбаатар: Тодруулъя. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Тийм ер нь бол цахим, дижитал, кибер гээд ингээд 3 үгийг 3 өөр янзаар ойлгоод яваад байгаа юм л даа. Тэгэхээр ер нь бол энэ хуульч бай ер нь цаашлаад яг энэ нэгэнт шинэ тутам энэ цахимжилтаас үүдэлтэй нийгмийн харилцаа чинь өөрөө маш нарийн ээдрээ төвөгтэй болж байгаа энэ үед бид нар энэ асуудлаа нэг мөр явах ёстой. Тэгэхээр ер нь бол Засгийн газар, Хуулийн яам энэ дээр ингээд санаачилга гаргаад Хэрэг эрхлэх дээр ч гэдэг юм уу яг энэ чиглэлийн ийм тайлбарыг зайлшгүй хийх зайлшгүй шаардлагатай болчхоод байгаа юм. Одоо энэ цахимаар бол хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл худалдаалах асуудал маш хүнд болчихсон байна. Маш олон үелзэл энэ дотор чинь явж байгаа үед энийгээ бол Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэмжээнд биш төрийн хэлний зөвлөлийн хэмжээнд, институцүүдийн хэмжээнд хэлэлцүүлэг хийгээд нэг мөр тогтох ёстой. Жил 6 сарын өмнө AI гэдэг үгийг бид нар “хиймэл оюун ухаан” гэдгийг “хиймэл оюун” болгосон. Одоогоороо хүртэл зарим газар бүтээмэл оюун гэсэн хэрэглэгдэхүүн яваад байгаа. Одоо дахиад зовлон байгаа нь…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тодруулж асууя Эрдэнэболд гишүүн 1 минут дэмжье.

С.Эрдэнэболд: Одоо та бүхэн мэдэж байгаа шүү дээ 24 оны сонгуулийн өмнө дуулиан шуугиантайгаар 2 хүний хоорондын viber-ыг манай цагдаагийн газар гэмт хэргийн юу болгоод, нотлох баримт болгоод олон нийтэд гаргаад тухайн хүмүүсийг баривчлах тухай ингээд сүр дуулиантайгаар гаргаж байсан. Одоо манай Улсын Их Хурлын гишүүдийн бүх зар, мэдээлэл viber чатаар явж байгаа. Бүүр хэдэн хувийг нь юм мэдэхгүй. Тэгэхээр үндсэндээ бол бид нарт яг албан ёсны төрийн дархлаатай нууцад хадгалсан ийм зүйл байхгүй байгаа. Тэгэхээр энэ бас Хуулийн яам энэ дээр анхаармаар байгаа юм. Бид нар ингээд дотоод аюулгүй байдлаа яаж хангах юм? Захын аппликэйшн буюу тэр цахим хэрэглэх юмнуудыг чинь задлаад уншчихаж байна шүү дээ. Тэгээд тэр дээр жишээлбэл photoshop-оор хуучин хийдэг байсан бол одоо хиймэл оюунаар энэ асуудлыг чинь хийгээд л хүнийг set up буюу зохиомол хэрэгт оролцуулах бүрэн боломжтой бүрэн боломжтой болчихсон. Яг энэ шиг ямар нэгэн байдлаар хүн хорлох гээд яг энэ нөгөө цахим байдлаар хэлцэл хийсэн байдлаар set up хийчихвэл яах вэ? Тэр гэх мэт асуудлуудыг энэ хуулийнхаа бас юунд магадлалтай…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Буяагийн Тулга асуултаа асууя.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхлээр хэлэлцэгдэж байгаа хуультай холбоотойгоор энэ харилцагч, нэхэмжлэгчийн хоорондох харилцааг илүү түргэн шуурхай ач холбогдол багатай шийдэх ийм практик нөхцөл байдлаас энэ хуулийг бас нэмэлтийг оруулж ирж байна гэж ойлгож байна. Энэ хүрээнд 2 асуулт байна. Нэгдүгээрт танилцуулгад дурдагдсан байгаа үндэсний цахим шуудан гэдгийг тодорхойлолтыг маш ойлгомжтой болгож өгөөч. Нэг.

Нэхэмжлэгчийг олох асуудал хүндрэлтэй байгаа, энийг шийдэх гэж байгаа гээд шийдэл танилцуулсан байна. Энэ шийдэл дээр бол яах вэ эхлээд шуудангаар хүргэх, дараа нь биечлэн хүнээр хүргэх, тэгээд болохгүй бол нөгөө үндэсний цахим шуудан гээд байгаа юм үүгээр хүргэх гэсэн ийм зүйл ярьж байна л даа. Тэгэхлээр энэ маань яг шийдлийн хувьд хэр зөв шийдэл бол? Хэрвээ нэгэнт л нэхэмжлэгчээ олж чадахгүй бол шүүх дээр шийдвэр гарсан ч гэсэн тэр хохирлыг

олдохгүй байгаа нэхэмжлэгчээс яаж нөхөж олж авах вэ гэдэг чинь асуудалтай шүү дээ. Тийм учраас шүүх хурал явж л байгаа тохиолдолд нэхэмжлэгч бол заавал ч үгүй тэнд биеэр гэдэг юм уу, төлөөнийх нь өмгөөлөгч байдаг юм уу хууль, эрх зүйн хувьд байж байх ёстой гэдэг ийм зүгээр болгоомжлол гэдэг юм уу ойлголт байна. Тэгэхлээр бас та бүхэн бас энийг яг тэр одоо тохиолдож байгаа практик талаасаа дээр нь энэ шийдэл маань яг 100 хувь байж чадах уу, үгүй юү? Энэнээс улбаалаад юу гэхлээр нэхэмжлэлийг 7 хоногийн өмнө тэр цахим шуудангаар ч юм уу хүргүүлчихсэн гээд баахан хүн дээр хохирол тооцоод явуулаад байдаг. Тэгээд нөгөө хүн нь ч мэддэггүй ямар яг ний нуугүй хэлэхэд бүх хүн И-Монгол руу ороод мэдээлэл авч байгаа нь юу л бол. Тэгэхдээ зүгээр энэ ханд явж байгаа чиглэл бол зөв байх. Тэгэхдээ энийг бас давхар яаж тооцож байна? Энэ дунд баахан нугалаа гарч эргээд нөгөө энэ хууль дээр ийм заачихсан учраас бид нар шийдчихсэн юм гээд ингээд баахан хохирол нөгөө талдаа гарах вий гэдэг ийм болгоомжлол байна.

Хоёрдугаарт нь энэ нэгэнт ажиллагааг хөнгөвчилж байгаа гэж үзэж байгаа. Тэгэхлээр энэ дээр энэ хууль гарснаар өнөөдөр мөрдөгдөж байгаа энэ төсөв дээр өгч байгаа ачаалал хэчнээн хувиар, хэд дахин, ямар хэмжээгээр буурч байна санхүү талаасаа? Шүүгч дээр ирж байгаа ачаалал бол тусдаа байгаа байх. Ажиллаж байгаа цаг маг гээд. Яг санхүү талаасаа бас хийсэн тооцоолол та бүхэнд байна уу? Энийгээ танилцуулж яриач гэж хүсэж байна. 2 асуулт.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн сайд хариулъя.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүний асуултад хариулъя Тэгэхээр бид бүхний саяын нөгөө энэ цахим баталгаажуулалттай холбоотой, мэдэгдэх хуудсыг хүргүүлэх ажиллагааг илүү шат дараатай цахим хэлбэртэй болгох гэж байгаа энэ зохицуулалт маань бол үндсэндээ бид бүхэн ямар байдлаар нөгөө хариуцагч болоод оролцогчийн хаяг нь тодорхойгүй, эсвэл мэдэгдэх хуудас гардуулах боломжгүй тохиолдолд бол энд шинэ харилцааг бол оруулж ирж байгаа нь шүүх өөрөө тэндээсээ шүүхийнхээ веб сайтаараа, цахим хуудсаараа нийтэд зарлан мэдэгдсэнд тооцох энэ зохицуулалтыг бол бас хийж байгаагаараа бас онцлогтой болж гарч ирж таарч байгаа.

Тэгээд энэ бол манайхан бас судалж үзээд яг үндсэндээ олон улсын эрх зүйн практик дээрээ бол энэ түгээмэл хэрэгждэг ийм жишиг байна. Тэгэхээр бол ямар байдлаар боломжит бүх аргаар гардуулах оролдлого хийгээд ингээд боломжгүй тохиолдолд бол шүүх өөрөө бол энийгээ бас нийтэд зарлаад гардуулах гэдэг юм уу тэрийг хүлээн авсанд тооцох гэдэг юм уу энэ зохицуулалт бол өөрөө байдаг юм байна эсэн үндсэн дээр хийсэн. Гэхдээ энэ үндсэндээ зөвхөн яг нөгөө хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хэрэг дээр бол ингэж байгаа асуудал байгаад байгаа юм. Нийт манай энэ хялбаршуулсан горимоор шийдэгдэж байгаа хэргүүдийн маань бол бараг 60 орчим хувь нь бол ямар байдлаар шүүх хурал болохгүйгээр, илт нотлох баримтууд нь ойлгомжтой, түргэн шуурхай шийдвэрлэх боломжтой ийм асуудлууд байдаг учраас ингээд шийддэг ийм хэргүүд бол байдаг.

Тэгэхээр бид яг саяын тэр саяын зохицуулалтын харилцаа маань бол үндсэндээ ингээд яг тэр цахим системд байршуулаад ингээд тэнд зар нийтлэгдсэнээс хойш 1 сарын дараа бол гардуулсанд тооцдог ийм процессыг бол бас нэмж өгч байгаагаар бол онцлог байгаад байгаа юм. Тэгэхээр сар гэж байгаа, 7 хоног. Манайхан бас нэмээд яагаарай.

Ер нь бид бүхний хувьд ингэж байж яг нөгөө шүүхийн ачааллыг өөрөө бууруулахгүй бол юу болж байна вэ гээд аваад үзэхээр нийт 2025 оны тоогоор аваад үзэх юм бол үндсэндээ улсын хэмжээнд 113-аас 15 мянган хэрэг бол нэхэмжлэл шүүхэд бол хандсан байдаг. Үүний 84 хувь нь буюу дийлэнх хувь нь буюу 95.4 мянга нь бол иргэний шүүх дээр бол хамгийн гол ачаалал ирж байгаа. Бусад эрүү дээр бол 15, 6 мянга байхад захиргаан дээр 2.1 байхад иргэний шүүх дээр ирж байгаа ачаалал бол үндсэндээ нийт бүх ачааллын 80, 90 хувийг авдаг. Энэ дээр гол ачаалал асуудлууд маань бол саяын л тэр хаяг тодорхойгүй, мэдэгдэх хуудас хүргэх боломжгүй, түүнээс гараад тодорхой цахим залилантай холбоотой зээлдэгчийг баталгаажуулах боломжгүй, мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн эсэхэд хүндрэл үүсээд цаг хугацаа авдаг хэрэг удааширдаг. Ингээд улмаар том зургаар бол төрд бол шүүхэд итгэх иргэдийн итгэл өөрөө буурдаг энэ асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар нэг талдаа хялбаршуулсан ажиллагааны, хялбар ажиллагааны шүүхийн асуудлыг бол түргэн шуурхай шийдвэрлэх, ингээд цаг хугацааны хувьд богино болоод ингээд энгийн, ойлгомжтой энэ асуудлуудыг бол ингээд шийдвэрлээд явах нь бол зүйтэй юм гэсэн энэ хүрээндээ бол саяын тэр мэдэгдсэнд тооцох энэ зохицуулалтыг бас оруулж ирж байгаа ийм онцлогтой байгаа.

Нэмээд саяын тэр хугацаатай холбоотой дээр бас манайхан маань нэмээд хэлээрэй санхүүгийн талаас нь бас. Санхүүгийн зохицуулах хороо шүүх дээр тооцоолол хийсэн байгаа байх ачааллын талаар.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн сайд ч сая бараг тодорхой хариулчихлаа даа. Нэмж хариулт авах юм уу? Тулга гишүүн юу яачихъя тодруулчих. Тэрэнд нь хариулчихъя ажлын хэсэг.

Б.Тулга: Тийм 2 асуулт асуусан л даа. Нэг нь бол яах вэ энэ оруулж ирж байгаа, шийдэл болгож оруулж ирж байна шүү дээ нэхэмжлэл олдохгүй тохиолдолд яаж шийдэх вэ? Тэгэхлээр нөгөө нэгэнт нэхэмжлэгч олдоогүй тохиолдолд шүүх нь шийдчихдэг. Яагаад гэвэл энэ чинь хялбар явуулах гээд байгаа шүү дээ. Хялбар явуулна гэдэг чинь 2 талаасаа ойлголцоод л ингээд тохиръё, ингээд асуудлаа шийдье гээд явах ёстой байтал нэг талд нь хүргэлгүйгээр хялбаршуулсан зарлачихсан учраас ирэхгүй байсан ч асуудлыг нь шийдчихдэг. Тэгээд нөгөө нэхэмжлэл авч байгаа юу гэдэг юм нөхөр нь буцаагаад шүүхдээд ингээд бүүр дахиад шүүхийн чинь ачааллыг нэг биш дахиад бүүр ихэсгэх юм биш биз дээ гэж би болгоомжилж байгаа юм зүгээр. Шийдэл тал дээрээсээ харж байгаа юм.

Хоёрт нь энэ нэгэнт л уг нь шүүх шийдэж байгаа бол аль аль заавал ч үгүй олж ирж байж байж шийдэх ёстой гэдэг л юм яриад байна л даа. Хоёр дахь нь бол энийг, энэ хуулийг оруулснаараа ер нь аль ч хуулийг батлахад хэдүүлээ төсөв мөнгийг нь шийдэж өгөхгүйгээр явдаггүй. Манайх муу юм бол хууль батлаад хаячихдаг. Төсөв нь байхгүй учраас хуульд хэрэгждэггүй. Хуультай ч юм шиг, хуульгүй ч юм шиг, мөрдүүлэх ч юм шиг, үгүй ч юм шиг ингээд ийм нөхцөл байдал нэлээн…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тулга гишүүн. Тулга гишүүн гүйцээгээд асуучихъя.

Б.Тулга: Тийм учраас энэ дээр энэ улсын төсөв дээр гэдэг юм уу, санхүү талаасаа эрх ачаалал хэдэн хувиар буурч байгаа вэ гэдэг асуудал дээр хууль санаачлагч нар хариулт өгөөч л гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Хууль зүй, дотоод хэрийн дэд сайд Мөнх-Эрдэнэ хариулъя.

Д.Мөнх-Эрдэнэ: Тулга гишүүний асуултад хариулъя. Таны бас болгоомжлол бас байгааг ойлгож байна. Гэхдээ ер нь өнөөдөр байгаа процессыг бас би танд танилцуулъя. 2026 оны байдлаар хэлбэр ажиллагааны шүүхээс шийдсэн 36765 хэргээс 4412 буюу хэрэг буюу 12 хувийг бол шүүх хуралдаанаар шийдсэн. Өөрөөр хэлбэл хариуцагч өөрөө шүүх хуралдаанд оролцсон гэсэн үг. Үүнээс шүүх хуралдаангүйгээр буюу зохигчид эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн гэх мэт шалтгаанаар 23530 хэрэг буюу 64 хувь нь, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн буюу нөгөө хаяг тодорхойгүй гээд байгаа энэ нэхэмжлэлийг гардуулж чадаагүй гэсэн энэ шалтгаанаар бол 8823 буюу 24. Тэгэхлээр ерөнхийдөө бол энэ хялбар ажиллагааны шүүх үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь жил 10 сарын хугацаанд харахад бол…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг гүйцээгээд хариулъя. 4 номерын микрофон өгчихье.

Д.Мөнх-Эрдэнэ: Энэ нөгөө шүүх хуралдаанаар буюу нөгөө хариуцагчийг шүүх хуралдаанд оролцуулдаг, зохигчид эвлэрсэн энэ хялбаршуулсан журмаар хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа энэ өсөөд байгаа. Өөрөөр хэлбэл шүүхийн ажиллагаа үр дүнгээ өгч байна гэсэн үг. Бид одоо юун дээрээ анхаарах ёстой байгаа гэхлээр энэ гардуулж чадахгүй байгаа, мэдэгдлээ гардуулж өгч чадахгүй байгаа энэ асуудлыг шийдэхийн тулд нэг асуудал орж ирж байгаа нь зээл олголт олгож байгаа бол зээлдүүлэгчийн үүргийг тодорхой хуульчилж өгч байгаа. Тэр нь олгож байгаа, авч байгаа зээлдэгчийг энэ зээлдүүлэгч өөрөө маш сайн баталгаажуулах ёстой нэгдүгээрт.

Хоёрдугаарт цахим шуудангийн хаягийг нь баталгаажуулах ёстой. Үүний дараа бид нэг юм оруулж ирж байгаа нь нийт хэрэг маргааныг чинь 80 орчим хувь байгаа энэ аппликэйшний гээд байгаа цахим зээлийн тэр баталгаажуулсан цахим шуудангаар нь тэр нэхэмжлэлийг, мэдэгдлийг хүргүүлснээр энэ гар тусад нь тооцох ийм шинэ зохицуулалт оруулж ирж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Мөнх-Эрдэнэ дэд сайд тэр цахим хаягийг л яагаад байна л даа. Үндэсний цахим шуудан гэж байна. Тэр дээр сая яриад байгаа нь бас тухайн зээл авахдаа ч юм уу бөглөсөн тэр цахим шуудангийн хаягийг хэлж байна уу, и-мэйл хаяг? Энэ асуудлаа бас нэг мөр болгож нэгдсэн ойлголттой болгох зайлшгүй шаардлага байгаад байна шүү дээ? Тэрийг энэ Тулга гишүүн бас асуугаад байх шиг байна. Нэг.

Хоёр дахь нь бол энэ хэрэг, маргааныг ер нь хянан шийдвэрлэх процессын үйл ажиллагаанд оролцогчдын эрхийг нь хэрхэн хангах вэ л гэж бас асуугаад байна л даа. Энэ чинь 2 талтай л зүйл шүү дээ. Хариуцагч байхгүй эрүүгээс бусад хэрэг дээр бол хариуцагч байхгүй байсан ч гэсэн шийдвэрлэх тийм тохиолдлууд олон гарч байгаа шүү дээ. Энэ чиглэлээр нь асуугаад байх шиг байна. Энэ дээр нь яг нийлүүлээд тодорхой хариулт өгчих та. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: E-Mongolia дээр байгаа иргэний цахим хаягийн хувьд бол нэг асуудал үүсээд байгаа нь нэхэмжлэлийг тэр и-мэйлээр тэр чинь нэлээн олон хуудас зарим тохиолдолд нэхэмжлэл байгаа. Тэгээд тэр тохиолдолд бас upload хийж ингээд явахад бас хүндрэл учраад байгаа юм байна лээ. Тийм учраас бид нарын бас нэг хувилбар гаргаж ирж байгаа зохицуулалт нь угаасаа энэ зээлдэгч зээл авахдаа цахим хэлбэрээр л хандаж байгаа. Тэгэхлээр энэ хүний зээл авч, зээлдэгчийн албан ёсны цахим хаяг нь өөрийнх нь харьцдаг хаяг нь аль нь юм бэ гэдгийг нь баталгаажуулж өгч байгаа. Энэ хаягаар л энэ хүнтэй харьцана. Энэ иргэн өөрөө зээлдэгч Мөнх-Эрдэнэ мөн үү гэдгийг тэр нөгөө өөр иргэний иргэний үнэмлэх ашиглаад байгаа учраас иргэний үнэмлэхийг нь хажууд нь барьж байгаад баталгаажуулдаг ийм сайн практик бас байгаад байгаа юм. Тэгэхлээр зээлдэгч зээлдүүлэгч хэрвээ хариуцлага…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гэхдээ Мөнх-Эрдэнэ дэд сайд ийм асуудал гарах байх. Ингээд хэргийг хялбаршуулан шийдэхэд та бүхэн бас яг практик дээр учраад байгаа нөхцөл байдлаа үнэлж үзээд нэхэмжлэгчдийн ихэнх эрх хангагдахгүй шүү дээ. Цахим шуудан чинь цахим шуудангаар л өгөхгүй бол биечлэн хүргэлт маань ерөнхийдөө 80 гаруй хувь нь, 86 хувь нь үр дүнгүй болж байна гэж байна шүү дээ. Тийм учраас цахим шуудангийн энэ механизмыг та нар сонгож авъя гэж байна. Энэ хялбаршуулахад зөвхөн ингээд ашиглагдаад явах уу? Энэ өөрөө энэ өөрөө концепцын шинжтэй том өөрчлөлт учраас иргэний ердийн журмаар шийдэж байгаа бусад хэргүүд байна шүү дээ иргэний нэр төртэй холбоотой ч байдаг юм уу, бусад энэ олон асуудал дээр яг адилхан яг энэ журам үйлчлэх үү гэдэг энэ зүйлийг ер нь та бүхэн яаж харж байгаа вэ манай хууль санаачлагч нар? 4 номерын микрофон өгчихье.

Д.Мөнх-Эрдэнэ: Мөнхбаатар даргын асуултад хариулъя. Энэ өөрчлөлт бол эхний ээлжид бол хялбаршуулсан шүүхийн ажиллагаанд хүрээнд хэрэглэгдэнэ. Бид ер нь Хууль зүй, дотоод хэрийн сайдын тушаалаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулаад ажиллаж байгаа. Шүүгч нар, өмгөөлөгч нар, Хуульчдын холбоо, их сургуулийн профессор, багш нар оролцсон. Тэгээд энэ хүрээндээ энэ иргэний шүүхийн процессыг яаж хүндрэл, чирэгдэл багатай түргэн шуурхай явуулах боломжийг бүрдүүлэх вэ гэдэг асуудлын хүрээнд таны саяын асуусан асуудлыг бид судалж үзье гэж хэлье.

Л.Мөнхбаатар: Дараагийн гишүүн асуултаа асууя. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ манайхан нөгөө ярихдаа цахим залилан, цахим зээл жоохон хольж яриад байна. Сайд маань ч бас тэр талаар асуудал хөндөөд байх шиг байна. Энэ цахим залилан бол Эрүүгийн хуулиар хамгаалагддаг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг учраас энэ их өөр хуулиар зохицуулагдана. Тэгээд энэ дээр бас арга хэмжээ авах шаардлагатай байгаа шүү. Тэгээд ер нь яамнаас энэ зүг рүү чиглүүлж байгаа ажил байна уу үгүй юу? Эхний асуулт.

Дараа нь үндсэн хуулийн төсөлдөө оръё. Шүүхийн ачаалал бол үндсэндээ асар ихэсчхээд байгаа юм. Шүүхээр явдаг хүн болгон ер нь ойлгоно. Юу гэсэн үг вэ 1 шүүгчийн ачаалал 4 аравны хэд дахин нэмэгдэнэ гэдэг чинь бүр аймшигтай тоо байхгүй. Бүр ямар ч ажил мэргэжлийн өөр хүн бол энэ чинь ойлгохооргүй, барахааргүй physically бүр дийлэхгүй тоо болчхоод байгаа байхгүй юу? Тэгэхээр

бид бол энийг бол яаралтай батлах нь зөв өө. Тэгэхдээ хэд хэдэн яг гол асуултууд байна.

Нэгдүгээрт яг энэ хялбар ажиллагааны шүүх дээр өнөөдөр шүүн таслах үйл ажиллагаа явуулж байгаа шүүгчид дунд хэлэлцүүлэг, шүүхээс бол санал авч байгааг ойлгож ойлгож байгаа Шүүхийн ерөнхий зөвлөлөөс. Энэ чинь бол яг уулзаж ярилцаж үзсэн үү? Санал нь хэр туссан бэ?

Хоёр. Энэ хэргийг ердийн шүүхэд шилжүүлэх зохицуулалт байна шүү дээ. Тэгэхээр энэ хэргийг Хялбар ажиллагааны шүүхээс тэр 75-ын штрих 7.1-ээр, 7.1.1 дээр юм шиг байна. Тэгээд энэ 75-ын штрих 1 дүгээр зүйлд заасныг зөрчсөн бол ердийн шүүхэд шилжүүлэхээр байна. Энэ ингээд хавтгайраад ачааллаа багасгах автомат хэрэгсэл болчих вий дээ. Одоо ер нь шүүгч нар бол ерөөсөө өөрийнхөө өрсөлдөх ажлын ачааллыг багасгахын тулд хэрэг үүсгэхгүй байх ийм тохиолдлууд их гардаг шүү. Энэ ингээд хэтэрхий өргөн болоод хэрэглэгдээд байх вий. Энэ эрсдэл юу гэж үзэж байна?

Дараа нь энэ баталгаажуулах дээр ийм тайлбар хийсэн юм байна. Иргэний үнэмлэхийнхээ зургийг бариад зургаа авхуулна гэж байна. Тэгээд цахижина гэж ер нь баталгаажуулах арга бол их олон байгаа шүү. Түрүүн бол тэр Санхүүгийн зохицуулах хорооноос ярьж байна гаднын сайтуудаар ороод судалгаа хийхэд PayPal ч байдаг юм уу баталгаажуулах олон арга хэрэгсэл байгаа. Бид ингээд яг хоёрхныг нь ингээд оруулах нь хэт явцууруулчих юм биш байгаа баталгаажуулахаа. Өөр арга, хэлбэрүүдийг нь арай явцууруулчихгүй юу гэдэг ийм асуулт.

Дараа нь тэр 75 штрих 3.1. Тэр баталгаат шуудан буюу шүүхийн ажилтан гэж байгаа юм. Тэгээд энэ дээрээ нэмээд хэрвээ мэйлээр хүлээж авсныгаа нотолчихвол заавал бичиг хэрэгч явуулахгүй байх, үндсэн бид нарын хүргэж байгаа зохицуулалт байна шүү дээ. Энийгээ жоохон өргөтгөөд цахим шуудангаар явуулаад, утсаар яриад би цахим шуудангаа хүлээгээд авчихсан гэдэг ч юм уу, өөрөө цахим шууданд хариу биччихвэл заавал явуулахгүй байх энэ боломж бололцоо нь байгаа билүү? Бид нар ингэж өргөсгөх билүү? Ер нь бид нарын нэн даруй халбал зохих зүйл бол тэр манайхан тоглоод “би икс” гэдэг юм даа тэр бичиг хэрэгч гэж ёстой хэдэн зуун цаастай зовчихсон хүний ажил байгаа шүү. Тэр хүний ажлыг л ер нь яаж багасгах вэ? Би асуулт дээр минутыг нь нэмээд авчихъя дарга. Дараа нь энэ хэдүүлээ…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Алтангэрэл гишүүнд 1 минут.

О.Алтангэрэл: Энэ зээлийнхээ хэлбэрээр нь ярих уу, зориулалт хэмжээгээр нь ярих уу гэдэг дээр түрүүн нэр томьёо дээр яг тодорхой болгохгүй бол өнөөдөр малчин хүн Хаан банкнаас зээл авахдаа аппликэйшнээр авдаг болчихсон шүү дээ. Түрүүнд нь нөгөө бүрдүүлсэн материал, малын тоо дансаа авчихсан учраас. Тэгэхээр энэ өөрөө дахиад бас их цахим, өөрөөр хэлэх юм бол хэлбэрийн байх уу, зориулалтаар нь байх уу, хэмжээгээр нь байх уу гэдгийг хэдүүлээ нэр томьёоны хувьд ялгахгүй бол маш их зүйлүүд яваандаа ер нь дийлэнх юм цахим хэлбэр рүү ер нь орохоор байна.

Жирийн иргэд ч гэсэн зээлийн аппликэйшнээс гадна банкны аппликэйшнээ ашиглаад зээл авч болж байгаа тээ. Тэгэхээр нэр томьёоны хувьд тэр тэр дээр бас анхаараарай гэж хэлье. Тэгээд энэ асуултууд дээр тодорхой хариулт тавья.

Л.Мөнхбаатар: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Тэмүүлэн сайд. Дараа нь ажлын хэсэг нэмж хариулж болно.

Г.Тэмүүлэн: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үндсэндээ яг манай энэ иргэний хэрэг дээр бас иргэний шүүх дээр шийдэгдэж байгаа энэ хэргийн ачаалал бол үндсэндээ бас асар их байгаа. Гэхдээ яг одоогийн байдлаар бол шүүх хуралгүйгээр шийдэж байгаа, нотлох баримтууд нь илүү ойлгомжтой, цаг хугацааны хувьд ингээд үргэлжилсэн байдлаар шууд шийдчихээр энэ хэргүүд нь бол дийлэнх хувийг нь бол эзэлж байгаа. Тэгээд нийт энэ нэхэмжлэл болоод энэ хэргийн маань бол 64 хувь нь бол ямар шүүх хуралгүйгээр шууд шийдэгдэж байгаа ийм асуудлууд бол байгаа.

Саяын нөгөө бичиг хэрэг гэдэг юм уу, яг нөгөө бичиг хүргэгч гээд нийслэлийн энэ 6 дүүрэг дээр үндсэндээ яг 6 бичиг хүргэгч л байгаад байгаа юм. Тэгээд энэ хүмүүс маань бол дүүрэг дүүрэгт яг ингээд 1 бичиг хүргэгч ажилладаг. Ингээд нөгөө материалыг нь аваачаад хүргэхээр үр дүн нь бол бараг ингээд 85 хувь нь бараг шахуу амжилтгүй болчхоод байдаг. Гэртээ хүн нь байдаггүй, эсвэл хаягт бүртгэлгүй, оршин суудаггүй ч гэдэг юм уу, ингээд буруу хаяг байдаг ч гэдэг юм уу энэ шалтгаанаас үндэслээд бол ямар ч үйл ажиллагаа бол хангалтгүй болчхоод байгаа. Тэгээд бид нарын хувьд бол яах энд оруулж ирж байгаа шинээр яг л энэ цахим хаягаар нь гэдэг юм уу, цахимаар нь авбал биетээр нь явуулахгүй байх ч гэдэг юм уу энэ зохицуулалтуудыг бас ингэж гаргаж өгч байгаагаараа шинээр бас цахимаар, эсвэл шүүхийн тэр цахим хуудсан дээр зарлан мэдэгдсэнээрээ бас тэрийг мэдэгдсэнд тооцдог. Энэ зохицуулалт бас орж ирж байгаагаараа бол илүү түргэн шуурхай, цаг үеийнхээ нөхцөл байдалд нийцүүлж бас энэ цахим хэлбэртэй болгож байгаагаар бол бас шинэлэг гэж л үзэж байгаа.

Бусад нь ердийн шүүх рүү шилжүүлэх гээд. Энэ үндсэндээ яг бид нар сая л нөгөө тухайн тэр нотлох баримтыг нь бүрдүүлэх, эсвэл үнэлэх ажиллагааг нь хялбаршуулж юу гэдэг юм ердийн ажиллагааны хүндрүүлсэн хэлбэрүүдээс чөлөөлсөн ийм асуудлууд ерөөсөө бүгдээрээ хялбар ажиллагааны шүүхээр ингээд явж байгаа. Тэгэхээр ямар нэг байдлаар харьцангуй энэ нөгөө явцын дунд анхнаасаа буруу хэрэг хялбаршуулсан горимоор орж ирээд тэр нь юу гэдэг юм яг шүүгч дээр очоод энэ нь бол юу нь буруу байх юм бол, харьяалал нь буруу байх юм бол зөв шүүх рүү нь бол шилжүүлэх энэ процессыг бол нэмж оруулж ирж байгаагаараа бас нэг талдаа иргэн дахин 2 удаа нэхэмжлэл гаргахаас 28 3 шат дамжлагаар дахиж явахаас бол сэргийлж, илүү процессыг илүү тодорхой болгож байгаа, харьяаллынхаа дагуу шуурхай шууд шийдвэрлэх эний процесс орж ирж байгаа юм.

Тэгэхээр бусад юун дээр бол харьцангуй тэр ердийн шүүх рүү шууд шилжүүлнэ ч гэдэг юм уу тийм практик бол байхгүй байх. Бид нарын нөгөө хялбар ажиллагааны шүүхийн маань үндсэн зарчим маань хуулиараа бол тодорхой болчихсон, тодорхой ямар нэг гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах ч гэдэг юм уу, эсвэл дундын өмчийн ашиглалт, засвар, үйлчилгээний зардалтай холбогдсон төлбөр, нэхэмжлэлийг гаргуулах, утасны төлбөр, эсвэл СӨХ-ын төлбөр ч гэдэг юм

уу ойлгомжтой энэ асуудлууд бол ингээд яг энгийнээр нь шийдэгдээд явах ийм зохицуулалтууд гарч ирж.

Эндээс харин зүгээр нэг зүйлийг анхааруулж та бүхэнд бас мэдээлэл болгоод хэлэх нь бид нар энэ хялбар ажиллагааны шүүхээр шийдэгдэхгүйгээр бас гацаж байгаа нэг зүйл бол байгаа нь энэ хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах асуудлыг бол хасаж байгаа.

Яагаад гэхээр энэ хөдөлмөрийн гэрээтэй холбоотой маргаан маань бол үндсэндээ хялбар ажиллагаа бас биш болчхоод байна Шүүх дээр очихоор маш их юу гэдэг юм нотлох баримт дахиад нэмэлт шаардагддаг, нэхэмжлэл, гомдлууд нэмэлтээр үүсдэг. Тухайн тэр хохирогч болоод хөдөлмөрийн маргааны этгээдүүд хоорондоо заавал ч үгүй байх ёстой байдаг ч гэдэг юм уу ийм нэлээн маргаантай асуудал учраас энийг бол ердийн хуримаар бол шийдэх нь зүйтэй гэсэн байдлаар энэ хуулийн төсөл дээр бас ингээд оруулж ирсэн байгаа.

Нэмэлтээр манай бас ажлын хэсгийнхэн маань нэмээд Алтангэрэл сайдын асуултад хариулъя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хэн хариулах вэ? Сая одоо энэ оруулж ирж байгаа хэд хэдэн зүйлүүд байна л даа. Мэдээж энэ хууль хэрэгжээд, практикт хэрэгжээд жил гаруй боллоо. Энэ хугацаанд практикт хүндрэл учруулаад байгаа асуудлуудаа л шийдэх гээд та нар оруулж ирж байна шүү дээ. Тэндээс сая Тэмүүлэн сайдын хэлээд байгаа нэг зүйл байна. Хөдөлмөрийн маргаан холбоотой энэ асуудлуудыг хялбаршуулсан журмаар биш шийдэхээр болж байгаа юм байна шүү дээ. Ердийн журмаар шийдэх гэж байгаа юм байна. Тэгэхээр энэ хэдэн хэрэг шийдсэн байдаг юм бол? Би сая асуултаас бол тэгж ойлголоо шүү дээ. Хэдэн хэрэг хөдөлмөрийн маргааныг шийдээд байгаа ч хүндрэл байгаад байгаа учраас ердийн журмаар шийдэх гээд байна шүү дээ тийм ээ. Тусгайлсан журмаар биш шийдэх гээд байгаагийн үндэслэл нь бас юу юм бэ гэж л энийг нь тодруулаад хариулчих. Тэгээд цаашаа явъя.

Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Мөнх-Эрдэнэ дэд сайд хариулъя.

Д.Мөнх-Эрдэнэ: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах маргаан 2025 онд бол хэрэг бол 253 хэрэг, нэхэмжлэл хүлээн авч 245 хэрэг шийдвэрлэсэн.

Ер нь бол анх ингээд хуулийн төслийг Улсын Их Хуралд ингээд хэлэлцүүлж байх үед бол энэ хялбар ажиллагааны шүүхээр хэлэлцэж байгаа энэ нийт нийт хэрэг, маргааны ер нь бол хэрэг үүс нэхэмжлэлийг хүлээж авснаас хойш 5 хоногийн дотор хэрэг үүсгэнэ. 45 хоногийн дотор хэрэг маргааныг хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 14 хоногийн хугацаагаар сунгаж болох ийм зохицуулалттай байсан.

Өөрөөр хэлбэл, энэ төрлийн хэрэг маргааныг өмнө нь дунджаар 109 хоногт шийдвэрлэж байсан бол хугацааг ингэж бууруулах зорилт тавьж байсан бол яг энэ төрлийн маргаан дээр энэ шийдсэн тохиолдлуудыг харах…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя ажлын хэсэг 4 дүгээр микрофон дээр.

Д.Мөнх-Эрдэнэ: Яг энэ төрлийн хэрэг, маргаануудыг шийдэж байсан хугацаа бол 100-220 хоног байгаа. Өөрөөр хэлбэл, хялбар, хялбаршуулсан журмаар биш болчхоод байгаа юм. Шинжээч томилдог, дүгнэлт гаргуулдаг ийм процесс, гомдол гаргадаг процесс байгаа учраас энийг ердийн журмаар шийдвэрлэх нь зүйтэй юм гэсэн ийм санал бид оруулж ирж байгаа юм. Тэгээд энэ хуулийн төслийг боловсруулахдаа бас Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүх, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хэрэг маргааныг хянан шийдвэрлээд байгаа хялбаршуулсан ажиллагааны шүүхийнхээ хүмүүстэй уулзаж, зөвшилцөж саналыг нь тусгаж ингэж ажилласан гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Яах юм тодруулах юм уу? Алтангэрэл гишүүн тодруулж асууя.

О.Алтангэрэл: Хамгийн эхний асуудал тэр цахим залилан дээр юу хийхээр төлөвлөж байна гэж? Ямар нэг хийхээр төлөвлөж байгаа зүйл байна уу? Яг энэ тухайн хуулийн төсөлтэй холбоогүй ч гэсэн энэ гэмт хэрэгтэй тэмцэх нь Засгийн газрын үүрэг тийм ээ. Тэгэхээр энэ дээр ямар нэг бодлого байна уу?

Хоёрдугаарт, тэр нэр томьёо дээр хэдүүлээ тэр цахим хэлбэрээр олгож байгаа хэлбэр бол ямар бол ямар байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ цаашдаа энийгээ бас яаж анхааралад явах вэ гэдэг дээр санал.

Гурав дахь нь энэ шууд хүргэсэн дээрээ хэдүүлээ нэмчхэж болж байна уу гэж. Өөрөөр хэлбэл, бичиг хэрэг болон баталгааж нөгөө Монгол шуудангаар явуулдаг дээрээ нэмээд мэйлээр нь явуулаад нөгөө хүн хариу өгсөн бол энийг шууд гардаж авчихсанаар ингээд хийчихвэл ганцхан хялбар ажиллагааны шүүх гэлтгүй энэ яваандаа энэ процессын дагуу явагдаж байгаа иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал юм биш үү гэсэн энэ дээр ямар байр суурьтай байна гэсэн ийм тодорхой асуулт.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн сайд хариулъя.

Г.Тэмүүлэн: Энэ цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг одоогоос 4, 5 жилийн өмнө бол 20 хүрэхгүй хувьтай байсан. Одоо үндсэндээ нийт гэмт хэргийн бараг 32.2 хувийг ерөөсөө дангаар ингээд эзлээд байгаа юм. Тэгээд бид нар энэ дээр бас онцгой анхааралад илүү арга ажиллагаа дээрээ бас илүү өөрчлөлт гаргахгүй бол зайлшгүй шаардлага бас байгаад байгаа. Одоо тун удахгүй нөгөө кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох хариу арга хэмжээ биш ээ, Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай гээд хуулийн төсөл бас орж ирэхээр ингээд бэлтгэгдээд байгаа. Энэ дээр харилцааг бид нар шинээр зайлшгүй бий болгох ёстой асуудал маань бол үндсэндээ нөгөө тэр тэр хөрөнгө хамгаалахтай холбоотой, тухайн тэр хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотойгоор нэмэлт зохицуулалтыг хийх ёстой юм. Зайлшгүй бид нар энэ цагдаагийн төв байгууллагын дэргэд энэ Харилцаа холбооны зохицуулах хороог, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагын бүрэлдэхүүнийг байнгын байлгаж тухай бүр шуурхай шийдвэрлээд, тухайн иргэний хөрөнгө гийг өмч хөрөнгийг аллагаас хамгаалах зохицуулалтуудыг тэр бүр шийдээд байх шаардлагатай. Прокурор бас дэргэд байх зайлшгүй шаа…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би 2, 3-н зүйл тодруулна. Санхүүгийн зохицуулах хорооноос нэг зүйлийг тодруулаадахъя. Сая энэ аппликэйшний зээл хөндөгдөж байгаатай холбоотой гэсэн үг. Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн чиг үүрэг бол яг энэ санхүүгийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах нэг ийм гол үндсэн чиг үүрэг байгаад байгаа. Тэгвэл энэ олон аппликэйшны зээлтэй холбоотой үүсэж байгаа ямар сөрөг үр дагавар үүсэж байгаа гэж та бүхэн харж байгаа вэ? Тэр дундаа бид нарын сайн мэдэх яриад байдаг хэр нь бодлого гардаггүй нэг зүйл бол энэ дундаж давхаргыг хамгаалах бодлого байдаг.

Тэгэхээр яг энэ аппликэйшний зээл болоод энэ зээлийн хүртээмж талдаа нэмэгдэж байгаа мэт боловч, дундаж давхарга маань эргээд эсрэгээрээ өрийн ийм дарамтад, өрийн сүлжээнд орж байгаа юм шиг байгаа юм даа. Тэр дээр хийж байгаа тооцоо судалгаа, та бүхний хамгаалах арга хэрэгсэл, бодлого гэж ер нь байгаа юу гэдэг дээр тодорхой хариулт авмаар байна.

Дээрээс нь ялангуяа энэ дундаж давхарга дээр гарч байгаа энэ зээлийн өөрчлөлт бол нэлээн сүүлийн 2 жил бол нэлээн маш томоохон хэмжээний өөрчлөлт гарч байна л даа. Тухайлбал, маш их хэмжээний өрхийн хэрэглээний жижиг хэмжээний зээлүүд өндөр хүүтэйгээр авч байна. Энэ нь эргээд хадгаламж хадгалах яг энэ амьдралын хэв маягийг нь өөрчлөөд өрийн хэв маяг руу шилжүүлж байна гэсэн үг. Тэгэхээр энэ тал дээр та бүхний гарч байгаа бодлого, харж байгаа зүйл гэж юу байгаа вэ гэдэг дээр хариулмаар байна.

Хуулийн төсөлтэй холбоотой 2, 3-н асуулт байна. Нэгдүгээрт энэ гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах механизм төсөл дээр нэмж орж ирж байгаа юу? Гуравдагч этгээдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд яах вэ гэдгийг хялбар ажиллагаа дээр ер нь яаж харж байгаа вэ гэсэн 1 асуулт.

Хоёрдугаарт нь шуудангаар мэдэгдэж байж болж байна. Цахимаар мэдэгдэж байж болж байна. Иргэн хуулийн этгээд хоёр дээр ялгаатай байх уу үгүй юү гэдэг дээр та бүхэн судалж үзэв үү? Ялангуяа хуулийн этгээдийн хувьд бол нэгэнт хаяг дээрээ байх үүрэгтэй, тэгээд түүнтэй холбоотой бас хэрвээ хаягийн шилжүүлэг гээд олон асуудлууд мэдээж байгаа. Гэхдээ хуулийн этгээд бол илүү хариуцлагатай байх учраас магадгүй хуулийн этгээд, иргэн хоёр дээр ялгаатай үзэх ийм зүйл байсан юм биш биз дээ? Энэ дээр тоо судалгаа байна уу гэсэн ийм асуулт байна.

Гуравдугаарт нь хариуцагч буюу иргэн сайн дурааараа хоёрдугаарт өөрөө хүлээн зөвшөөрч мэдээлэлтэйгээр ямарваа нэгэн дарамт шахалтгүйгээр энэ хялбар ажиллагааны шүүхийн үйл ажиллагаанд оролцож энэ нэг ёсондоо хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үг. Тийм ээ би энэ мөнгийг төлөх ёстой гээд. Тэгэхээр энэ 3 нөхцөл энэ 4 нөгөө цаана нь байдаг яг энэ зарчмуудыг хангаж байгаа шиг эсэх дээр та бүхэн ямарваа нэгэн хөндлөнгийн хяналтууд ер нь энэ хялбар ажиллагааны шүүх дээр явагдаж байна уу үгүй юү гэсэн ийм 3 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Хоёр байгууллагаас тусад нь асууж байна. Санхүүгийн зохицуулах хороо хариулъя. Санхүүгийн зохицуулах хороо сая Баасанжаргал гишүүн бас энэ ямар бодлогын арга хэмжээ нэгэнт үүсчихсэн

нөхцөл байдал чинь ийм хүнд байдалтай болчихсон байна шүү дээ. Энэ дээрээ та нар ямар дүгнэлт хийж байгаа юм? Жижиг зээл буюу аппликэйшний зээл чинь өөрөө ингээд нийгмийн том асуудал болсон байна. Иргэдийн хувьд том асуудал болоод шүүхийн хялбар ажиллагааны шүүхийн Тэмүүлэн сайдын хэлж байгаагаар 80 хувь нь энэ цахим буюу аппликэйшний зээл чинь болчихсон байна шүү дээ. Маргаантай байгаад байна. Тэгэхээр нийт олгож байгаа зээлийн чинь, аппликэйшн олгосон зээлийн хэдэн хувь нь шүүх дээр очоод байгаа юм бэ гэдгийг бас тэр тоо нь байна уу ? Ингээд харахаар ингээд том зураг харагдана. Тэн дээрээ та нар ямар бодлого хийж байгаа юм, ямар урьдчилан сэргийлэх гэдэг юм уу иргэдийнхээ эрх ашгийг хангах, хамгаалах тал дээр юу хийж байгаа юм бэ гэдэг тодорхой асуултуудад нь хариулъя. Дараачид нь Хууль зүйн яам хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье.

Б.Итгэлсүрэн: Итгэлсүрэн. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ цахим зээл хөгжсөнөөр түрүүн гишүүний хэлдэг энэ санхүүгийн хүртээмж хэдий нэмэгдэж байгаа, орон зайнаас үл хамааraад барьцаагүй бага хэмжээний зээл иргэдэд хүрч байгаа ч гэсэн бас сөрөг үр дагаврууд бол нэлээдгүй гарч ирж байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд бол энэ цахим зээлийн давхардал бас тодорхой хэмжээнд өсөж байгаа. Тэгээд энэ асуудлыг бол Санхүүгийн зохицуулах хороо 2021 оноос бас иймэрхүү эрсдэлүүд үүсэх юм байна гэдгийг олж хараад энэ банк бус санхүүгийн зээлийн журам дээрээ энэ цахим зээлийг Зээлийн мэдээллийн сан руу зээлийн мэдээллээ илгээхдээ энэ бодит цагийн горимоор нь нийлүүл ээ, ингэснээр нөгөө бусад санхүүгийн байгууллагууд бусад нөгөө банк, санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийг бодит цагийн горимоор хараад зээл олгохоос татгалзах иймэрхүү арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Түүнээс гадна хамгийн чухал хэрэгжүүлээд явж байгаа арга хэрэгсэл нь юу вэ гэхээр цахим зээл маань өөр өөрөө ер нь 100 хувь энэ бага дүнтэй зээлүүдийг бид нар бол хэрэглээний зээл гэж үздэг. Тэгэхээр хэрэглээний зээл дээр өр, орлогын харьцааг бол Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоогоод явдаг. Ингээд анх бол 70 хувиар тогтоож байсан бол өнөөдрийн байдлаар 55 хувь болгоод ингээд чангатгаад явж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ өр, орлогын харьцааг мөрдөж ажилласнаар энэ дундаж давхарга бас өрийн дарамтад орох, энэ өрийн дарамтын энэ цахим зээлийн энэ дарамтыг бас бууруулах гол хөшүүрэг гэж Санхүүгийн зохицуулах хорооноос үзэж байгаа.

Мөн давхар зээлийн энэ эрсдэлийг бууруулах зорилгоор бас нэлээдгүй ийм бодлогын арга хэрэгслийг бол авч хэрэгжүүлж байгаа. Тэр нь бол зээлийн мэдээллийн сан дээр зээл судлуулахаар хүсэлт гаргасан лавлагааг бодит цагийн горимоор хараад ингээд дараагийн банк бус санхүүгийн байгууллагууд олон ийм санхүүгийн байгууллага руу судалгаа хийлгэсэн байх юм бол судалгаа хийх, улмаар зээл олгох хугацаагаа 24 цагаар хойшлуулаад дахин судалгааг эхлүүлдэг иймэрхүү зохицуулалтыг хүртэл одоо журмаараа, холбогдох журмаар тусгаад мөрдүүлээд ажиллаж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Энэ дээр нэг зүйл тодорхой сая хэлсэнгүй. Нийт олгогдсон зээлийн чинь хэдэн хувь нь шүүх дээр очоод байгаа юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч. Хэдэн зээл өгч байгаа юм, тэрний хэдэн хувь нь шүүх дээр очоод байна. Тэгэхээр манай шүүх дээр байгаа маргааны чинь 80 хувь нь аппликэйшний зээл болчхоод байна шүү дээ. Тэгэхээр та хэдийн чинь бодлого та нарт нөгөө зохицуулалт хийх ёстой энэ Санхүүгийн зохицуулах хороо чинь. Зохицуулах гэдэг

агуулгаараа. Тэгэхээр энэ дээрээ ямар бодлого барьж байгаатай уялдах ёстой юм байгаа юм шүү. Тэр хэдэн хувь нь өгөөд байна гэдэг дээр хэн хариулах юм? Итгэлсүрэн хариулах уу? Хэдэн хувь нь шүүх рүү явчхаад байгаа юм? Та бүгдийн бага хэмжээний буюу аппликэйшний зээлийн чинь нийт тэдэн зээл олгоход тэдэн хувь нь шүүх дээр оччихоод байна аа? Тэгэхээр эндээс чинь яг та бүгдийн үндсэн, нөхцөл байдал чинь харагдах ёстой шүү дээ. Хариулъя 1 номерын микрофон өгье.

Б.Итгэлсүрэн: Банк бус санхүүгийн салбараас олгосон зээлийн 9.3 хувь нь бол хугацаа хэтэрчихсэн зээл байгаа. Ингээд бид нар бас нөгөө хялбар ажиллагааны шүүхдээ энэ нэлээдгүй ийм хамтын ажиллагааг хийж хэрэгжүүлсэн өнгөрсөн хугацаанд. Энэ цахим зээл олгож байгаа аппликэйшний банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтарсан уулзалтууд хийгээд энэ өргөдөл, гомдлыг хэрхэн бууруулах талаар бас ярилцсан. Энэ хэлэлцүүлгүүдийг хүртэл хийсэн. Ингээд харахад бол хялбар ажиллагааны шүүх дээрээс ирсэн мэдээллээр нийт ирж байгаа өргөдлийн 2025 онд бол 45 хувь нь банк бус санхүүгийн байгууллагатай холбоотой энэ цахим зээлийн өргөдөл, гомдол байна.

26 оны эхний хагас жилийн байдлаар бол 52.9 хувь нь бол энэ хялбар ажиллагааны шүүх дээр ирж байгаа энэ жижиг зээлүүдийн банк бус санхүүгийн байгууллагатай холбоотой жижиг зээлүүд байна гэсэн ийм мэдээлэл байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? Тэмүүлэн сайд хариулах уу? Энэ сүүлийн хоёр дахь, гурав дахь асуултууд байгаа шүү дээ. Ажлын хэсэг хариулах уу? Тэмүүлэн сайд хариулах уу? Та Баасанжаргал гишүүний тавьсан хоёр дахь, гурав дахь асуултууд байгаа шүү дээ. Ажлын хэсэг хариулах юм байна. Мөнх-Эрдэнэ сайд, дэд сайд.

Д.Мөнх-Эрдэнэ: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ гуравдагч этгээдийн хувьд бол ер нь бол ердийн журмаар асуудал шийдэгдэнэ. Мэдээж тухайн хэрэг, маргаантай холбоотой асуудал дээр бие даасан шаардлага гаргасан, гаргаагүй гуравдагч этгээд байгаа тохиолдолд хүсэлтээ гаргаад энэ тохиолдолд шүүх хүсэлтийг нь хангаж гуравдагч этгээдээр оролцуулаад ингээд явна. Энэ тохиолдолд бол ердийн журмаар хэрэг шийдвэрлэх ийм боломжтой гэж. Энэ ямар нэгэн хязгаарлалт байхгүй гэж хариулъя.

Хаягийн хувьд, хуулийн этгээдийн хаягийн хувьд бол, хуулийн этгээдийн хаягийн хувьд бол бид бас одоо байгаа хууль дээр бол ямар зохицуулалт байгаа вэ гэхлээр түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн тухай бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, эс үгүй бол өмгөөлөгчийн, Монголын өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж, хол…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя 1 номерын микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээдэг ийм зохицуулалт үйлчилж байгаа. Нэмэх нь бид нарын оруулж ирж байгаа бол түрүүний хэлсэн хуулийн төслийн 75.3-ын штрих 6 хэсэг дээр бол 6 дахь хэсэг дээр цахим хэлбэрээр олгосон зээлийн гэрээтэй холбоотой нэхэмжлэлийн хувьд, цахим хэлбэрээр зээлдүүлэгчээс баталгаажуулсан хариуцагчийн цахим хаяг, оршин суугаа хаягаар хүргүүлэх гэж ингэж шинэ зохицуулалт оруулж ирж байгаа.

Энэ өөрөө зээлдүүлэгчийн үүрэг, хариуцлагатай холбоотой ийм зохицуулалт байгаа юм.

Л.Мөнхбаатар: Болчихсон уу айн? Тэмүүлэн сайд нэмээд хариулчихъя.

Г.Тэмүүлэн: Мөнхбаатар даргаас сая асуусан асуултад хариулъя. Нөгөө яг хэдэн хувь нь яг шүүх хуралдаанаар шийдэгдээд байна вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ яг 26 оны 8 сарын байдлаар одоогийн байдлаар бол 36.7 мянган хэрэг бол нэхэмжлэл гаргаад ингээд хэрэг үүсээд ингээд явж байгаа. Энэ дотроос бол 4412 хэрэг нь бол буюу 12 хувийг бол шүүх хуралдаанаар шийдэж байгаа юм. 12 хувийг нь. 64 хувийг нь бол яг хялбаршуулсан журмаараа буюу шүүх хуралдаан явуулахгүйгээр шийдэгдэж байгаа. Тэр дотроо саяын эвлэрсэн ч гэдэг юм уу, эсвэл хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, шаардлагыг биелүүлсэн, нэхэмжлэлээсээ татгалзсан ч гэдэг юм уу ийм байдлаар бол ингээд шүүх хуралдаан явуулахгүйгээр шийдэгдэж байгаа юм.

24 хувийг нь буюу 8 мянган хэргийг бол үндсэндээ хэрэгсэхгүй болгоод шийдэж байгаа асуудлууд байгаад байгаа.

Л.Мөнхбаатар: Хяналт шинжилгээ. Мөнх-Эрдэнэ дэд сайд хариулчих 3 дахь асуулт дээр нь. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Бид энэ хялбар ажиллагааны шүүх үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2025 оны 01 сарын 01-нээс хойш хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээд шүүх эрх мэдлийн байгууллагуудтай энэ хуулийн хэрэгжилтэд учирч байгаа бэрхшээл, хүндрэл саадыг ярилцаж, зөвшилцөж, ингэж байж энэ тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Хэлэлцүүлгийн шатад бол энэ хялбар ажиллагааны шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн бас нэлээн олон санал, шүүмжлэл бид нарт орж ирсэн. Эдгээр санал, шүүмжлэлийг бол бас хуулийн төслийг боловсруулах явцад бол тусгаж ингэж ажилласан байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Гишүүд. Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Би нөгөө хуулийн этгээд, иргэн хоёр дээр ялгаатай байхгүй юу гээд байгаа нь энэ 75-ын штрих 9.4, 75-ын штрих 3.3 гээд 2 заалт байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нөгөө шийдвэрийг хүргүүлэхдээ шууд шуудангаар хүргүүлснээр хүргэсэнд тооцно. Хойд талд нь болохлоор хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд энэ тэр гээд ингээд ялгаатай ингэж зохицуулах гэж оролдсон байгаад тэгснээ цахим зээл дээр болохоор хүргүүлснээс хойш 7 хоног өнгөрсөн гээд ингээд 3 өөр ялгаатай процесс явах гээд байгаа байхгүй юу нөгөө мэдэгдсэнд тооцох гээд. Энэний чинь цаад нөгөө судалгаа нь нюанс нь юу юм бэ гэж асуугаад байгаа гэсэн үг.

Ялангуяа хуулийн этгээд дээр бол илүү энэ дээр бол илүү хариуцлагатай байх ёстой гэдэг дээр бол шууд хүргэснээр мэдэгдсэнд тооцно гэж болж байна. Иргэн дээр арай ийм хөнгөлөлттэй нөхцөл байх уу үгүй юү гэдгийг бодож үзсэн үү

гэсэн ийм утгатай асуулт гэсэн үг. Тэгээд цаашид энэ ажлын хэсэг дээрээ бас ярих ёстой болов уу гэж бодож байна.

Энэ 75 штрих 4.3 дээр энэ нэхэмжлэл хариу тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална гэдэг. энийг бас тодруулаад хэлчхээрэй.

Л.Мөнхбаатар: Хариулт авах уу? Мөнх-Эрдэнэ дэд сайд хариулчихъя. Иргэн, хуулийн этгээд дээр ялгаатай үйлчлэх үү гэж асуугаад байна. Тийм жоохон тодруулаад хариулчихаар болохоор гээд байгаа шүү.

Д.Мөнх-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн ээ энэ одоо байгаа зохицуулалт юм. Бид нөгөө зүйл дээр нь зарим орж байгаа нэмэлт, өөрчлөлтийг нь нөгөө тусад нь бичихэд төвөгтэй байгаа учраас бүхэлд нь үйл зүйлийг нь өөрчлөөд ингэж оруулж ирж байгаа юм. Энэ одоо байгаа зохицуулалт нь.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу байр сууриа хэлэх?

Байхгүй байна. Манай Хууль зүйн байнгын хороо бас мэргэжлийн байнгын хорооны хувьд бас энэ уг хуулийн төсөл дээр бол нэлээн олон талаас нь ярилаа. Гэхдээ энэ дээр бол нэлээн нарийвчлах бөгөөд анхаарах зүйлүүд сая байгаа гишүүд бүгд хэлж байна. Тэгэхээр ажлын хэсэг байгуулж ажиллана. Тэгээд ажлын хэсэг дээрээ яг энэ зүйлүүдээ нэлээн тодорхой болгоё.

Манай Хууль зүй, дотоод хэргийн яамныхан сая гишүүдийн хэлээд байгаа бас хариулт нь тодорхойгүй нэлээн хэдэн зүйл үлдлээ шүү Санхүүгийн зохицуулах хороонохон та нар тэрийгээ ажлын хэсэг дээрээ нэгтгэж байр сууриа нэгтгээд оруулж ирээрэй гэдгийг та бүгд хэлье.

Монгол. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу, биш үгийг нь авчихсан. Алх цохичихсон. Үг авчихсан, үг аваад хаачихсан. Тэмүүлэн сайд танаас юм асуугаад асууж байхын хоорондчинь л тэгээд яачихсан байна. Байр сууриа илэрхийлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ анхааралтай байгаарай.

Дамдины Цогтбаатар гишүүн дэмжсэн байна. Дэмжсэнээр авъя.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 64.7 хувь нь дэмжлээ.

Хоёр дахь нь санал хураалт явуулъя. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 76.5 хувь нь дэмжлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 76.5 хувь нь дэмжлээ.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулчихсан тийм ээ. Санал хураалтад оролцсон гишүүдийн 76.5 хувь нь дэмжсэн байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулах вэ?

Баасанжаргал гишүүн танилцуулъя. Дараагийнхаа асуудалд оръё.

15.45 цаг.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдоржоос 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг оруулаарай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байгаа юу? Уянгахишиг гишүүн түр байж байгаарай. Би энэ ажлын хэсгийг танилцуулчихъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Чүлтэмсүрэнгийн Цасчихэр. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Луттөмөрийн Очирсүрэн нар оролцож байна.

Уянгахишиг гишүүн асуултаа асуучихъя. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад.

Г.Уянгахишиг: Энэ 1 дүгээр зүйл дээр болохоороо өөрчлөх санал нь өөрт байхгүй холбогдох нотлох баримт сэлтийг энэ хуулийн 6.2-т заасан байгууллагад гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гарсан байна л даа. Тэгэхээр энэ дээр асуулт асуух гэж байгаа нь болохоороо энэ яг хуулийн төслийн өргөн барьсан хувилбараар бол нотлох баримт гаргаж өгөх үүрэггүй гэж явж байгаа юм. Тэгэхээр өөрт байхгүй гэдэг үгийг нэмчихээр өөртөө байхгүй гэдгийг бас нотлох ёстой юм шиг болчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр заавал өөрт байхгүй гэж нэмэх ямар шаардлага байгаа вэ? Ерөөсөө нотлох баримт гаргаж өгөх үүрэггүй гээд явчихвал аандаа тэр хүн чинь өөртөө байгаа юмаа гаргаж өгөх эрхийг бол ерөөсөө хаахгүй байгаа.

Харин нөгөө өөрт байхгүй холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх үүрэггүй гэчихээр энэ баримт өөрт чинь байх ёстой гээд ингээд шаардаад байх юм бол нөгөө нотлох баримт гаргаж өгөх үүрэггүй гэдэг санаа маань байхгүй болчих гээд байхгүй юу. Ер нь энэ хуулийн томьёолол дээр гэж нэмэх, нэмэлт шаардлага тавьж өгснөөрөө буцаагаад тэр нөгөө хуулийнхаа заалтын өөрийнх нь зорилго дээрээ бас алдаа гарах гээд байдаг явдал байдаг. Тэгэхээр нөгөө санал гаргасан гишүүнээсээ л би асуух гээд байна л даа. Яг заавал ингэж өөрт байхгүй гэж оруулах шаардлага байгаа юм уу? Зүгээр л нотлох баримт гаргаж өгөх үүрэггүй гэдгээрээ явчихвал болох юм биш үү л гэдэг ийм саналтай байгаад байна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсэг айн. Ингэе түр байж байгаарай. Цэнгүүн гишүүн бас зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа юм байна. Энэ томьёоллыг нь уншчихаад тийм байна. Тэгчхээд асуултад нь ажлын хэсэг хариулж болно. Тийм.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Энийг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хууль ёсны” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, “буюу” гэснийг “, эсхүл” гэж, “тохиолдолд энэ тухайгаа нотлох баримт сэлт” гэснийг “бол өөрт байхгүй холбогдох нотлох баримт сэлтийг энэ хуулийн 6.2-т заасан байгууллагад” гэж тус тус өөрчлөх гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Уянгахишиг гишүүний асуулттай бас агуулга нэг байгаа юм байна. Тийм учраас энийг нэгтгээд ажлын хэсэг хариулчихъя. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон бэ? Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье асуултад хариулъя.

Л.Очирсүрэн: Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга Очирсүрэн. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Хуулийн өмнөх юун дээр бол ажлын хэсгээр ярилцаад өөрт байхгүй, гомдлыг хэлмэгдсэн гэж үзэж байгаа этгээд өөрөө, эс үгүй бол түүний гэр бүлийн гишүүд аль нэг гишүүн, эс үгүй бол хууль ёсны төлөөлөгч гаргасан бол өөрт байхгүй нотлох, холбогдох нотлох баримтын хүсэлтийг 6.2-ын дагуу байгууллагад гаргаж өгөх үүрэггүй гэж байгаа юм.

Гэтэл гомдол гаргаж байгаа хэлмэгдэгч, түүний гэр бүлийн гишүүд маань бол бас өөрт нь тодорхой хэмжээний юу гэдэг юм мэдээлэл, юу гэдэг юм зураг ч гэдэг юм уу, дээрээс нь юу гэдэг юм тухайн үед хамт амьдарч байсан ахмад буурал настан ч гэдэг юм уу манай хууль дээр нөгөө мэдээлэл өгдөг яадаг юм

заалтууд байгаа л даа. Тэгэхээр жишээлэх юм бол зураг ч байдаг юм уу, бусад ийм өөрт байгаа нотлох баримтыг бол гаргаж өгөх ийм, гаргаж өгч ингэж шийдвэрлүүлдэг.

Өөрт байхгүй гэдэг нь бол тухайн үед юу гэдэг юм хэлмэгдээд явж байсан үеийн юу гэдэг юм тогтоол, шийдвэр, байцаалтын хэрэг материалыг бол тухайн байгууллагуудаар шүүхийн журмаар гаргуулна л гэсэн гэж ойлгож болох юм.

Л.Мөнхбаатар: Болсон уу, хариулт болсон уу? Тодруулах юм уу? Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Харин би ойлгоод л байна л даа. Жишээлбэл, нөгөө нотлох баримт гаргаж өгөх үүрэггүй гэдэг чинь нотлох баримт ерөөсөө гаргах эрхгүй гэсэн үг биш шүү дээ. Тэгэхээр өөрт байхгүй нотлох баримтыг гаргаж өгөх үүрэггүй гэчихээр тэрний чинь цаана хуулийн агуулга яаж яваад байна вэ гэхээр өөрт чинь байх ёстой тэрийгээ гаргаж өг гээд шаардаад байх үндэслэл нь үүсчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр уг нь энэ хууль санаачлагчийн гол зорилго чинь тэр хүнд зураг байх ёстой гээд байтал тэр зураг алдагдсан байж болно шүү дээ.

Тийм болохоор заавал нотлох баримт гаргаж өг гэж шаардаад байх шаардлагагүй. Төр өөрөө тэрийг нотлох баримтыг бүрдүүлэх үүргээ авч байгаа гэсэн үг байхгүй юу. Гэтэл энэ дээр өөрт байхгүй гэдэг ийм тусгай нөхцөл тавиад өгчихөөр энэ чамд өөрт байх ёстой гэдэг шаардлагыг тавих боломж чинь энэ хуулиараа үүсчих байхгүй юу даа. Тийм учраас би бол хууль санаачлагчийн анхных нь байсан төслөөр буюу нотлох баримт, сэлтийг гаргаж өгөх үүрэггүй гэдгээр явмаар байгаа. Тэрнээс өөрт байхгүй гэдэг шинэ нөгөө нэмэлт шаардлага оруулаад ирчихээр тэр чинь өөрт нь байх, байхгүйг нотлох ёстой ч юм шиг ингээд дахиад үйл ажиллагаа, процесс нэмээд байгаа байхгүй юу.

Л.Мөнхбаатар: Ойлголоо. Санал хураалтаар бас шийдээд явъя. Тийм Цэнгүүн гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргачихсан байгаа. Уянгахишиг гишүүн бас өөрийнхөө саналаа хэллээ. Энэ дээр харин Цэнгүүн гишүүнийхийг дэгийн дагуу хураана. Хэрвээ энэ дэмжигдэхгүй тохиолдолд бол хуучнаараа үлдэнэ гэсэн үг шүү дээ. Ийм байдлаар уншиж явна гэсэн үг шүү. Ингэж ойлгоод би саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтад бэлдье.

Гишүүд Эрдэнэболд гишүүн, Тулга гишүүн, Одонтуяа гишүүн. Гишүүд санал хураалтад бэлэн болсон байна. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 47.1 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй хоёр дахь саналыг, хоёр дахь асуудал руугаа оръё.

Төслийн хоёрдугаар зүйлийг хэлэлцье. 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

2 дугаар зүйл шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал бол тусдаа шүү. Зүйл үү? Асуулттай гишүүн алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан байна. Үүнийг уншиж танилцуулъя. Аль? Тэгээд ер нь зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн өөрөө тухайн саналаа тайлбарлаж хэлж болно шүү дээ. Тийм хариулж болно тийм.

Эхлээд энийгээ юу яачихъя та бүгдэд би саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “2” гэснийг “7.2” гэж, “холбогдох” гэснийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн. Санал хураалт бэлтгэх шаардлагагүй шууд явчихна. Цэнгүүн гишүүн саналаа тайлбарлаж бас үг хэлж болно шүү. Санал хураалт явуулна. Байнгын хорооныхон танилцуулчих. Санал хураалтдаа гишүүд бэлтгэсэн байгаа.

Саруулсайханы Цэнгүүн гишүүний гаргасан саналтай холбогдуулан ажлын хэсэг энэ дээрээ тодорхой тайлбар өгөөдөх дөө. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

Л.Очирсүрэн: Хоёр дахь сэвэн дээр Монгол Улсын холбогдох хуулийн төсөлд явсан. Энийг нарийвчилж үзэж, харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль гэж байгаа, гэж өөрчилж байгаа юм. Энэ нь яагаад ийм гэхээр цагаатгагдаж байгаа иргэн ер нь бол 3 төрлийн шүүхээр явж байгаа. Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон бол Эрүүгийн хуулиар ороод хуулийн дагуу Дээд шүүх цагаатгадаг. Бусад юу гэдэг юм хоригдож байгаад суллагдсан, мөрдөгдөж байгаад суллагдсан нь бол прокурор цагаатгадаг. Дээрээс нь энэ ажил, албан тушаалаасаа халагдсан, нутаг заагдсан, ажил албан тушаал нь буурсан хүмүүс бол Захиргааны хэргийн шүүхээр тогтоолгодог.

Иргэний гэм буруугүйн хохирол бол Иргэний хэргийн шүүхээрээ буюу нөхөн төлбөр олгох асуудлыг бол Иргэний хэргийн шүүх шийдвэрлэдэг. Захиргааны энэ юу гэдэг юм ажил, албан тушаалаасаа халагдсан, нутаг заагдсан энэ хүмүүсийн цагаатгах асуудлыг бол Захиргааны хэргийн шүүх авч хэлэлцдэг байгаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн чинь хариулт бас тодорхой л юм байна шүү дээ. Үүгээр нь аваад явчихвал яасан юм бэ хэдүүлээ?

Ингээд байна л даа Баасанжаргал гишүүний яриад байгаа болгоомжлолыг харж байна. Яах вэ энэ чинь өөрөө хуульдаа, ажлын хэсгээс би асууя. Эрүүгийн журмаар, иргэний журмаар гэдгээ шийдэх тэр эрх зүйн үндэс нь байгаа юм байгаа биз дээ? Дээр нь нэмээд энэ захиргааг нэмж байгаа юм байна гэж ойлголоо шүү дээ тийм үү? Тэгж ойлгож байгаа зөв үү? Эрүү, иргэн гэдэг зүйл чинь тэр хуульдаа байгаа юм уу? Ажлын хэсэг гялс хариулчих. Тийм. Холбогдох яг тэр хууль дээр чинь энэ 2 нь байгаа юм уу? Дээр нь нэмж энийг бичээд байна шүү дээ. Захиргааны хэрэгт шүүхэд хянан шийдвэрлэх тухай гэж нэмж байгаагийнхаа тайлбар, үндэслэлээ маш тодорхой хэлчих. Энэ дээр байгаа энэ 7.2 гэдэг нь бол би зүгээр техникийн чанартай юм гэж ойлголоо. Энэ дараа нь янзал найруулгаар янзалчихаар болохоор зүйл харагдаж байх шиг байна. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье. Тэгээд санал хураалтаа явуулъя.

Л.Очирсүрэн: Энэ Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хэн нь хаана нь өргөдөл, гомдол га гаргах вэ гэдэг нь тодорхой байх ёстой гэдэг үүднээс энэ захиргааны арга хэмжээ авагдсан хэлмэгдэгчдийг цагаатгах шийдвэр гаргах нь бол Захиргааны хэргийн шүүх байгаа. Манай дээр иргэн бол зөвхөн иргэний хохирлыг барагдуулах буюу нэхэмжлэл гаргах, нэхэмжлэл Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж нөхөн олговор авдаг ийм. Хуулийн заалт дээр нь байгаа.

Л.Мөнхбаатар: Санал хураалт явуулъя. Холбогдох гэдгийг л илүү тодорхой болгож байгаа гээд Захиргааны хэргийн шүүх гээд л биччихсэнээс болоод ингээд байгаа юм байна. Холбогдох гэхээр яах вэ шүүх аль маргааныг аль шүүх шийдэх вэ гэдгийг л илүү тодорхой болгох гээд л уул нь бичсэн томьёолол юм байна шүү дээ тийм үү энэ ажлын хэсгийнхэн? Санал хураалтаа явуулъя хэдүүлээ. Би санал хураалт, саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Ингээд гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 41.2 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Байхгүй байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан шүү. Эрдэнэболд гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Яах вэ энэ жишээлбэл сая Хятадад ийм хэрэг болсон байхгүй юу. Залуу хосууд технологи, шинжлэх ухааны аргаар зигот буюу нөгөө үрээ үлдээчихсэн. Тэгээд аль аль нь осолд ороод ингээд амиа алдчихсан. Тодорхой хугацааны дараа тэр хосын гэр бүлийнх нь хүмүүс өөрөөр хэлбэл тэрүүгээр нь ургийг нь хүүхэд болгоод ингээд хүн төрсөн гэж байгаа юм л даа. Энэ бол нөгөө шинжлэх ухааны хувьд бол яаж байна гэхлээрээ заавал нөгөө 10 сараар хязгаарлагдахгүй тийм боломж байгаад байгаа байхгүй юу. Тэгээд би бас ингээд сая гишүүдтэйгээ яриад энэ бол зөвхөн өнгөрсөн удаад 1 удаа үйлчлэх гэж байгаа хууль юм уу, эс үгүй бол ирээдүйд ч гэсэн цаашдаа байх юм уу гээд асуухаар энэ хууль бол цаашаагаа үргэлжлээд явах юм байна гэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр яаж байна гэхлээрээ 10 жил, 20 жилийн дараа Монголд ийм асуудал үүсвэл яах вэ гэдэг асуудал үүсэж байгаа юм. Санааг ойлгож байна уу? Үзэл баримтлал дээр байж байгаа тэр 4 юм байгаа шүү дээ. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч өөрөө, үгүй бол гэж ойлгож байна. Нас барсан бол түүний эхнэр буюу нөхөр гээд ингээд хамаарал бүхий хүмүүсийг нь бичиж байгаа дотор бол хэлмэгдэгчийг амьд байхад нь төрсөн болон үрчилж авсан, түүнчлэн хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхэд гэж байгаа юм. Технологийн хувьд чи энэ чинь 10 сараар хязгаарлагдахгүй болчихсон шүү гэдгийг хэлээд байхгүй юу. Тэгэхээр энд хугацаа заавал заах хэрэг байна уу л гэж хэлэх гээд байгаа юм. Асуух гээд байгаа юм.

Өөрөөр хэлбэл, энэ бол олон улсад түгээмэл болчихлоо шүү дээ. Тээгч эхээр хүүхэд төрүүлдэг ч гэдэг юм уу ийм тогтолцооны ийм шинж боломжууд гарчихсан учраас тийм. Тэгэхээр одоо бид нар энийг ингээд заавал хууль дээр 10 сар гэж заах хэрэг байна уу гэдгийг л асуух гэж байгаа юм л даа. Айн? Ирээдүйд бас энэ үйлчлэхэд яах вэ хамаагүй байна.

Л.Мөнхбаатар: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон уу? Хуулийнхаа үйлчлэх хүрээ, хязгаартай холбоотой асуудал асуугаад байна шүү дээ. Хариулчих.

Л.Очирсүрэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Хууль дээр бол, одоогийн энэ хуулийн төсөл дээр бол энэ зүйл заалт бол орж яваагүй байгаа. Гэхдээ саналыг хүлээж авлаа. Манай хууль бол 1922 оноос 1990 оны хооронд хэлмэгдсэн иргэдийн асуудлыг авч хэлэлцдэг ийм байгаа.

Гол нь бол хэлмэгдээд явах хугацаандаа хэлмэгдсэн хугацаанд юу гэдэг юм жирэмсэн үлдсэн ээжүүдийн, эхчүүдийн, хүүхдүүд байдаг учраас бодит амьдрал дээр эд нарын оруулах ийм зорилгоор үзэл баримтлалд ингэж орж явсан юм байгаа юм.

Л.Мөнхбаатар: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Сая энэ 2026 оны 05 сарын 01-нд Улсын Их Хурлын 15 дугаар тогтоол гарсан. 4, 5 хуудас тогтоол гарсан. Энэ тогтоол гарах болсон суурь шалтгаан нь бол эрүүдэн шүүхийн улмаас хохирсон хүмүүсийн хохирлыг төр яаж барагдуулж, нөхөн төлүүлэх вэ гэдэг асуулт явсан. Энэ маань Хууль зүйн байнгын хороон дээр ажлын хэсэг явсаар байгаад нэр бүхий 10 гишүүн 2 жил ажлын хэсэгт нь орж ажиллаад энэ Эрүүгийн хууль болон энэ процессын үйл ажиллагаа дахь системийн шинж чанартай алдаа мадгийг яаж системийн шинж чанартайгаар засварлах вэ гэдэг Засгийн газарт чиглэл өгсөн баахан даалгаврууд өгөгдчихсөн байгаа юм. Намрын чуулганы бүрэн эрхийн, намрын чуулганы хугацаанд. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ хугацаанд бас яг энэ хуулийг төгөлдөржүүлэх асуудлууд гарч ирэх бөгөөд цаашлаад бол мэдээж өнгөрсөн хугацаанаас гадна ирээдүйд энэ тохиолдохгүй гэх баталгаа байхгүй учраас тэр чиглэлийн хуулиа ингээд юу гэдэг юм зохицуулалт дээрээ энэ технологийн боломж өсчихсөн байгааг харгалзаж үзээрэй л гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Эрдэнэболд гишүүн бас тодорхой санал хэллээ. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн “3” гэснийг “12.3” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн. Санал хураалт гишүүд ээ.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 70.6 хувь нь дэмжсэн байна. Санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг зүйл бүрээр явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн танилцуулна.

16.07 цаг.

Дараагийнхаа асуудалд оръё. Ажлын хэсгээ оруулаарай. Төсөв төсөвтэй холбоотой асуудлаа хэлэлцэнэ. Ажлын хэсгээ оруулчих.

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгээ оруулъя. Ажлын хэсэг орж хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулна.

Байнгын хорооны гишүүдэд бас мэдээлэл хүргэчихье. Нэгдсэн төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчдын 2027 оны төсвийн талаарх энэ мэдээллийг бас ингээд тусад нь нэгтгээд гишүүдэд бас тараасан байгаа шүү. Тийм учраас бас манай Тамгын газрынхан энийг нэгтгэсэн байна. Тийм учраас та бүхэн бас энэнтэй бас танилцаарай гэдгийг хэлье.

Ажлын хэсгийнхэн наашаа ороод сууцгаачих. Ажлын хэсгийнхэн суучих, байраа эзэлье.

Хуралдаан эхлэхийн өмнө бас би нэг зүйлийг бас хэлчихье гэж бодлоо. Сая Байнгын хороогоор бас энэ улсын нэгдсэн төсөв хэлэлцэхтэй холбогдуулаад бас Их Хурлын гишүүд бас тодорхой асуудлуудыг тодруулсан. Тэмүүжин гишүүн, хэд хэдэн гишүүд бас асуудлуудыг тодруулаад байгаа юм. Тусгай хяналтын дэд хороотой Хууль зүйн байнгын хорооны дэргэдэх энэ хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих Тусгай хяналтын дэд хорооны хороо энэ төсвийг ер нь хэрхэн хэлэлцэж байх вэ гэдэг асуудлыг илүү тодорхой болгоё гэж байгаа. Одоогийн Дэгийн хуулиараа бол нь хоёр дахь хэлэлцүүлэг бол нь Байнгын хороо хэлэлцэнэ. Гурав дахь хэлэлцүүлгээс Байнгын хороо болон дэд хороо хэлэлцээд явдаг ийм дэгийн хуультай байгаа юм.

Гэхдээ ер нь логикоороо бол, та битгий зэрэгцэж яриад байгаарай. Логикоороо бол яах уу улсын төсвийг хэлэлцэхэд Байнгын хорооны болоод Их Хурлын бүтцийн байгууллага болох дэд хороо бас ер нь хэлэлцэж байх нь ер нь хамгийн зохимжтой байна. Ийм учраас цаашдаа Их Хурлын дэгийн хуульд өөрчлөлт оруулахдаа бас Байнгын хорооны дэргэдэх энэ дэд хороонууд бас хэлэлцээд өөрийнхөө санал, дүгнэлт гэдэг юм уу, тухайн Байнгын хороогоороо дамжуулан Төсвийн байнгын хороонд уламжлах энэ асуудлуудаа оруулдаг байх нь зүйтэй гэдэг агуулгаар бас Байнгын хорооныхон болон манай Их Хурлын гишүүд бас тэр Их Хурлын дэгийн хуульд оруулах өөрчлөлтдөө бас анхаарч оруулаарай гэдгийг бас хэлье. Энийг бас эхэнд нь хэлчихье гэж бодож байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Золзаяа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Мөнхзориг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Наранбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын

газрын дарга Заяадэлгэр, Улсын Дээд шүүхийн төсвийн ерөнхий нягтлан бодогч Эрдэнэцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Энхтөр ирсэн үү? Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнх-Алдар, Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга ерөнхий нягтлан бодогч Бадамсэрээжид, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Чулуунбат, Авлигатай тэмцэх газрын хэн ирсэн байгаа? Азжаргал, Баасанням нар ирсэн байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын Нарийн бичгийн дарга Цасчихэр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Очирсүрэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас оролцож байгаа төлөөллийг танилцуулъя. Хууль зүй, дотоод хэрийн сайд Тэмүүлэн, Хууль зүй, дотоод хэрийн дэд сайд Мөнх-Эрдэнэ ирсэн байгаа юу? Мөнх-Эрдэнэ дарга? Хүмүүсээ оруулаарай Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Оростогоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Базаргүр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах ахлах шинжээч Хатантуул. Энэ Хууль зүйн яамныхан байгаа юу? Хүмүүсээ оруулаарай. Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Болд, Цагдаагаас хэн байгаа юм? Ганчулуун оруулж ирсэн байна. Тэргүүн дэд дарга Ганчулуун ирсэн байна. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа Батчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ралдийжамц. Хил хамгаалах ерөнхий газрын дарга Хилийн цэргийн командлагч, хошууч генерал Бямбасүрэн, Хилийн цэргээс хэн байна? Генерал ирчихсэн байгаа юм байна тээ? Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Намсаманд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Цэргийнхүү, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга хурандаа Өнөртуяа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга хошууч Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дабааням, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга Нямдаваа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ганбаяр, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа Алтансүх, Гадаад хэргийн харьяатын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхсүх, Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Солонгоо, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Жамъянхүү, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Уранчимэг, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нямгэрэл, Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лхамсүрэн, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дарга, цагдаагийн хурандаа Ганзориг, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргаа удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга, цагдаагийн хошууч Уянга, Дотоод хэргийн их сургуулийн захирал, бригадын генерал Сүхболд байна уу? Энэ хүмүүсээ байлцуулаарай. Дотоод

хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Гантулга, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хурандаа Нарантуяа, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, дэд хурандаа Баярсайхан, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Буянбат нар ирсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн, Нийцлийн аудитын газрын захирал тэргүүлэх, аудитор Буяндэлгэрийн Баттуяа, Аудитын шийдвэр, хэрэгжилтийн газрын захирал Чимэдцэрэнгийн Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Баясгалангийн Долгорсүрэн, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер Машдэлгэрийн Наранжаргал, Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер Довчинсүрэнгийн Цэгмэддорж нар хүрэлцэн ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат мөн хүрэлцэн ирсэн байгаа.

Сангийн яамны төлөөллийг танилцуулъя. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Чимидсүрэн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ичинноров, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Гантулга, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Содномдаржаа, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Отгонжаргал, Сангийн яамны Төсвийн орлогын ахлах мэргэжилтэн Мөнхзул нар оролцож байна.

Энд Эдийн засаг, хөгжлийн яамнаас оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын төлөвлөлтийн Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Отгондэмбэрэлийн Мягмардорж, мөн яамны хэлтсийн ахлах мэргэжилтэн Галбадрахын Төгөлдөр нар оролцож байна. “Чингис хаан баялгийн сан” нэгдлээс Чингис хаан баялгийн сан нэгдлийн гүйцэтгэх захирал Даваадалай, газрын дарга Мэндбаяр, Зоригтбат, Чагнаадорж, “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирал Чагнаадорж нар оролцож байна. Эдгээр албан тушаалтнууд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байна.

Ингээд дэгт заасны дагуу та бүхэн хууль санаачлагчаас асууж болно. Мөн Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно. Үүний дагуу асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Байгаа юу? Баярмаа гишүүнээр. Цогтбаатар гишүүнийг нэмье. Болсон уу? Цогтбаатар гишүүн үг хэлье.

Д.Цогтбаатар: Би орж ирж байгаа төсвийг бол эхнээс нь дэмжээд явж байгаа. Гэхдээ энэ дээр би зүгээр бас энэ Сангийн яамныхан ч гэсэн нэг зүйлийг анхааралтай гэж бодож байгаа юм. Асуулт байхгүй. Хэлэх үг. Ер нь бол энэ шүүхийн шинэчлэл, энэ хууль, хяналтын байгууллагуудтай холбогдсон бас

шинэчлэх нэлээн олон үйл ажиллагаанууд явж байгаа. Тэгээд төсвийн тал дээр нь бол дэмжиж ажиллах ёстой шүү. Эндээс ингээд баахан дэмжинэ гэдэг тунхаг чанарын үг улс төрчид гаргаж гаргачхаад тэгээд улс төрчдөөс хүсэж байгаа дэмжлэг юу вэ гэхлээр төсөв дээр нь л дэмжиж өгөх ёстой. Энэ бол төрийн ажлыг явуулахад төсөвгүй угаасаа явна гэж байхгүй.

Тэгэхлээр энэ дээр тэр төсвийг нь аль болох хангалттай тавьж өгч ажлыг нь хийх боломжийг олгож өгч байж дараа нь хариуцлагын асуудал өөрөө гардаг шүү гэдгийг би бас цохоод хэлмээр байгаа юм. Тэгээд энэ дээр бол хуучин Байнгын хороон дээр бол нэлээн төсөв дээр нь дэмжиж ажиллаж өгч байсан энэ бодлого Мөнхбаатар даргын үед үргэлжилнэ гэж итгэж байгаа. Тэгээд энэ жишээлбэл би зүгээр энгийн жишээ л ярья л даа. Энэ шүүхийн барилгуудын асуудал дээр гэхэд урьд нь тавигдчихсан юмнууд зарим нь Сангийн яаман дээр очоод хасагдаж бариад ороод ирчихсэн байх шиг байна лээ. Тэгэхлээр энэ Төв аймаг, Дундговь гэсэн, жишээлбэл аймгууд дээр нэгэнт ажлууд нь ингээд хийгдэхээр болчихсон тэр төсвүүд нь хүлээгдээд байж байхад энэ нь ингээд батлагдахгүй хэрэв орхигдоод явчих юм бол ажил гацна л гэсэн үг.

Тэгэхлээр энэ дээр миний зүгээс хэлэх үг бол Сангийн яам дараагийн удаа энэ асуудал дээрээ бол анхаарч, энэ асуудлыг тусгаж оруулж ирээрэй л гэдгийг захиж хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Үг хэлчихлээ. Байр сууриа илэрхийлж үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг асуултаа асууя.

П.Сайнзориг: Том салбар байдаг. Бас олон л асуулт байгаад байна. Нэгдүгээрт яах вэ ер нь ирэх жилүүдэд гол асуудал энэ донтох өвчтэй тэмцэх энэ асуудал дээр ямар бодлого, төсвийн хөрөнгө оруулалт орж ирж байгаа вэ? Тэр Архины сан зарцуулдаггүй. Одоо Архины сангийн 27 онд 6 тэрбум төгрөг тавьж байгаад ажлын алба байгуулна гэж байгаа байхгүй юу. Цалин тавиад л дуусах гээд байна. Битгий тэгээч гэж гуйж байна. Үүгээр нь тэр 22 тэрбумаар нь зарцуулаад эмнэлэг тэр донтох өвчин буюу хар тамхи, мансууруулах бодис, дэлгэцийн дон, архины донг эмчлэх тэр эмнэлгүүдийг нь бүсүүдэд байгуулах ажил дээр зарцуулаад өгөөч ээ. Битгий жижгээр тавьж байгаад 5, 6-н хүнтэй ажлын алба байгуулна гээд ингээд үрэн таран хий л дээ. Бодит үр дүн гаргамаар байна Энэ дээр ямар байдлаар орж ирж байгаа юм нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ хоригдлуудын нэгж хоригдол дээр хэчнээн төгрөгийн хоолны зардал болон урсгал зардлууд гарч байгаа? Ер нь энийг зарим асуудлыг нь өөрсдөөс нь гаргуулах, зардлын бас тодорхой хувийг нь өөрсдөөс нь гаргуулах хөдөлмөр эрхлэх тэр боломжийг нь бүрдүүлж өгөх тал дээр Засгийн газар, Хууль зүй, дотоод хэрийн ямар байр суурьтай байна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар? Дээрээс нь шүүх шинжилгээний байгууллага гэдэг бол бид хэд анзаараад байгаа юм гэмт хэрэгтэй тэмцэх гэхээр ерөөсөө л мөрдөн шалгах байгууллагууд болон энд нэг оролцдог хянадаг эргээд энэ чиглэлийн байгууллагуудыг ойлгоод байтал хэргийг яг шуурхай хэн нэгнийг хэлмэгдүүлэхгүй, хэргийн бодит байдлыг цаг хугацаа алдахгүйгээр шийдээгүй шүүх шинжилгээний байгууллагуудын чадавхын асуудал. Энэ шүүх шинжилгээний байгууллага ер нь ерөнхий газар болгож өгсөн. Энэ тоног төхөөрөмж, янз бүрийн юмнууд юу болсон бэ? Одоо энэ задланг жишээ нь хийхгүйгээр программ, технологийн давуу талаар тухайн тэр цогцсыг оруулаад гаргахад ямар өвчний улмаас үхсэн энэ тэр гардаг болсон шүү дээ. Бид хэд бас

жоохон иргэнлэг, хүмүүнлэг талдаа байя гээд байгаа. Энэ чиглэлийн юмнууд ер нь юу болж байгаа вэ? Бас энэ дээр ерөнхийд нь шүүх шинжилгээний байгууллагуудын техник, технологийн хангамж ямар байгаа вэ? Энийг хариулж өгөөч.

Хоёрдугаарт дараагийн асуудал энэ Хил хамгаалах ерөнхий газар. Ирэх жилүүдэд бас энэ Гашуунсухайт эргээд энэ Ханги-Мандалын боомт ч гэдэг юм уу, тодорхой боомтуудад бол төмөр замаар холбогдох нь. Энэ дээр хил хамгаалах байгууллага ер нь бэлэн байгаа юу? Ер нь зүгээр яах вэ энэ чиглэлдээ та нар бас бас анхаарах ёстой. Дээрээс нь энэ зорчигч тээврийн, зорчигч нэвтрүүлж байгаа энэ хилийн боомтуудын E-gata-ийн асуудал ер нь өргөжсөн үү? Буянт-Ухаа болон Замын-Үүд, Алтанбулаг дээрээс нь энэ Боршоо боомтуудын асуудлууд яригдаж байсан. Одоо ингээд Буянт-Ухаагаас өөр газар ер нь нээгдсэн үү? Замын-Үүд хоёроос өөр? Энийг цаашдаа ер нь ямархуу байдалтай явж байна?

Францчуудтай ярьж байсан тэр хилийг, энэ хил хамгаалалтыг бас технологийн арга буюу дулаан мэдрэх тэр тоног төхөөрөмжийг тавьж хамгаалъя гэж ярьж байсан. Энэ зүйлүүд ер нь хийгдэж байгаа юу? Одоо бүх зүйлийг хүний хүчээр шийднэ гэж юм байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ зүйлүүд дээр ямар ахицууд гарч байна? Энэ дээр бас хариулаач.

Цагдаа, дотоодын цэрэг дээр асууя. Энэ ундны ус болон эрчим хүчний эх үүсвэрүүдийн энэ харуул хамгаалалтын асуудал дээр ер нь ямар байдалтай оролцож байгаа вэ? Энийг харуул хамгаалахад хэчнээн алба багт оролцож байна? Энэ өөрөө эргээд үйл ажиллагааны зардлаа нөхөж чадаж байна уу? Эсвэл улсын төсвөөс татаастай ажиллаад байна уу? Энэ салбар дахь мөрдөх, ялангуяа мөрдөгч нарын чиглэлийн боловсон хүчний нөхөлт чинь хэд байна? Дотоод хэргийн их сургуулиас төгсөгдөж байгаа оюутнууд чинь бараг ажилд орох шаардлагатай орон тооноосоо цөөхөн байгаа. Энэ завсар дахь нөхөлтийг яаж хийж байна? Ажлын ачааллыг яаж тэнцвэржүүлэх бодлого бас барьж байна? Энэ хэдэн мөрдөгч нар чинь бараг ажил ачааллаасаа яагаад энэ ажлын хам шинжтэй болж байх шиг байна шүү. Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодлого, төсвийн асуудлуудаар зохицуулалт орж ирэхээр байгаа вэ? Эцэст нь сайдаас бас асууя. Ер нь хувийн эрх зүйн шинэчлэл энэ…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Ер нь төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулан төсвийн захирагч нар өөрсдөө хуулиар хүлээсэн үүрэг, байгууллагынхаа хэвийн үйл ажиллагааг хангахад энэ 2027 онд тавьж байгаа энэ төсөв чинь хүрч байгаа эсэх, хэрвээ учир дутагдалтай зүйл байгаа бол түүнийгээ бас тайлбарлаж бас ярьж болно.

Ингээд 3 номерын микрофон дээр ээлжилж суугаад хариулна шүү. Эхлээд эхний асуултад бол Сангийн яам хариулах юм байна гэж ойлголоо тийм үү? Эхний асуултад. Хууль зүйн яам юм уу? Тэр Архидан согтуурахтай тэмцэх сантай холбоотой асуудал явж байна шүү дээ. Энэ Сангийн яам, Хууль зүйн яам хэн нь хариулах юм? Дараа нь Хилийн цэрэг, түүний дараа Цагдаагийнхан бэлтгэгдэж байгаарай. Буянбат хурандаа хариулах юм уу? Архидан согтуурахтай тэмцэх сантай холбоотой асуусан асуулт байна шүү дээ. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

Ж.Буянбат: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд энэ Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, дэмжих энэ сан хамт ажиллаж байгаа. Энэ дээр яг орон тоотой, цалин мөнгөтэй алба хаагч бол байхгүй. Ажил үүргийг нь хариуцуулчихсан. Ирэх энэ 27 оны төсөвт 12 тэрбум, 12.9 тэрбумын санал төсвийн ерөнхийлөн захирагчаас хүргүүлсэн. Их Хуралд яг өнөөдрийн байдлаар 5 тэрбумын зардал зарцуулагдахаар ингэж орж ирсэн байгаа.

Донтох эмгэг Хууль зүй, дотоод хэргийн яамны асуудал дээр бол албадан эмчилгээний, энэ Майнт дахь албадан эмчилгээний байр сав, орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт дээр энэ 5 тэрбумаас тодорхой зардалд зарцуулагдана гэж ингэж тооцож байгаа. Энэ 5 тэрбум төгрөг батлагдах юм бол энэ сангийн удирдах зөвлөл буюу төр, олон нийтийн төлөөлөл тэнцүү тоогоор орсон энэ зөвлөл шийдвэрээ гаргах юм.

Л.Мөнхбаатар: Энэ Сайнзориг гишүүний асуултад бас Сангийн яам хариулчих нь зүйтэй. Сая Буянбат хурандаа бол яах вэ нөхцөл байдлаа ярьж байх шиг байна. Энэ Архидан согтуурахтай тэмцэх санд төвлөрч байгаа энэ мөнгө бол бас улсын төсвөөс хуваарилагддаг бол мөнгө биш архи үйлдвэрлэгчдээс тодорхой мөнгийг төвлөрүүлдэг. Түүнийгээ 4 чиглэлээр зарцуулах үүрэгтэй ийм сан байгаа юм. Тэгээд Сайнзориг гишүүний энэ яриад байгаа агуулга бол нь энэ сангийн мөнгийг ирэх онд 5 тэрбум гээд биччихжээ. Өнгөрсөн онд бол 0 байсан байна. Энийг энэ онд 5 гэсэн байна. Нийт цугларсан мөнгө нь хэд байгаа юм? 20 хэдэн тэрбум байгаа бол нь тэрийгээ ингээд тухай бүр ингээд зарцуулаад энэ зориулалтынх нь дагуу зарцуулах энэ ажилд нь ингээд өгөөд явах боломжтой юм уу? Яагаад ингээд заавал 5 гэж багасгаж тавьдгийн учир шалтгаан нь юу байна гэж асуугаад байна тийм үү Сайнзориг оо? Тийм учраас энэ дээр та хариулт өгчих. Санжаадорж дарга хариулъя.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Одоогоор Архидан согтуурахтай дэмжих санд бол 22 тэрбум төгрөг бол хуримтлагдсан байгаа. Энэ нь бол архи үйлдвэрлэж байгаа болон импортоор оруулж ирж байгаа компаниудаас албан татварын шугамаар бол орж ирээд манай дээр татварын данснаас бол хуваарилалтаа хийгээд явж байгаа. Тэгэхлээр нэгж хэмжээнд нь тогтоосон тарифынх нь дагуу гэсэн үг.

Энэ зардал маань өөрөө бол бас төсвийн бүрэлдэхүүн хэсэг байгаад байгаа. Тэгэхлээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бол энэ зардал бол өөрөө заавал төсөв дээр тавих болчихлоор төсвийн нөгөө орон зайн дээр сууж орж ирэх болчхоод тэгээд орж ирж чадаагүй байгаад байгаа. Үүнтэй ижил бас сан байгаа. Тэр нь бол Авто замын сан байгаа. Авто замын сангийн асуудлыг бол ирэх жилээс бол энэ дээр бол хувийн хэвшилтэй бас хамтарч ажиллах, төр, хувийн хэвшлийн оролцоог хангах зорилгоор бол бас төсвөөс бас бие даалгах шугамаар бол ажиллаж байгаа.

Хэрвээ энэ дээр бас ингээд энэ дүрэм журам маань бол тэр Авто замын сан дээр болоод ажиллачих юм бол яг энэ сан дээр бас ижилхэн ийм арга…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Дараагийн асуултад нь хэн хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгч байя. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Г.Цэргийнхүү: Шүүх шинжилгээний ерөнхий газрын дэд дарга хурандаа Цэргийнхүү. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр 2026 онд хоригдлын хоолны зардал 11 тэрбум төгрөг төсөвт зарцуулагдсан. 27 оны төсвийн төсөөлөл дээр мөн 11 тэрбумаараа явж байгаа. Ер нь бол хоригдлын 1 өдрийн хоолны зардал 4076 төгрөгөөр тооцогдож явж байгаа.

Ер нь бол хоригдлын хоолны зардлыг бол төсвөөс санхүүжүүлэх ёстой гэсэн хуультай явж байгаа. Энэ дээр бас түрүүн таны хэлсэн бас хоолны төлбөрийг хоригдлын бас хөдөлмөрийн хөлснөөс гаргуулах энэ асуудлыг бас анхаарч ажиллана дарга.

Л.Мөнхбаатар: Хил хамгаалах ерөнхий газар Бямбасүрэн генерал хариулъя. 3 номерын микрофон өгөөрэй.

Ж.Бямбасүрэн: Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Бямбасүрэн. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Хил хамгаалах байгууллагад технологийн шинэчлэлийн ажлууд бол жил жилээр төлөвлөгдөөд үргэлжлээд хэрэгжээд явж байгаа. Ялангуяа шалган нэвтрүүлэх албан дээр энэ иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг бас түргэн шуурхай үзүүлэх чиглэлээр шат дараалсан олон ажлуудын нэг нь бол энэ автомат гарцууд байгаа.

Өнөөдрийн байдлаар бид нар Замын-Үүд үүд дээр 10, Хөшигийн хөндийд 10, Алтанбулаг дээр шинээр 10-ыг нэмээд ашиглаж байгаа. Мөн төмөр замын боомтуудад бид нар иргэдийг галт тэрэгнээс буулгахгүйгээр шалгадаг хөдөлгөөнт бас шалгалтын тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Мөн хил хамгаалах байгууллагын хэмжээнд мэдээллийн нэгдсэн бие даасан холбооны систем байгуулах, шат дараалсан удирдлагын төвүүдийг байгуулах ажлууд бол жил жилийнхээ төлөвлөгөөнд тусгаад энэ ажлууд бол хэрэгжээд бас энэ дээр онцгой анхаарч ажиллаж байгаа. Гашуунсухайтай холбоотой ажлууд…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцэж хариулах уу болсон уу? Бямбасүрэн генерал гүйцээгээд хариулчихъя.

Ж.Бямбасүрэн: Гашуун сухайтыг анги болгон өргөжүүлэх асуудал бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Энэ жил бид нар анги болгохоор Засгийн газрын тогтоолыг өргөн, саналаа хүргүүлсэн боловч орон тоо нэмэхгүй гэдэг шалтгаанаар үндсэндээ Гашуунсухайтын орон тоо, төсөв батлагдаагүй, тавигдаагүй явж байгаа. Засгийн газрын тогтоол нь гараагүй байгаа.

Нийтдээ бол нийтдээ 143 хүн хүний тоогоор орон тоогоо нэмэгдүүлээд 4.8 тэрбум төгрөгийн санхүүжилт бол нэмэлтээр шаардлагатай байгаа. Бид бол албан хаагчдаа байрлуулах орон сууцын асуудал ерөнхийдөө тэн дээр анги болгон өргөжүүлж, цаашдаа шалган нэвтрүүлэх албыг отрядын хэмжээнд өргөтгөн зохион байгуулахаар бол байгууллагаас шалтгаалах бэлтгэлүүдээ хангаж байгаагаа танд танилцуулъя.

Л.Мөнхбаатар: Цагдаагаас цагдаагийн байгууллага асуултад хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон өгөөрэй.

Д.Батчулуун: Цагдаагийн ерөнхий газраас Санхүү, ард талын албаны дарга хурандаа Батчулуун. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Дотоодын цэргийн хамгаалалтад энэ Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор усны эх үүсвэрүүд дотоодын цэргийн хамгаалалтад байхаар заасан. Өнөөдрийн байдлаар 9 аймаг бол авагдаагүй байгаа. Үүнд усны эх үүсвэрт нийтдээ 300 гаруй энэ 9 аймгийг хамгаалалтад авахад шаардлагатай 300 гаруй орон тоо нэмүүлэх санал энэ жилийн төсвийн төсөлд өгсөн боловч одоогоор дэмжигдээгүй байгаа. Улаанбаатарын төв дээр бас зарим усны цэг үүсвэр нэмэгдэж байгаа асуудлыг бол дотооддоо байгаа цэргийн ангиудынхаа нөгөө цөөн хүчээр явж байгаа. Аймгууд дээр бол зайлшгүй 8 аймагт нь ийм тусгай дотоодын цэргийн салбар байхгүй учраас одоогоор хамгаалалтад авч чадахгүй байгаа.

Хоёрдугаар асуулт энэ юуны мөрдөгч нарын сул орон тоог мэргэшүүлэх тухай асуулаа. Цагдаагийн байгууллагад нийтдээ 12 мянга гаруй албан хаагч нар ажиллаж байгаа. Үүний 20 хувь нь буюу 2000 орчим мөрдөгч нар эрүүгийн…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя.

Д.Батчулуун: 2000 орчим мөрдөгч нар ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар мөрдөгч нарын сул орон тоо 200 орчим мөрдөгч байна. Жилдээ цагдаагийн байгууллагад 170-аад 100 офицер орон тоо, 170, 80 орчим гарц ажлаас орох, гарах хөдөлгөөн байна. Үүний бас тал хувийг нь дандаа мөрдөгч нар эзэлж байгаа. Дотоод хэргийн их сургуулийн төгсөлтөөс бол 200 жилдээ 270-аад хүн төгсөж байгаа нь бол нийт энэ юуны 40 хувийг эзэлж байна. Бусдыг нь бол энгийн их, дээд сургууль төгссөн болон тийм бусад сургуулиас сонгон шалгаруулалтаар авч, нөхөн хангалтаа хийж ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Одоо тэгээд бас бусад гишүүддээ бас хүлцэл өчье. Олон учраас олон л асуумаар байна. Би аль болохоор базаж байна. Тэр Сангийн сайд маань сууж байна. Тэр 22 тэрбумыг яг тодорхой эмнэлгүүдэд яг энэ Наркологийн төв бариулах, энэ донтолтын эсрэг юмаа барихад зарцуулаад өгчхөөч ээ. Яг үнэндээ бол архидалт, энэ мансуурах бодисын чинь асуудал маш хүнд байгаа шүү. Албадах эмчилгээний Мааньтын ангиас гадна сайн дурааараа очих газар байхгүй байхгүй юу. Хэдэн төрийн бус байгууллагууд аваад явж байгаа. Ээж, аав нар хаашаа авч авч явахаа мэдэхгүй байна. Энэ ингээд далд хэлбэрт ороод хэрэглэгч чинь улам гүнзгийрээд байна. Тийм учраас энийгээ хэдүүлээ хойч үедээ зарцуулж байгаа гэдгээр нь өгчхөөч гэж хүсэж байна.

Тэр Ганцмод-Гашуунсухайт буюу экспортыг дэмжих чиглэлийн ийм төрийн байгууллагуудын орон тоог одоо цомхотгодгоо болих хэрэгтэй. Ялангуяа гааль, хил гээд яг өдөр шөнөгүй ачаалалтай буюу энэ экспортын орлогыг нэмэгдүүлэх энэ нөхцөл байдал дээр өөрөө орон тоо нь хүрэхгүй энэ дээр ажиллах нөхцөлүүд нь хүртэл аймаар хүнд шүү дээ. Тэгэхээр би зөвхөн хил хамгаалахыг яриагүй. Энэ боомтыг, боомт дээр ажилладаг 5, 6…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Үг хэллээ. Хариулах уу? Хууль зүй, дотоод хэрийн сайд Тэмүүлэн нэмж хариулъя

Г.Тэмүүлэн: Сайнзориг сайд саяын асуудал дээр бол зарчмын хувьд байр суурь бол үндсэндээ бол нэг байгаа. Та бас яг өмнө нь намайг томилогдоод чуулганаар орж байхад бас энэ асуудлыг хөндөж бас ярьж байсан. Тэгээд Байнгын хорооноос Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос өнгөрсөн жил ч гэсэн бас яг энэ асуудалтай холбоотойгоор бас хамаарах энэ тогтоолыг бол баталж байсан байгаа. Тэгээд энэ дээр бол үндсэндээ яг иймэрхүү хамааралтай иргэдэд мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх гэдэг юм уу, сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, дэмжих төвийг байгуулах энэ зохицуулалтыг бол бас тогтоолоор хийж өгсөн.

Ингээд тодорхой хуулийн төслүүд дээр ч гэсэн бас энэ өөрөө ороод явж байгаа. Тэгэхээр бид нар бол яг цаашдаа саяын тэр сантай холбоотой асуудлыг бол илүү үр дүнтэй, иргэдийг илүү сэтгэл зүй болоод эрүүл мэнд талаас нь анхаарах, дэмжих талаас нь бол ингээд зохицуулалтыг хийгээд явах нь зүйтэй гэж бол харж байгаа. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээний тогтолцоог бол би зайлшгүй бий болгох шаардлагатай гэж бол харж байгаа. Түрүүний хувийн эрх зүйн шинэчлэлтэй холбоотой дээр бас та сайдын…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн сайд гүйцээгээд хариулчихъя.

Г.Тэмүүлэн: Ер нь ялт ч үгүй бас яг энэ салбарт бид нар энэ энэ салбарын ажилчид, албан хаагчид, тэр дундаа мэргэжлийн энэ мөрдөн байцаагч гэдэг юм уу энэ мэргэжлийн хүмүүсийн нийгэм хамгааллын асуудлыг зайлшгүй анхаарахаас өөр шаардлага байхгүй болчхоод байгаа юм. Нэг талдаа бид нар сахилга бат, хариуцлага гэж яриад байдаг. Нөгөө талдаа төрөөс үндсэндээ энэ нийгмийн хамгааллынх нь асуудлыг нь одоогийн байгаа энэ эдийн засгийнх нь боломжит нөхцөлд нийцүүлж дээшлүүлэх бол зайлшгүй шаардлага бол байна. Өнөөдөр тогтвор суурьшилтай ажиллаж байгаа юу гэдэг юм яг энэ чиглэлийн мэргэжлийн хүмүүс бол үндсэндээ бас их ховор болж байна. Ороод гардаг гэдэг юм уу, ажил алба нь сэлгээд явдаг ч гэдэг юм уу ийм нөхцөлүүд бол байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ нөхцөлтэй, байдалтай уялдуулаад энэ цалин болоод орон тооных нь энэ асуудлуудыг бол бид нар одоогийн байгаа нөхцөл байдалд нийцүүлж цаашид дээшлүүлэх арга хэмжээг бол үе шатаар авахаас өөр гарц, гаргалгаа шийдэл бол байхгүй. Сайнзориг гишүүн бас саяын тэр хувийн эрх зүйн шинэтгэлийг шинэчлэх талаар бас та ямар байр суурьтай байна вэ гэсэн. Үндсэндээ энэ Иргэний хууль бол үндсэндээ яг бага хууль…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд асуултаа асууя.

Л.Соронзонболд: Миний хувьд ийм хэдэн би бас тойрогт ажиллаж байгаад тэрэнтэй холбоотойгоор бас нэлээн хэдэн Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгууллагуудтай уулзсан. Улсын бүртгэлийн ерөнхий газраас тодруулж асуух зүйл юу байна гэхээр одоо Улсын бүртгэлийн хэлтсийн нөгөө архивын байр нь болохоор бол ийм гараашны байранд. Тэгээд бохирын шугам явж байгаа ийм өрөөнд архивын нөхцөл байдал нь ажиллаж байгаа архив чинь. Тэгээд

яг одоо хуулиараа тийм байх ёстой юу? Энийг нөхцөл байдлыг засахын тулд 2027 оны төсөв дээр улсын бүртгэлийн ерөнхий газраас ямар төсөв тусгасан бэ? Дээрээс нь бол энэ компьютер, техникийн хангамжийн асуудал нэлээн хоцрогдолтой, олон жил хангагдаагүй байгаа юм байна лээ. Энэ тал дээр энэ тоног төхөөрөмж гэсд нийт дүнгээрээ орчихсон байгаад байдаг. Яг Дорнодын Улсын бүртгэлийн хэлтэст өчнөөн компьютер хийгээд төсөвлөсөн зүйл байна уу? Нэгдүгээр асуулт.

Гадаадын иргэн, харьяатын газраас хилийн боомтоор ажиллаж байгаа ажиллагсдын амьдрах нөхцөлийг сайжруулах талаар ямар хэмжээний ажил хийхээр төлөвлөсөн бэ? Хэдэн төгрөг төсөвлөчхөөд байгаа юм бэ?

Цагдаагийн ерөнхий газар малын хулгайтай тэмцэх чиглэлээр энэ чипжүүлэх ажил хийгдээд бас тодорхой үр дүнд хүрч байна гэж Дорнод аймгийн Цагдаагийн ерөнхий газраас ярьж байсан. Тэгэхээр энэ малын хулгайтай тэмцэх чийгжүүлэх ажлыг үргэлжлүүлэхэд хэдэн төгрөг төсөвлөсөн байгаа вэ? Дорнод аймгийн цагдаагийн газрын барилгын зураг, төсөв боловсруулахад шаардлагатай байгаа төсвийг 2027 оны төсөв дээр тусгасан уу?

Дээрээс нь болохоор одоо бол Цагдаагийн ерөнхий газраас энэ аймаг, орон нутгийн цагдаагийн газруудад машин өгөхдөө дандаа хуучин машин шилжүүлж өгдөг юм байна лээ. Тэгээд ерөнхийдөө бол машинуудынх нь ашиглалтын хугацаа дуусчихсан машиныг хооронд нь шилжүүлж өгөөд байдаг. Тийм учраас 2 ширхэг машины хэрэгцээ байна гэдэг асуудал яригдаж байсан. Энэ дээр Дорнод аймагт яг төлөвлөс төсөвлөсөн зүйл байгаа юу гээд.

Дараагаар нь болохоор бол ерөнхийдөө бүх ихэнх аймагт бол энэ камержуулах ажил хийгдэж байна. Тэгэхээр энэ яаралтай тусламжийн 112 төв гээд энэ асуудал бол бас зөвхөн Цагдаагийн ерөнхий газрын асуудал биш энэ бол Онцгой байдлын ерөнхий газар Эрүүл мэндийн яамтай хамтран хэрэгжүүлж бас тодорхой төсөв зардлаа хуваах боломжтой юм болов уу гэсэн ийм асуудал яригдаж байсан. Тэгэхээр энэ тал дээр энэ Онцгой байдлын ерөнхий газар болон Эрүүл мэндийн яамтай ярьсан зүйл байгаа юу гээд Цагдаагийн ерөнхий газраас асуулт байна.

Зүүн бүсийн шүүх шинжилгээний төв мөн адилхан автомашины асуудал ярьсан. Тэгэхээр Шүүхийн шинжилгээний газар энэ чиглэлээр ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ? Ялангуяа Дорнод аймгийн хувьд 1 ширхэг автомашин, тунгаах чадвартай машин хэрэгтэй байна гэдэг асуудал яригдсан.

Прокурорын ерөнхий газраас Дорнод аймгийн прокурорын газрын барилга нь суурийн давхар ус нь байнга автдаг. Үүнтэй холбоотойгоор барилгын засвар зайлшгүй хийх шаардлагатай байна гээд 1.3 тэрбум төгрөгийн асуудал тавьсан юм байна лээ. Энэ асуудал нь энэ төсөв дээр орсон уу? Энийг яаж шийдвэрлэх гэж байгаа юм бэ? Дээрээс нь болохоор бол энэ шүүх, прокурорын байгууллагуудын ажил цахимаар их явдаг болсон. Тэгээд цахимаар явж байгаа учиртай холбоотой учраас компьютерынх нь санах ой, хүчин чадал өндөр байх шаардлагатай байгаад байдаг. Ирж байгаа компьютерынх нь хүчин чадал нь тийм муу байгаад байдаг. Тэгээд ингээд хооронд нь зөрүү үүсээд байгаа юм. Энэ талыг энийг сайжруулах тал дээр Прокурорын ерөнхий газар төсөв дээр ямар ажил төлөвлөж хийж байгаа вэ, ямар тоног төхөөрөмж худалдаж авахаар оруулж байгаа вэ гэдэг асуудал.

Хил хамгаалах ерөнхий газраас аймгийн төвийн 0-132 дугаар ангид спорт заалны барилгын асуудлыг зураг төсвийн асуудал бас ярьсан гэж ойлгосон. Энийг энэ 2027 оны төсөв дээр тусгасан зүйл байгаа юу? Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дээр бол Дорнод аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өргөтгөл барихад нь 90м^2 өргөтгөл барихаар ингээд тооцож байгаа юм байна лээ. Энэнтэй холбоотой төсөв дээр тооцож байгаа зүйл байна уу гэсэн ийм асуултууд.

Л.Мөнхбаатар: Гишүүний асуултад албан тушаалтнууд хариулна. Эхлээд улсын бүртгэлээс Дабааняам хариулъя. Дараа нь цагдаагаас Ганчулуун, Батчулуун хоёрын аль нэг нь хариулаарай. 3 номерын микрофоныг өгье.

Д.Дабааняам: Гишүүний асуултад хариулъя. Улсын бүртгэлийн байгууллага нь 21 аймагт хэлтсийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар 21 аймгаас 13 аймагт бол Улсын бүртгэлийн байгууллага өөрийн гэсэн байранд үйл ажиллагаа явуулж байна. Үлдсэн 8 аймаг нь бол аймгийн төвийн сумын төв болон аймгийн Засаг даргын тамгын газруудад үйл ажиллагаагаа явуулдаг. Улсын бүртгэлийн их нотлох баримтыг хадгалах төрийн төрөлжсөн архив бол үнэн байгаа. Эдгээр 8 аймагт бол ерөөсөө зоорины буюу В1 давхарт зориулалтын бус өрөө тасалгаанд үйл ажиллагаа явуулж байгаа. 27 оны төсөвт бид нар үндсэндээ 5 нэгжийн улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн. Үүнээс өнөөдрийн байдлаар бол Баганууур, СХД-ийн хөрөнгө оруулалтын асуудлууд өргөн баригдаад байх шиг байна. Хэлэлцэгдээд байх шиг байна. Дорнод, Налайх, Баян-Өлгий аймгуудад бол хоёр тус бүр 2.6 тэрбумын хөрөнгө оруулалттай барилгын зураг магадлал хийгдчихсэн энэ төсвийг өргөн барьсан боловч хасагдсан байна.

Л.Мөнхбаатар: Цагдаагийн байгууллагаас хэн хариулах вэ? Батчулуун бас 3 номер дээр суучих.

Д.Батчулуун: Цагдаагийн ерөнхий газраас хурандаа Батчулуун гишүүний асуултад хариулъя. Дорнод аймагт малын хулгайн гэмт хэрэгт, юу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тухай хуульд зааснаар урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, орон нутгийн төсвийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх заавал сангийн хөрөнгөөр шийдвэрлэж байгаа. Дорнод аймгийн хэмжээнд малын хулгайтай холбоотой чипт суурилуулалт зардал бол цагдаагийн байгууллагын төсөвт бол энэ жил орж тусгагдаагүй.

Автомашины талаар хэлье. Автомашин дээр сүүлийн 2, 3 жилд цагдаагийн байгууллагын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар явсан 2 удаа машин тэрэг худалдаж авсан. Үүнээсээ Дорнод аймгийн цагдаагийн газарт 2, Хууль зүйн яамнаас цагдаагийн байгууллагаас 2 машин өгсөн байна. Land Cruiser 76, Спа… гээд 2 шинэ машин өгсөн. Хуучин машин өгч байгаа асуудал дээр бол авто баазаас парк шинэчлэлтийн хүрээнд нэгжүүдийнх нь санал ирвэл аваад бид нар засаад үргэлжлүүлээд хэрэглэе. Хэсгийн байцаагч төлөөлөгч нартаа хэрэглүүлье гэвэл саналынх нь дагуу хуучин машин олгож байгаа тохиолдол байгаа. Дорнод аймгийн цагдаагийн газар…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя.

Д.Батчулуун: Дорнод аймгийн цагдаагийн газрын барилга, шинэ барилгын зураг төсөв хийлгэх санал энэ төсвийн төсөл дотор явж байгаа.

Л.Мөнхбаатар: Хил хамгаалах ерөнхий газар. Камержуулалтаа дуусгачхаарай. Батчулуун аа. Камержуулалтын талаар түрүүн асуулт асуучихсан. Тэрийгээ ярьчих даа. Камержуулалт хийгдэж байгаа талаарх асуулт асуусан шүү дээ Соронзонболд гишүүн. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Батчулуун хурандаа хариулчихъя.

Д.Батчулуун: Цагдаагийн байгууллагын төсөвт бол ямар нэгэн байдлаар камержуулалттай холбоотой зардал тусгагдаагүй. Тийм санал бол байхгүй байгаа. Дараа нь Соронзонболд гишүүн яах вэ тодруулж асуухдаа асууж байя. Хил хамгаалах ерөнхий газар. Бямбасүрэн генерал хариулъя.

Ж.Бямбасүрэн: Гишүүний асуултад хариулъя. Хилийн цэргийн 0132 Дорнод аймгийн төв дээр 27 оны төсөвт бол спорт заалны барилгын ажил тусгагдаагүй байгаа. Манай дээр зураг бол үндсэндээ бариулж холболт хийх спорт заалны зураг бол байгууллагын хэмжээнд бол зураг нь бол байгаа. Төсөв нь бол тавигдаагүй 27 онд.

Л.Мөнхбаатар: Шүүх шинжилгээ. Шүүхийн шийдвэрийнхэн хариулчих. Дараа нь Шүүхийн шийдвэр бэлэн байж байгаарай.

Г.Цэргийнхүү: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга Цэргийнхүү. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Дорнод аймгийн Зүүн бүсийн албадан эмчлэх төв дээр орон нутгийн хөрөнгө оруулалтаар сая байрны нэмэлт байрны асуудлыг өргөтгөл хийгдсэн байгаа. 27 онд бол ямар нэгэн улсын төсвөөс төсөв тавигдаагүй байгаа.

Л.Мөнхбаатар: Шүүх шинжилгээнийхээ асуултад хариулъя.

Н.Ганбаяр: Шүүх шинжилгээний ерөнхий газраас гишүүний асуултад хариулъя. Автомашины парк шинэчлэлтэй холбоотой асуудлаар бүх аймгууд дээрээ бид нар дуудлагын автомашины хэргийн газрын автомашины санал хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар батлагдаагүй байна.

Л.Мөнхбаатар: Улсын ерөнхий прокуророос Чулуунбат хариулъя.

Д.Чулуунбат: Улсын ерөнхий прокурорын газар Чулуунбат. Гишүүний асуултад хариулъя. Манайх прокурорын байгууллага маань үе шаттайгаар ба компьютер, техник тоног төхөөрөмжийг шинэчилж байгаа. Өмнө жил авах ёстой мөнгө тодотголоор одоо тавигдаж байгаа учраас бид нар энэ жил аваад үе шаттайгаар Дорнод аймаг болон зүүн бүсийн тодорхой аймгууд дээр компьютерыг шинэчилнэ. Энэ нь болох дээрээ худалдан авах ажиллагаагаараа тендер нь зарлагдаад тендерийнх нь компани нь шалгарчихсан байгаа. Тэгээд одоо мөнгө нь шилжигдэх юм бол бид нар компьютер, техникийн … шинэчлэх ажил явагдаж байгаа. Дорнод аймгийн прокурорын газрын хувьд усанд автдаг. Тэгэхдээ Дорнод аймгийн прокурорын газар өнөөдрийн байдлаар энэ усанд автдаг талаараа төсөвт санал ирүүлээгүй байгаа. Бид нар төсөв болон зургийг нь хийгээд явуул гэдэг үүрэг даалгавар өгсөн. 27 оны төсөв дээр одоохондоо бол санал ирээгүй байгаа.

Л.Мөнхбаатар: Чулуунбат аа энэ танайх жишиг барилга бариад байгаа шүү дээ прокурорын? Хэдэн аймаг дутуу байгаад байгаа юм? Дээр нь сая Соронзонболд гишүүний асуугаад байгаа Дорнод аймгийнх нь шинэ барилга дээр усанд автаад байгаа юм уу? Хуучин барилгаа яриад байна уу? Ажлын хэсгийн 3 дугаар микрофон дээр.

Д.Чулуунбат: Дорнод аймгийн прокурорын газар 2013 онд ашиглалтад орсон. Тухайн гүйцэтгэгч компанитай бид нар шүүхцэлдчихсэн байгаа. Шүүхээр шийдвэр гаргаад ер нь ерөнхийдөө бол Дорнод аймгийн прокурорын газрын барилгыг барихдаа үерийн усны аман дээр барьчихсан юм байна лээ. Жоохон бороо орохоор л ус орж ирчхээд байдаг. Тэгээд тэр талтай холбогдуулаад 2 удаа гүйцэтгэгч компаниар нь янзлуулсан байгаа. Одоо жишиг барилгаар бол энэ жил Орхон аймаг, Говь-Алтай аймаг гэсэн 2 аймгийн прокурорын газрыг барилга бариулахаар төлөвлөчихсөн байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу та? Соронзонболд.

Л.Соронзонболд: Энэ гудамж бүх замын хөдөлгөөний дагуу чинь бүгдэд нь ер нь камержуулалт хийгдээд байна л даа аймаг болгонд. Аймгийн төсвийн хөрөнгөөр ч хийгдэж байна. Тэгээд тэр аймгийн нэгдсэн хяналтын төв байх шиг байгаа юм камерын хяналтын. Тэр Камерын хяналтын төв дээр тэр нөгөө нэгдсэн дуудлагын төв гээд 112 гээд Цагдаагийн ерөнхий газрын юун дээр уул нь байх шиг л байсан л даа. Тэгээд тэрний нөгөө цаад хэрэглээг нь харахаар зөвхөн Цагдаагийн ерөнхий газар биш Онцгой байдлын ерөнхий газар, эмнэлэг ингээд ашиглах ийм боломжтой байна гэж ойлгосон байхгүй юу. Тэгэхээр Цагдаагийн ерөнхий газар дээр болохоор бол нөгөө оператор зардлууд нь тусчхаад байдаг, орон тоо нь байдаггүй. Тэгээд энэ асуудлаа шийдэхдээ бол Онцгой байдлын ерөнхий газар Эрүүл мэндийн яамтай яриад тодорхой зардлаа хуваалцах байдлаар шийдэх ийм боломж байгаа юм биш үү л гэж асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бол Хууль зүй, дотоод хэргийн яам юм уу эсвэл Цагдаагийн ерөнхий газар л хариулах хэрэгтэй байна л даа.

Л.Мөнхбаатар: Сангийн сайд Мэндсайхан сайд нэмж хариулъя.

З.Мэндсайхан: Соронзонболд гишүүний асуултад нэмээд тайлбар өгчихөд орон нутгийн тэр хөдөлгөөний аюулгүй байдлын теле камер Дорнод, Булган, Орхон, Баян-Өлгий, Увс, Завхан, Ховд байсан байх байх аа нийтдээ 8 аймаг дээр, 7 аймаг дээр 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төсвийн хөрөнгө оруулалтаар суусан.

Ер нь зүгээр хууль зүйн салбарын төрийн тусгай албан хаагчдын цалин хөлс нийгмийн баталгаа, тэр дундаа нөгөө онцгой нэмэгдэл унаа, хоолны нэмэгдэл, бусад салбаруудтайгаа дүйцүүлэх асуудлаа салбар нь өөрөө тэргүүн ээлжид эрэмбэлсэн. Тэр дагуу бол төсвийн төсөлд тусгаж өгсөн байгаа 27-ны төсөлд. Амарсайхан сайд энэ хөрөнгө оруулалтын асуудлаа ер нь салбарын төсвийн асуудлаа эрэмбэлээд яагаад эрэмбэлж байна гэхээр бид нар нэгэнт орлого хязгаартай учраас салбарын тэргүүн ээлжийн юуг шийдэх ёстой асуудлаа эрэмбэлэхээс өөр замгүй. Ингээд эрэмбэлж оруулсан байгаа. Зүгээр хууль зүйн салбарын хөрөнгө оруулалтын төсвийн хязгаар бол 40.7 тэрбум байсан. Энэ жилийн 27 оны төсөвт өргөн барьсан нь 98.8 байгаа шүү. Ингээд нэмэгдээд орсон байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Хариулт болчихсон уу Мэндсайхан сайд аа? Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Нэгдүгээрт цагдаагийн холбоотой асуулт байна Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн цагдаагийн алба хаагчидтай сая энэ хавар зун уулзсан. Тус бүрээс нь ойролцоогоор 10 орчим орон тоог ингээд хасчихсан. Зарим нь санхүүч байхгүй. Хэмнэлт гээд ингээд нэгдсэн журмаар ингээд хасчихсан. Гэтэл гэмт хэрэг зөрчил нь бол жилээс жилд ихсээд байдаг. Ялангуяа энэ Төв аймаг, Дархан, Сэлэнгэ 3 чинь Монгол Улсын хэвтээ, босоо тэнхлэгийн гол ачаалал өнгөрч байгаа хүн амын 60, 70 хувь нь аж төрж байгаа. Асар их асуудал гардаг. Ингээд нэгдсэн журмаар ингээд орон тоог нь хасчихдаг. Яг алба хаагчидтай дарга нарынх нь дэргэд уулзаж байхад бол юм хэлэхгүй. Зүгээр тусдаа бол ямар мэдээллүүд ирүүлдэг вэ гэхлээрээ энэ хувцасны чанарын асуудал. Нөгөө гутал нь чийг татах ч гэдэг юм уу, өмсөж байгаа хувцас нь үүрэг гүйцэтгэхэд шаардлага хангахгүй байх, хөлрүүлдэг сүүлийн үеийн хувцаснууд тийм байна. Маш олон хүмүүсээс ирж байгаа санал шүү дээ. Тэгээд энэ яаж байна гэхлээрээ нөгөө тендер нь яаж явагддаг юм энд? Ер нь яг тэн дээр ямар хүмүүс хяналт тавьдаг юм? Хэдэн мянган хүн алба хаагчдын ялангуяа бол жагсаал хувцас биш яг өдөр тутам үүрэг гүйцэтгэдэг хээрийн ч юм уу энэ хувцаснуудын чанар, стандарт нь яаж хангагдаад байна? Энэ дээр бол онцгой бүүр анхаарч алба хааж байгаа хүмүүс дээрээ анхаармаар байгаа.

Хоёрдугаарт, Тээврийн цагдаагийн албан дээр яг энэ өвөл, зунгүй утаатай болчихсон. Яг энэ ажил үүргийнх нь хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор энэ онцгой хэрэг үед хэрэглэх утааны маск ч гэдэг юм уу яг энэ тухайн хүнээ бас бодох, хүний эрхийн наад захын мэдрэмжтэй байхад энэ төсвөө уях зайлшгүй шаардлагатай байгаад байгаа. Энэ талаар мэдээлэл авмаар байна. Мөн бас хэд хэдэн хилийн цэргийн ангиуд орж үзсэн. Бас яг ингээд хувцас хангалт сүүлийн үед ирж байгаа ч гэсэн чанар гэхээсээ илүүтэйгээр тухайн хүн хүний яг эргономикт таарсан хувцасны асуудал бас байгаад байгаа. Энэ дээр яг ямар та нар стандарт хил хамгаалах газар барьдаг юм? Яг энэ алба хаагчдын хувцасны хангалт дээр өнөөдрийн байдлаар хэчнээн төрлийн компани, аж ахуйн нэгжүүд тендерт ордог юм?

Дараагийн асуулт нь энэ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Байнгын хорооны даргаар ажиллаж байсан Дамдины Цогтбаатар гишүүн бид хэд бас Дундговь аймаг, дараа нь Төв аймгийн шүүхүүдээр орж байсан. Үйл ажиллагаа асар хүнд. Одоо яг мөөгөнцөртчихсөн байранд л үйл ажиллагаа явуулдаг. Ингээд төсвийг нь оруулах гээд явсан боломж байгаагүй гээд хасчихсан. Энэ дээр Сангийн яам ямар эх сурвалжаар гарах боломжтой байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ер нь энэ дээрээ саналуудаа хэлмээр байна. Эдгээр асуудалд хариулт аваадахъя.

Л.Мөнхбаатар: Цагдаагийн байгууллагаас хариулъя. Дараа нь Шүүхийн ерөнхий зөвлөл бэлдэж байгаарай. 3 номерын микрофоныг өгье.

Д.Батчулуун: Цагдаагийн ерөнхий газраас хурандаа Батчулуун. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагаас 25 оны төсвийн тодотголоор 770 орон тоо хасагдчихсан. Энэ орон тоонууд тэгээд цагдаагийн байгууллагаар байгууллага дээр хасагдсан. Зарим нэгжүүд дээр бас 10 орчим орон тоо хасагдсан нь үнэн. Тэгээд энэ жилийн төсвийн төсөлд энийгээ бас

буцааж авах нэмэгдүүлэх талаар бас санал явуулсан. Тэгэхдээ дэмжигдээгүй байгаа.

Дүрэмт хувцасны тухайд бол цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагчдын хувцсыг Засгийн газрын тогтоолоор баталсан тогтоолоор, дотоодын цэргийн алба хаагчдын хувцсыг бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан төрийн цэргийн байгууллагуудын хувцсаар явдаг. Нээлттэй ил тендерээр зохион байгуулагддаг. Сүүлийн жилүүдэд бол бас сүүлийн 2 жил цагдаагийн байгууллагын дүрэмт хувцасны төсөв өсөж байгаа. Өмнө нь бол бас харьцангуй бага байсан учраас бэлдэх шаардлагатай тоо хэмжээгээр бэлдэж чадахгүй асуудал байдаг. Өгөх ёстой хугацаандаа өгч чадахгүй байгаа асуудал, нэр төрлийн цөөн байгаагаас эд нар нэг төрлийн хувьцаа удаан хугацаанд үүсэхтэй эд нар холбоотой тийм асуудлууд гардаг байсан.

Стандартыг бол Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаараа баталсан байдаг. Энэ 2012-оос 18 оны үед бас энэ дүрэмт хувцастай холбоотой энэ Техникийн их сургуулийн энэ олон докторууд орсон ажлын хэсэг олон улсын туршилт, шинжилгээний үр дүнд олон улсын жишигт нийцүүлэн гаргасан ийм дүрэмт хувцасны стандарт байдаг. Тэгээд судалгааны ажил бол байнга явдаг. Бага багаар бол ингээд шаардлагатай хувцаснууддаа өөрчлөлт тогтмол ороод явж байгаа.

Л.Мөнхбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөл хариулъя. Золзаяа дарга бас шүүхийнхээ төсөвтэй холбоотой асуудлаа ерөнхийдөө бас хариулсан нь зөв байх. Хууль зүйн байнгын хороо хянагдсан төсөв, сая Засгийн газраас өргөн баригдсан төсөв хоорондын нийцэл нь ямар байгаа юм, хэдээр буурсан юм? Хоёрдугаарт уг хянагдах үед байсан аймгуудын асуудал яригдаж байна шүү дээ Дундговь, Төв аймгийн шүүхийн төсөвтэй холбоотой асуудлуудыг гишүүд асуугаад байна. Тийм учраас энийгээ хамтатгаад хариулчих. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

П.Золзаяа: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Хууль зүйн яаманд биш ээ, Хууль зүйн байнгын хороонд хянагдсан төсвийн хэмжээ бол 646 тэрбум байгаа. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь 333 тэрбум байна. 312 тэрбумаар багасгасан. Үүн дотроо хөрөнгө оруулалтын нийтдээ 248 тэрбум байсныг 38 тэрбум болгож ийм өргөн мэдүүлж байгаа. Энд баригдаж байгаа барилгын санхүүжилт нь нийтдээ бол 38 тэрбум байгаа. Энийг л шийдсэн. Шинээр барих барилга бол ямар ч хөрөнгө оруулалт байхгүй байгаа.

Энэ барилгын тухайд гэвэл шүүхийн барилгууд угаасаа эхнээсээ шүүхийн зориулалттай байгаагүй. Дандаа өөр зориулалтаар бас барилгуудад үйл ажиллагаа явуулж байгаа. Хамгийн тулгамдсан жишээлбэл Завхан аймаг гэхэд 2014 онд ашиглалтын шаардлага хангахгүй гэсэн ийм акт гарсан. Одоо 10 жил гаруй энэ үйл ажиллагаагаа энд явуулж байна. Өмнөговийн Ханбогд сумын Сум дундын…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя.

П.Золзаяа: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Сум дундын шүүх гэхэд өөрийн байргүй сумын Засаг даргын эзэмшлийн байранд үйл ажиллагаа явуулдаг. Дундговь аймгийн шүүх бол маш жижиг талбайтай ийм 70 оны барилгад халаалт нь хувийн байгууллагаас авдаг ийм доголдолтой байнга энэ шүүхийн байр. Төв

аймгийн байруудыг бол нэн шаардлагатай байгааг хэлмээр байна. Мөн цахимжилттай холбоотой төсвийг бол бүгд 0 байгаа. Тэгэхээр цахимжилтын хүрээнд бол дор хаяж энэний суурь болсон нөгөө тоног төхөөрөмжийн зардал нь 7 тэрбум, үүнтэй холбоотой бас бусад нөгөө тоног төхөөрөмжид нийлээд 10 тэрбум байгаа энэ асуудлыг бүгд хасчихсан учраас энэ үйл ажиллагаа цаашаа яаж явах бол гэдэгтэй дээр бол нэлээн бас хүндрэлтэй байгаа.

Л.Мөнхбаатар: Та яах юм тодруулах юм уу? Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Одоо энэ Завхан, Дундговь, Төв аймаг гээд энэ 3 газар дээр жишээлбэл Сангийн яам боломжит хариултыг өгмөөр байна эх сурвалж талаасаа. Нэг. Дээрээс нь түрүүн тэр Батчулуун хурандаагийн хариулт дотор бол хэд төсөв нэмэгдэж байгаа, алба хаагчдын төсөв нэмэгдэж байгаа гэж байгаа ч гэсэн энэ яг хангалттай байж чадаж байна уу үгүй юү? Яагаад гэхлээр би бол алба хаагчдаас өөрсдөөс нь шууд асуугаад ингээд хувцсанд чийг цохиод байна гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь бол 10 жилийн өмнөх стандарт яригдаж байна. Одоо энэ дээр бол ийм шинэчилсэн зүйл хийх зайлшгүй шаардлага харагдаад байгаа юм.

Хоёрдугаарт тэр Батчулуун хурандаагаас хариулах юм уу, Хууль зүйн сайд хариулах юм уу яг ингээд шударга ёс тогтоох яг ингээд нүүр тулж ажил хийж байгаа хүмүүсийнхээ юуг хасчихдаг орон тоог хасчихдаг. Жишээлбэл манай ингээд Улаанбаатар хотын бүх зүг рүү Төв аймаг руу гарч байгаа шүү дээ. Тэгэнгүүт нөгөө тэнд байгаа. Ингээд сумын цагдаа нар хүртэл давхар нэмэлтээр ажиллаж байгаа. Амжихгүй байгаад байгаа.

Эдийн засаг, хөгжлийн хөгжлийн яамнаас нэг зүйлийг асуучихмаар байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн захирлуудын цалин өндөр байна гээд иргэд маш бухимдалтай байгаад байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариулъя. Энэ дээр бас би тодотгоод бас 2 зүйлийг бас нэмээд асуучихъя. Гишүүд бас асуугаад байгаа учраас. Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2027 оны төсвийг бол 646.5 тэрбум төгрөгөөр хянаад явуулсан. Энийг Засгийн газар өргөн мэдүүлэхдээ 312.6 тэрбум төгрөгөөр бууруулаад 333.9 тэрбум төгрөгөөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлчхээд байгаа. Ер нь бол Шүүхийн тухай хуульд заасан холбогдох заалтын дагуу бол шүүхийн Хууль зүйн байнгын хорооны хянасан төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд ирүүлэх ийм үүрэг хүлээдэг. Тэгээд энэ хоёрын хоорондох зөрүү дээр л манай Их Хурлын гишүүд, Сангийн яам болоод холбогдох байгууллагуудын байгууллагуудынхан яриад яриад байна яриад байна. Энийг тойрч бичүүлээд байгаа учраас. Энд бол яах вэ мэдээж төсөв хүндрэлтэй байгаа нөхцөл байдлуудыг хэдийгээр ойлгож байгаа ч гэсэн зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байгаа хэд хэдэн төсвийн асуудлууд байгаа. Энийг бас манай Сангийн яамныхан анхааралд бас хариулаарай гэж хэлье. Энэ нийтдээ 105.3 тэрбум төгрөг зайлшгүй байна гэж эдгээр байгууллагууд манай шүүхийн болоод холбогдох байгууллагууд хэлээд байгаа юм. Энд бол эхний нь бол нийслэл дэх энэ Гэр бүл, хүүхдийн болон анхан шатын давж заалдах шатын шүүхийн барилгын эхний жилийн санхүүжилт шаардлагатай байгаа. Энэ бол 15 тэрбум тэрбум төгрөг гэж байгаа.

Шүүх хуралдааны дуу, дүрсний бичлэг шууд дамжуулалтын техник гэж байгаа. Энэ бол сая Хууль зүй, дотоод хэрийн сайд Тэмүүлэн бид хэд ч Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчтэй хамт явж Архангай аймагт ажилласан. Энэ бол аймгуудад болоод шүүх хуралдааны танхимаас бас энэ авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой тодорхой хэргүүдийг шууд дамжуулах ийм үүрэг хүлээсэн ил, тод нээлттэй байж дамжуулах хуулиар хүлээсэн үүрэгтэй. Энийгээ биелүүлэх боломжгүй байгаад байна. Ерөөсөө нэг тасалгааны камер тавьчихаар хэлбэрийн төдий болчхоод байна. Яагаад гэвэл дуу, дүрс, хүн нь танигдахгүй ийм л байна. Энийг шийдэхэд 10 тэрбум төгрөг шаардлагатай байна гэж үзэж байгаа юм байна лээ.

Хэд хэдэн аймгуудын барилга байна. Энэ сая Завхан, Төв, Дундговь аймаг, энэ Өмнөговийн Ханбогд бол сумын Тамгын газар дотроо байрлаад байгаа бие даасан хараат бус байх энэ шаардлага бол байгаа. Тэгээд урсгал зардал тай холбоотой гэсэн ийм зүйлүүд бол нь байгааг бол манай Сангийн яамныхан маань бид бол энэ дээр дүгнэлттэй оруулаад явуулна. Сангийн яамныхан нэгдүгээрт хариулах хэрэгтэй. Хоёрдугаарт Сангийн яам болоод Улсын Их Хуралд байгуулагдах тэгээд төсвийн ажлын хэсгийнхэн бол энэ дээр анхаарч тодорхой шийдэл гаргах шаардлагатай байна гэдгийг та бүгдэд бас хэлье гэж бодож байна.

Ингэхээр энэ шүүхтэй холбоотой энэ асуудлууд дээр Сангийн яам болоод Эдийн засаг, хөгжлийн яам бас сая Эрдэнэболд гишүүний асуултад хариулах хэрэгтэй. Орон тоотой холбоотой асуудал дээр цагдаа юу? Тэмүүлэн сайд уу? Ингээд энэ 3 яам хариулъя. Хэн хариулах вэ? Эхлээд Сангийн сайд Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Ер нь Шүүхийн хуулираа бид нар төсвийг нь бууруулахгүй оруулж ирэх учиртай хууль нь ийм. Бид бол мэдээж Засгийн газар хуулиа өргөн барихдаа Төсвийн тухай хуулиа л баримталж оруулж ирж байгаа. Энэ хоорондын зөрчил явагддаг. Байнга л яригддаг асуудал. Төсвийн хязгаар бол Шүүхийн ерөнхий зөвлөлийнх 33 тэрбум төгрөг байсан. Өргөн барьсан төслөөрөө 38.1-ээр өргөн баригдаж байгаа. 5 тэрбумаар нэмэгдээд явж байгаа. Нийтдээ шүүх дээр бол 5 аймаг шүүхийн барилга барих гэж байна. Хан-Уул дүүрэг дээр шүүхийн нэгдсэн цогцолбор хэрэгжиж байгаа. Энэний төсөвт өртөг 18 тэрбумаар нэмэгдсэн энэ асуудлыг нь шийдвэрлээд оруулаад ирж байгаа. Гишүүний асуугаад байгаа тэр Дундговь аймгийн асуудал бол ийм санал бол ирээгүй. Энийг бол бас та тодруулах нь зөв байх. Тэр танагдсан асуудал гэдэг бол энэ хэрэгжээд явж байгаа. Би хариулчихъя. Дараагийнх нь болохоор зэрэг тэр танагдсан асуудал гэдэг бол…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Мэндсайхан сайд гүйцээгээд хариулчих. Микрофон өгье. Мэндсайхан сайдын микрофоныг өгөөрэй.

З.Мэндсайхан: Гантөмөр сайд Эдийн засаг, хөгжлийн сайд байхдаа хөгжлийн төлөвлөгөө батлуулахдаа 9 хувиар төрийн албан хаагчийн энэ юуг танах хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. Энэний дагуу танагдаад явсан асуудал байгаа.

Л.Мөнхбаатар: Төсөв дээр ажлын хэсэг гарах байх. Сангийн яам бас тодорхой эх үүсвэрүүдийг гаргаад ажлын хэсэг дээр бас эх үүсвэрүүдээ гаргаад энэ дээр ярилцах нь зүйтэй шүү. Энэ шүүхийн төсөвтэй холбоотой асуудлууд. Мэдээж хуулиар хүлээсэн үүрэг байгаа. Төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлын энэ

уялдаа, балансыг нь бас бариад явах нь зүйтэй гэж бодож байна. Нэмж хариулах зүйл байгаа юу? Хэн Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Ер нь энэ хуулийн, Шүүхийн шүүхийн хуулиараа тусгах гэж байгаа хөрөнгө оруулалтыг. Бид нар Засгийн газар Улсын Их Хуралд Төсвийн хуулиа л өргөн барьж төсвийн хязгаар, орлого дээрээ л хязгаарлагдаж байгаа шүү дээ. Гэхдээ бид бас зүгээр суугаагүй. Ер нь цаашдаа энэ бол шүүх засаглалыг хараат бус байдлыг хангах чиглэлээр Засгийн газар, бид нар Засгийн газар дээрээ ч ярьсан. Энэ асуудлыг ер нь олон улсын зээл, тусламжаар 1 удаадаа энэ шүүхийн санхүүгийн асуудлыг шийдье гэж 2, 3 эх үүсвэр рүү ханд сан байгаа. Нэг хүндрэлтэй асуудал нь бол арилжааны зээлээр явах юм байна лээ. 2 улсаас, 2 донороос бол ерөнхийдөө дэмжих юу ирчихсэн байгаа. Ерөнхийдөө Сангийн яамны Засгийн газрын барьж байгаа бодлого бол цаашид бид нар 100 сая орчим долларын яг энэ шүүхийн энэ та гишүүдийн яриад байгаа хөрөнгө оруулалтын асуудал дээр шийдэж өгөөд явахгүй бол болохгүй юм байна гэдэг ийм байр суурьтай байгаа. Энэ асуудал дээр Сангийн яам ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Мэндсайхан сайдын хувьд маш их зөв, зүйтэй санал шүү. Ер нь бол шүүхийн барилга, шүүх хуралдааны танхимууд, түүнтэй холбоотой зардлууд бол 1 удаагийн л зардал болно шүү дээ. Тийм учраас 1 удаа шийдчих юм бол ингээд иргэдэд эд нар үйлчлэх, шүүхийн үйлчилгээ хүргэх ажил бол ингээд шийдэгдчих юм байгаа юм. Гэхдээ энэ удаагийн төсөв дээр Мэндсайхан сайд аа та бас манай Шүүх ерөнхий зөвлөлийнхөн болоод холбогдох хүмүүстэй сууж байгаад шүүхийн энэ төсвийн хэлэлцүүлгийн явцад бас анхаарч тусгах шаардлагатай байгаад тодорхой зардлууд дээр анхаарч ажиллана шүү. Тэмүүлэн сайд хариулъя. Орон тоотой холбоотой асуудал байна. Тэмүүлэн сайдын микрофоныг өгөөрэй.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Тэгээд яг үндсэндээ өнгөрсөн хавар бид нар энэ орон тооны цомхотгол буюу 9 хувийн нэгдсэн байдлаар ерөнхийдөө тооцоо судалгаа багатайгаар бас ингээд нэгдсэн шугамаар, массаар нь ингэж халсан асуудал бол бас өөрөө тодорхой сөрөг үр дагаврууды бол орон нутагт авчирсан байгаад байгаа юм. Тэгээд бид нар ч гэсэн зөвхөн зүгээр юу гэдэг юм манай энэ хууль хяналтын байгууллагууд ч биш хөдөө орон нутаг дээр мал эмнэлэг гэдэг юм уу, бусад өөр дийлэнх яг төрийн үйлчилгээ хүргэж байгаа төрийн байгууллагууд дээр бол яг нэгдсэн ийм асуудлууд бол үүссэн байна.

Тэгэхээр бид нар үндсэндээ энэ орон тоог хасахдаа нэг талдаа механикаар үзэмжээр биш, яг бодит үр дүн, шинжилгээнд суурилж байж хийх зайлшгүй шаардлага бол байна. Тэгэхээр би салбарын хэмжээнд бол ажил аваад хийх ёстой чиг үүрэг асуудал бол энэ чиг үүрэг болоод ажлын ачааллын судалгаа хийх бол зайлшгүй шаардлагатай байна Яг салбар болгон дээр, байгууллага хоорондуур дээр бол бол тодорхой тэр давхардсан чиг үүргүүд байна уу үгүй юү, тэрийг илрүүлж гаргаж ирээд тухайн ажлын цаг ашиглалтыг нь…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Болсон уу? Эдийн засаг, хөгжлийн яам хариулаарай. Хэн байна? 3 номер дээр суучихъя. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яам Макро эдийн Засгийн газрын дарга Мөнх-Эрдэнэ. Гишүүний асуусан асуулт төрийн өмчийн компаниудын захирлуудын цалинг асуусан. Ер нь бол Эдийн засаг, хөгжлийн яам Төрийн өмчийн

компаниудын захирал, албан тушаалтнуудын цалингийн бодлого, цалинг тогтоох тэр зүйлийг бол хийдэггүй. Зүгээр бидэнд байгаа судалгааны албан мэдээллээр бол төсөвт байгууллагуудын дундаж цалин оны эхний хагас жилийн байдлаар 3 сая 90 мянган төгрөг, харин төрийн өмчийн компаниудын дундаж цалин дунджаар 3 сая 600 мянган төгрөг орчим, хувийн компаниудын дундаж цалин дунджаар 3 сая 200 мянган төгрөг гэсэн ийм статистик мэдээллүүд байна. Статистикийн хорооноос гаргасан мэдээллээр.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл асуултаа асууя. Та тодруулчихсан шүү дээ. 1 удаа тодруулчихсан даа. Эрдэнэболд гишүүн тодруулаад асуучихъя. Дараа нь Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Тэмүүлэн сайд аа таныг ажлаа аваад удаагүй байгааг ойлгож байна. Гэхдээ их юм судлаад байх шаардлага байхгүй. Бодит амьдрал дээр наадах чинь ачааллаа дийлэхгүй байгаа. Дипломат хариулт битгий хэл. Шууд энэ асуудлаа ингээд гарцаагүй байна гээд хэл л дээ. Цагдаагийн ерөнхий газар ч гэсэн энэ дээрээ судалгаанууд нь бэлэн байж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр юу гэдэг юм зарчмын зөрүүтэй санал ч гэдэг юм уу ингээд оруулж ирэх дараагийн хурал дээр оруулж ирэх дээр анхаарах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, Эдийн засгийн хөгжлийн яам аягүй бөөрөнхийлөөд байна. Энэ 770 цагдаагийн албан хаагчаас 770 хүнийг тандсан байгаа шүү дээ. Тэр төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн захирлын чинь цалин Монгол Улсын иргэдийн дунд дундаж цалингаас хэд дахин илүү байгаа юм. Бараг энэний гуравны нэгийг нь цалинжуулчих хэмжээний асуудал байгаа байхгүй юу. Мөнгө байхгүй гэж хэлээд байгаа ч гэсэн тэр мөнгийг зөв газраа үр ашигтайгаар хуваарилж энэ хүний эрхийг дээдэлсэн шударга ёсыг сахиулах үйл хэрэгт л оруулаач гэж байгаа шүү дээ. Тийм учраас ийм тайлбар тавихаасаа илүүтэйгээр шийдэл рүүгээ хандаад гаргалгаануудаа оруулж ирээч байгууллагууд.

Л.Мөнхбаатар: Санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл асуултаа асууя.

О.Алтангэрэл: Би энэ нөгөө Архины сангийн асуудлыг удаа дараа тавьж байгаа. Хууль зүй, дотоод хэрийн сайдаар ажиллаж байхдаа ч тавьсан. Жил болгоны төсөв дээр ярьдаг. Тэгээд тэр төсөвт багтаад явдгийг бол ойлгож байгаа. Тэр тоонд ороод. Тэгэхдээ эх үүсвэр нь энэ чинь төрийн мөнгө биш шүү дээ. Одоо Мэндсайхан сайд аа, Санжаадорж дарга аа, Сангийн яамныхан энийг багтаагаад эмнэлэг барьчихмаар байна. Мааньтын албадан эмчилгээ яриад байгаа юм.

Мааньтын албадан эмчилгээ дээр чинь байна шүү дээ хүнийг архины албадан эмчилгээнд аччихаад очоод 2, 3 удаа рингер хийвэл хийсэн болоод ингээд байж байгаа. Төсөвгүй газар байхгүй юу даа. Энэ мансууруулах бодисын улмаас хуруу, гараа тариулж байгаа хүүхдүүдийн өмнөөс, тэр шаналж байгаа аав, ээжүүд, донтолтод нэрвэгдчихсэн хүмүүсийн өмнөөс Сангийн яамныхан та нараас хүсэж байна. Гуйж байна. Тэр холбогдох саналыг нь гаргачихна гишүүд. Энийг тэр 20 тэрбум төгрөгөөр ганц донтолтын эмнэлэг байгуулчих л даа. Улсын төсвийн мөнгө биш шүү дээ. Энийг ингээд шийдээдэх л дээ. Энэ маш чухал асуудал нь.

Хоёр дахь нь энэ Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс асуулт байна. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал ер нь хэр хүнд байна вэ? Ер нь эмнэлэгт энэ санхүү, мөнгөн дээр тулгамдаж байгаа асуудал ер нь юу байна? Хэвийн үйл ажиллагаагаа явуулж чадаж байна уу, үгүй юү, төсөв хөрөнгө ямар байна гэдэг дээр эмнэлгийг нэг сонсмоор байна.

Дараагийнх нь Шүүх шинжилгээний ерөнхий газар, Өвөрхангай аймгийн Шүүх шинжилгээний ерөнхий газар, хуучин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ашиглаж байсан давхар байранд ороход хөгц, чийг үнэртсэн, гэрэлгүй, харанхуй хэзээ нурах нь мэдэгдэхгүй байранд хэдэн албан хаагч нар сууж байгаа юм. Үгүй тэр дотроо зүгээр ажилтай танилцаад явж байхад ингээд нярайн цогцос ингээд хадгалчихсан, саванд хийгээд хадгалчихсан, хайрцагт хийгээд хадгалчихсан тэр байрандаа байж байгаа байхгүй юу. Энэ чинь юу гэсэн үг вэ. Энэ байрны зураг төсөв, тэр мөнгө төгрөг гаргаад зураг төсөв нь хийгдээд ингээд явсан. Энэ төсвийн төсөл дээр алга. Энэ хаана хасагдчихав? Яг хэдэн төгрөг хэрэгтэй байна. Ингээд албан хаагчид ингээд нярайн цогцсыг ингээд занданшуулсан хэлбэрээр хадгалаад байж байгаа, дээжүүдээ хадгалж байгаа ийм байранд Өвөрхангай аймагт нүд халтирам байранд тэр шүүх шинжилгээний байгууллагын албан хаагчид байна. Санал нь хаана хасагдчихав? Та хэд саналаа өгсөн үү үгүй юу гэдгийг асууя.

Гуравд дараагийнх нь прокуророос асууя. Энэ цалингийн дутагдлын асуудал сая би тодотгол дээр асууж байсан. Цалингийн дутагдал гараад шинээр албан хаагчдаа ер нь зарим томилж чадахгүй дутуу орон тоон дээр хүн томилж чадахгүй байсан. Энэ төсөв дээр ер нь прокурорын байгууллагын хувьд ямархуу төсөв болов, төсөл болов? Асуудал тус чадав уу гэдэг дээр эдгээр асуултад хариулъя.

Л.Мөнхбаатар: Сангийн яам хариулъя. Эхний асуултад Архидан согтуурахтай тэмцэх сангийн мөнгөний талаар Санжаадорж хариулах уу? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгчихье. Мэндсайхан сайд хариулчихъя даа саяынх. Дараа нь холбогдох байгууллагууд бэлдэж байгаарай. Мэндсайхан сайдын микрофоныг өгье.

З.Мэндсайхан: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Тэр Өвөрхангайн шүүх шинжилгээний барилгын санал бол ирсэн зураг төсөвтэй 6.8 тэрбумын өртөгтэй ирсэн байна. Тэгээд төсвийн хязгаарт багтаагүй байна. Хөрөнгө оруулалтын хязгаарт. Санал бол яг нөгөө хөрөнгө оруулалтынхаа системдээ ирсэн юм байна. Онцгой албан татварын хуулийнхаа 6.11-д заасны дагуу ногдуулаас хурааснаасаа бол 300 төгрөгийг нөгөө архидан согтуурах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа төвлөрүүлж байгаа. Энэ бол тусдаа эх үүсвэртэй сан биш. Нэг ёсондоо төсвөөс санхүүжүүлдэг сан биш шүү дээ. Үйлдвэрлэгчийн борлуулж байгаа. Энийг бид нар онцгой эх үүсвэртэй өмнө нь зүгээр л улсын төсөвт ордог байсан орлогоос хуваарилдаг байсан. Одоо бол бол орлогоос тусгайлан хуваарилдаг болсон.

Ер нь бол зүгээр энэ сангийн асуудлыг яагаад бие даалгахгүй байна гэдэг асуудлыг яриад байгаа. Энэ дээр хийгдээгүй ажил жишээлбэл энэ жил бол Засгийн газар төлөвлөхдөө Автотээврийн замын сан, Архидан согтууруулахтай тэмцэх сан хоёрыг тусад нь гаргая гэсэн юм. Яагаад гэхээр энэ чинь эх үүсвэр нь төсвөөс хамаагүй байхгүй юу. Авто замын сан болохоор зэрэг хурааж байгаа цэг

нь тодорхой. Хураасан цэгийнхээ тэндээс хураасан мөнгөө аль замдаа зарцуулах нь тодорхой. Ингээд бие даагаад явчхаж байгаа юм. Энэ дээр хийгдээгүй юм нь Тэмүүлэн сайд энэ асуудлыг хийх байх. Тэгээд ингэхэд бид нар ирэх жилийн юун дээр гаргаад явах боломжтой.

Яагаад гэхээр энэ нь өөрөө хэн юунд зарцуулах нь огт тодорхойгүй байгаад байгаа байхгүй юу. Яг энэ асуудал Амарсайхан сайд бид нар ярилцаар байгаад энэ нь шийдэгдээгүй тэгээд төсвөөс гарч чадалгүй үлдсэн. Сангийн яамны барьж байгаа байр суурь бол энийг төсвөөс нь гаргаад, бие даалгаад, тэр шаардлагатай юманд нь зарцуулаад явах тэр бүрдчихсэн байгаа 22 тэрбум байх. Сан нь тийм дүрэмтэй юм байна лээ. Ингээд явахад бидний зүгээс бол ямар ч асуудал алга. Одоо тэн дээр процессын шинж чанартай яг тухайн сангийн тэр зарцуулалтыг нь хэрхэн, яаж явах юм нөгөө хувийн хэвшлээс орж ирсэндээ хэн хяналт тавих юм? Энэ бүхнээ л шийдээд явчих юм бол цаашаагаа явчих л юм байна лээ.

Л.Мөнхбаатар: Тийм сая Мэндсайхан сайд энийг бас санг нь тусад нь гаргая гэж байх шиг байна. Тэгээд энэ өөрөө төсвийн бус орлого учраас энийг тусдаа бөгөөд зориулалт нь бол 4 чиглэлээр байдаг. Энэ дотор бол энэ Алтангэрэл сайдын яриад байгаа согтуурах, мансуурах донтой, өвчтэй хүмүүсийг эмчлэх асуудал нь бол байгаа. Байгаа яг энэ заалтаараа бол орж ирж байгаа. Тэгэхээр энэ эмнэлэг барья гээд энэ дээр бол манай олон гишүүд, Одонтуяа гишүүн их олон гишүүд бас энэ дээр санал тавиад явдаг. Энийг нь бол бас дэмжээд энд нь зарцуулах хууль эрх зүйн боломж нь бол байгаа юу. Байгаа. Тэгэхээр ер нь энэ хар тамхитай тэмцэх энэ ажил бол мэдээж олон талт арга хэмжээнээс бүрдэнэ. Тэр дотроо хамгийн гол нь энэ хар тамхи, мансууруулах бодис, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодист донтсон хүмүүсийг эмчлэх асуудал нь хамгийн чухал буюу хамгийн орхигдсон асуудал байгаа юм байна лээ. Мэдээж илрүүлэх энэ ажлууд нь бол зөндөө хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ ажил дээр бол эмнэлэг барихаас арга байхгүй. Мэргэжлийн боловсон хүчин шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үүнийгээ эмчлэх л асуудал байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр шүүхийн шийдвэр дээр өнгөрсөн жил 51 тэрбум төгрөг тавьж явж байгаад сүүлдээ хасагдчихсан байх шиг байна лээ. Эмнэлэг барих энэ газрын болоод зураг нь байж байгаа. Энэ асуудлуудыг бас Тэмүүлэн сайд бас судалж үзэх байх. Сангийн яам бас энийг бас дэмжээд ингээд явах юм бол.

Байршлыг нь бол СЭМҮТ-ийн хашаанд бас их том хашаа байдаг. Тэнд байрлаж болно гэдэг энэ судалгаануудыг бас хийсэн байсан. Тодорхой ажлын хэсэг гараад явж байсан. Энэ ажлуудаа бас сайхан судалж үзээд ер нь бол эмнэлэг барих асуудал дээрээ Сангийн яам ч тэр, манай Хууль зүйн яам энэ олон гишүүд санаа зовниж ярьж байна. Энэ асуудлаа бол нэг талдаа гаргаж тохирох нь зүйтэй шүү гэдгийг та бүгдэд хэлье. Дараагийн асуултад хэн хариулах нь хэн байгаа билээ? Прокурор хариулна. Өөр хэн байна? Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, прокурор Чулуунбат хариулчих. Дараа нь Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг хариулна шүү. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Д.Чулуунбат: Улсын ерөнхий прокурорын газар Чулуунбат. Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Прокурорын байгууллага 2026 онд төсвийн цалингийн сан хүрэлцэхгүйгээс нийтдээ 100, хүүхэд асрах чөлөөтэй, 62 сул орон

тоо 63 гэсэн нийтдээ 125 албан хаагчийн үндсэндээ цалингаар цалингийн санг хүргэсэн.

2027 онд бол нийт 1456 албан хаагчийг бүрэн цалинжуулахаар өөрөөр хэлбэл сул орон тоон дээр байгаа 62, 63 албан хаагчийгаа томилуулахаар бид нар цалингийн сандаа бүтэн цалингийн саналаа тавьж саналаа тусгай саналаа хүргүүлсэн. Одоогийн байдлаар энэ санал яг хэвээр явагдаж байгаа.

Бид бас прокурорын сонгон шалгаруулалтыг бас нээлттэй явуулахаар дараа онд энэ 65 прокурор дээрээ прокурорын сонгон шалгаруулалтыг бол нийтэд нээлттэй явуулахаар журмын төслөө боловсруулаад Хууль зүйн яаманд удахгүй хүргүүлээд тэгээд прокурорын сонгон шалгаруулалтыг бас…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төлөөлөл. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Т.Нарантуяа: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал хурандаа Нарантуяа. Гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлээр санхүүжиж байгаа. Энэнтэйгээ уялдуулаад тус эмнэлгийн хувьд бол гүйцэтгэл хэчнээн хийх боломж байгаа боловч Эрүүл мэндийн даатгалтай хийсэн гэрээний дагуу манай гэрээг багасгаж хийж байгаа.

2026 онд 17 тэрбумаар бид нар гүйцэтгэлээ хийнэ гэж хэчнээн төсөвлөсөн ч одоогийн байдлаар бол бид нарт 11.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор ингээд төсөвлөчихсөн байж байгаа. Та бүхэн мэдэж байгаа Засгийн газрын 135 дугаар тогтоолоор ТҮТҮМ-ээр ажиллаж байгаа албан хаагчдын цалинг 01 сарын 01-нээс 30 хувиар нэмсэн. 05 сарын 01-нээс нэмэгдэл хөлсийг нь энэ үндсэн цалингаар тооцохоор ингээд зохицуулалт явж байгаа. Тэгээд энэ мөнгө бол 2026 оны төсөвт бол суугдаагүй. Бид нар төсвийн тодотголд бас үүнийгээ хэчнээн оруулах гэсэн боловч энэ удаа суугаагүй байгаа нь эмнэлэг бол бас нэлээн хүндрэлтэй байж байна…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя.

Т.Нарантуяа: Эрүүл мэндийн даатгалаас хурц оношийг бол 100 хувь санхүүжээд төлөвлөгөөт оношийг 80 хувь хүргэхээр нь үлдэгдэл хувийг нь болохоор 80 хувиар тооцож санхүүжиж байгаа. Архаг оношийг 80 хувьд хүрэхээр нь үлдэгдлийг нь 60 хувиар ингээд санхүүжүүлж байгаа нь өөрөөр хэлбэл бид нар 100 хувь стандартынхаа дагуу тусламж, үйлчилгээг үзүүлсэн хэдий боловч санхүүжилтийг ингэж хасаж олгож байгаа нь энэ бид нарын хувьд бол маш хүндрэлтэй байна.

2027 онд улсын татаасыг бид нар 9.2 гэж хэчнээн төсөвлөсөн төсөвлөсөн ч 26 оных шигээ 4.4-өөр төсөвлөж өгч байгаа нь эмнэлэгт бол цаашаа төсвийн хувьд бол хүндрэлтэй байгааг бас илтгэж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ Их Хурал тарааж байгаа материал дээрээ хуудасны дугаар тавьчихаж байвал зүгээр байна. Яагаад гэхээр шууд хуудасны

дугаар хэлээд л асуухгүй бол их хүндрэлтэй байна шүү. Цагдаагийн ерөнхий газраас асууя. Цахим сургалт төсөл дээр 0 гэж байх юм тэгэхээр 26 ч 0, 27 ч 0. Тэгэхээр бид нар чинь энэ цахим шилжилтдээ ордоггүй юм уу? Манай урд хөрш чинь гэхэд л робот цагдаанууд яваад эхэлчихсэн. Тэгээд энэ цахим шилжилтийг хийхгүй юм уу? Дандаа л байшин барилга, оронтоо нэмээд байхаас энэ чинь маш их орон тоо хэмнэх ийм боломжтой шүү дээ. Тэгэхээр энэ AI-д шилжчихсэн байна. Тэгэхээр энэ талаар яагаад 0 байгаа юм бэ гэдэг асууя.

Дараагийнх нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос асууя. Бид нар өнгөрсөн жил хууль баталсан. Өнгөрсөн жил биш саяхан хаврын чуулганаар. Энэ дээр энэ цэргийн байгууллагуудад маш их хүний амь эрсдээд байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар юу гэж оруулсан бэ гэхээр цэргийн байгууллагуудад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг явуулъя гэж яасан. Дандаа сургалт байгаа. Тэгэхээр яагаад энэ дотоод албан томилолт чинь ердөө 147-хон сая юм бэ? Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал 146-хан сая. Тэгэхээр одоо бид нар энэ хилийн цэргийн газрууд чинь 21 аймагт байгаа. Тэгэхээр ийшээ явж сургалтаа хийхгүй юм уу? Энэ сургалтын зардал чинь яагаад ороогүй юм бэ? Тэгэхээр хууль хэрэгжихгүй шүү дээ. Тэгэхээр бид нар Их Хурлаар хүний амь нас эрсдэхгүй байя гээд бараг 2 парламент дамжаад хууль баталдаг энэ хуулийг хэрэгжүүлэхгүй юм уу гэдэг асуумаар байна.

Батлан хамгаалах яам бол сүүлийн үед бол бас харин нэлээн чухал юмнууд хийгээд байгаа. Камержуулалт, энэ урьдчилан сэргийлэх дээр. Тэгэхээр бид нар өмнөх парламент биш ээ, өмнөх чуулганаар Хууль зүйн байнгын хороо батлаад 8 хүний орон тоо гээд оруулсан байгаа. Тэгэхээр энэ 8 хүний орон тоо энэ 27 оны төсөвт батлагдсан уу гэдгийг нэгдүгээрт асуумаар байна. Тэгээд энэ дотоод томилолт энэ сургалт 2 чинь бид нарын батлуулсан энэ Байнгын хорооны дарга ч бас тэнд орсон. Бид нар ийн батлуулсан хуулийг хэрэгжүүлэх боломж яагаад байхгүй байгаа юм бэ гэдгийг асуумаар байна.

Энэ Гэр бүл, хүүхдийн шүүх бас тусдаа байгаа. Энэ дээр ямар нэгэн төсөв мөнгө ерөөсөө харагдахгүй байгаад энэ чинь болж байгаа юм уу гэдгийг асуумаар байна.

Хамгийн сүүлчийнх нь сайдаас асууя Тэмүүлэн сайдаас энэ мансууруулах бодист донтохтой холбоотой том төв барья гээд зураг төсөл, төсөв батлуулах батлагдсан уу? Энэ зураг төсөв нь батлагдсан бол энэ барилгын ажил гэж ерөөсөө орж ирээгүй харагдаад байна. Ерөөсөө хөтөлбөрт мөнгө байхгүй харагдаад байгаа байхгүй юу мансууруулах бодистой холбоотой. Тэгэхээр энэ зөвхөн тоног төхөөрөмж гээд байна л даа. Тэгэхээр БГД-т хасагдсаар байгаад 1 тэрбумаар нэг жижигхэн байр зөвлөгөө өгөх төв гээд авсан. Энэ нь тоног төхөөрөмжгүй. Тэгэхээр энэ тоног төхөөрөмжийг нь яаж шийдэх юм бол оо? 27 оны энэ тоног төхөөрөмжид багтаж байгаа юу гэдгийг асууя.

Ер нь Монгол Улс чинь энэ хар тамхи маш асуудалтай болоод байгаа шүү. Тэгэхээр төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлнэ гээд бид нар хуульд оруулах гээд байдаг. Гэтэл энийг нь төсөвлөсөн зардал, мөнгө байгаа юм уу гэдгийг бол тодорхой асуумаар байна. Тэгэхээр энэ тодорхой 3 газар энд хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Эхлээд цагдаа байсан уу? Цагдаагийн байгууллага асуултад хариулъя. 3 номерын микрофоныг өгье.

Д.Батчулуун: Цагдаагийн ерөнхий газар хурандаа Батчулуун. Гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагаас энэ 26, 27 оны төсвийн төсөлд байгууллагын хэмжээнд программ хөгжүүлэлт, дата бүтэц, дата төв байгуулах, хиймэл оюун хөгжүүлэлт гээд нийтдээ 20 гаруй тэрбум төгрөгийн санал өгсөн. Харамсалтай нь бол төсвийн төсөлд дэмжигдэж ороогүй байгаа. Байгууллагын дотоод албаны сургалтын зардлыг бол харин 2 дахин нэмэгдүүлэхээр орсон. Байгууллагын батлагдсан төсвөөсөө цагдаагийн байгууллагын дотоод албаны сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа.

Л.Мөнхбаатар: Цахим сургалт дээр бол 0 гээд байгаа нь бас албаны сургалт дээр бол 20-оод тэрбум төгрөг байгаа юм байна шүү дээ тийм үү? Тэр нь тэгээд дүйцүүлж ойлгоно гэсэн үг юм уу тээ? Цахим сургалт 0 байна. гэж асуугаад байгаа юм байна шүү дээ тийм үү? Хэн ээ? Одонтуяа? Тэр нь хэн Батчулуун хурандаа хариулчихъя. Цахим сургалтад 0 гээд байна. Гэхдээ танай албаны сургалтууд тийм дотроо багтаж яваа юм уу үгүй юм уу гэдгийг нь л хариулчих. Ажлын хэсэг 3 номер.

Д.Батчулуун: Сургалтууд танхимаар болон заалаар цахимаар явж л байгаа л даа. Тэгээд цахим сургалт гэж гишүүн дээр аль яг ямар мэдээлэл дээр 0 гэж байгаа юм бол? Тийм. Ер нь сая 25 оны, 26 оны 8 сард засгийн тогтоол гарсан сургалтууд аль болохоор цахим хэлбэрүүд рүү ер нь шилжсэн. Сургалтууд цахимаар ингээд танхимаар хослоод явж л байгаа дарга.

Л.Мөнхбаатар: Хүний эрхийн Үндэсний Комисс. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

Д.Сүнжид: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. 27 оны төсвийг урсгал зардлыг 16.8 тэрбум байхаар санал өгсөн. Энэ дунд комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор дотоод томилолт, мөн сургалтын үйл ажиллагаа явуулах хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардал, орон тоог нэмэгдүүлэхээр өгсөн боловч энэ оны төсвөөр буюу орон тоо нэмэгдэхгүй сургалтын зардал энэ оныхоор 146 сая, дотоод томилолт 147 сая байхаар ийм төсөөлөл нь орж ирсэн байна Өөрөөр хэлбэл бидний өгсөн санал дэмжигдээгүй ийм байна.

Л.Мөнхбаатар: Одоо хаана хариулах билээ? Хууль зүйн сайд уу? Тэмүүлэн сайд хариулъя.

Г.Тэмүүлэн: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Энэ зураг төсөв байгаа юу гээд тэгсэн энэ яг мансуурахтай холбоотойгоор, хар тамхитай тэмцэхтэй холбоотойгоор яг мэргэжлийн энэ тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх энэ эмнэлгийн зураг хөргийг бол манай яамны зүгээс бас боловсруулаад ингээд 24 онд зургийг нь бол батлуулсан байгаад байгаа. Ингээд нийт төсөвт өртөг нь бол 54.3 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр СХД-ийн 21 дүгээр хороон дээр Таширын аман дээр барихаар бол ийм төлөвлөгдсөн. Ингээд бид нар 2027 онд барилгын ажилтан нь бол 18.1 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэхээр бол Сангийн яаманд

санхүүжилтийнх нь саналыг бол явуулсан. Ингээд энэ бол тусаж ороогүй байгаад байгаа. Тэгэхээр бол бэлэн зураг бол байгаа гэдгийг хэлэх байна.

Тоног төхөөрөмжтэй холбоотойгоор бол 3.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн зардлыг бол тавьсан. Тоног төхөөрөмжийн судалгааг нь бол одоогийн байдлаар бол хийж байна гэж байгаа. Та бас БГД-тэй холбоотойгоор бас

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Жудгийн Баярмаа асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. 27 оны төсөвтэй холбоотойгоор тодорхой асуултууд байна. Хууль зүй, дотоод хэрийн сайдаас нөгөө бид нар чинь аль болох л төсвөө хэмнэе, шаардлагагүй зардлаа таная гэсэн ийм үндсэн концепц бариад уг нь ажиллаж байх ёстой. Тэгээд хүн болгон л ер нь ялангуяа Засгийн газрын сайд нар бүгд л тийм юм ярьдаг боловч яг ингээд төсөвтөө тулгаад үзэхээр байдал өөр байгаад байгаа юм6 Тэгээд энэ эрс нэмэгдсэн зардлуудыг жишээлбэл асууя гэж бодож байна.

Хууль зүй, дотоод хэрийн сайдаас нөгөө л нөгөө бид нарын ярьж шүүмжилдэг ийм зардлын төрөл байгаад байгаа шүү дээ. Томилолт, зочны зардал гээд. Тэгээд энэ бол жишээлбэл 27 онд 3.4 тэрбум байсан байна. Гэтэл 26 онд энэ онд тэгээд 27 оны төсвийн төслөөр бол 9.2 тэрбум болж орж ирсэн байна. Бараг 3 дахин нэмэгдээд 170 хувь 6 тэрбумаар нэмэгдсэн байна. Тэгээд энэний задаргаа юу байна вэ? Хаашаа ямар томилолт нэмэгдээд ийм их дүн болчхов гэдгийг асуумаар байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт дахиад л мөн эд хогшил, урсгал засварын зардал гээд. Бас энэ онд 15.3 тэрбум байсан бол 36.6 тэрбум болж өссөн байна. Бас л бараг 3 дахин. Тэгээд энэ яг задаргаа нь юу юунд ингэж их 3 дахин нэмэгдээд байна вэ гэдгийг асууя.

Бас багаж, техник хэрэгсэл гээд энд. Жишээлбэл 5.7 тэрбум байсан байна л даа энэ 26 онд. Гэтэл 18 тэрбум болж бас 213 хувиар нэмэгдсэн байна. Тэгэхээр энэ дотор ямар багаж, техник хэрэгсэл орж байгаа юм бэ? Тэгээд энийг асуухын зэрэгцээ бас асуултыг нэмээд асуувал нөгөө энэ цагдаагийн бүхий л 21 аймаг, 9 дүүрэг, нэгж хэлтсүүдийн энэ цагдаагийн байгууллагууд камертай байх ёстой гэж хэдэн жилийн өмнөөс л ярьж байсан. Тухайн үед бол эвдэрсэн, ажилладаггүй дутуу гэдэг зүйл байсан. Тэгээд энэ бүхэн бол хангагдсан уу? Яагаад гэвэл энэ чинь нөгөө хүний эрхийг хангахтай холбоотой маш чухал ийм техник, хэрэгсэл байгаад байгаа камер гэдэг бол. Тэгэхээр энэ бүрэн камержиж дууссан уу? Дуусаагүй бол энэ техник хэрэгсэл гэдэг энэ их дүнд 36 тэрбум дотор энэ камер хэрэгслүүд орж байгаа юу гэж асуумаар байна аа? Хүний эрхийн Үндэсний Комиссоос. Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ төсөв дотор 23 бараг 24 тэрбумаар барилга байгууламж гэж тусгагдсан байна. Тэгээд шинээр гээд энэ. Тэгэхээр энэ шинэ барилгатай болох гэж байгаа юм байна гэж ойлголоо. Шинэ байшин барих гэж байгаа юм байна. Тэгээд ямаршуу байранд байдаг вэ? Хэдэн хүний бүрэлдэхүүнтэй төв оффис нь ажилладаг вэ? Яг ийм том бүхэл бүтэн тусдаа барилга байгууламж 24 тэрбумаар барих шаардлага яг байгаа юу? Энийг барьснаар хүний эрхийн зөрчил хэдэн хувиар яаж буурах вэ? Бишгүй л хүний эрхийн зөрчил энд тэндгүй гарч байдаг. Тэгээд энэ бүхэнд маш тийм онцгой нөлөө үзүүлэхүйц ийм барилга байшин байгууламж болж хувирах гэж байгаа юм уу?

Бусад орнуудын туршлага юу байдаг юм бэ? Хүний эрхийн Үндэсний Комисстой улс болгон тусдаа шинэ барилгатай юу гээд.

Одоо бид нар сая энэ шүүхийн барилгуудыг маш их ярьж байна л даа. Зарим нь хасагдсан байна гээд ерөөсөө багтахгүй шингэхгүй гээд. Гэтэл шүүх чинь өөрөө Үндсэн хуулиараа засаглалын 3 хэлбэрийн нэг бие даасан хараат бус байх шүүх. Засгийн газар, хууль тогтоох байгууллага энэ бүхэл бүтэн үндсэн хуулийн том институц барилга байгууламжийн зовлон ярьж байна. Гэтэл Үндэсний комисс маань мэдээж хүний эрхийг хангах үндсэн чухал үндсэн хуулийн дагуух бас үүрэгтэй боловчиг яг ийм цөвүүн цаг…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд асуучихъя Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тийм тэгээд ийм барилга байгууламж хэрэгтэй юм уу гэж ингэж асуумаар байна. Түрүүн нөгөө Хууль зүйн сайдаас бас дутуу асуусан байна. Энэ сургалт, дадлага, бэлтгэлийн зардал гээд бас 26 онд 8.5 тэрбум байсан бол 19.3 тэрбум бараг 20 тэрбум болоод 11 тэрбумаар нэмэгджээ. Энд яг ямар сургалтууд, дадлага, бэлтгэлүүд ордог юм бол оо? Тэнд огцом огцом нэмэгдээд байгаа дүнг нь л би асуугаад байгаа юм л даа. Энийг бас нөхөөд хариулчхаарай.

Бас нэг шүүхээс зүйл асууя. Хүний эрхийг бид нар дээдлэх ёстой. Шүүгдэгч, яллагдагч бол бас хүн. Тэгээд маш олон хүмүүс бол надад гомдол мэдүүлж байсан. Шүүхийн процесс маш олон цагаар явагддаг. Тэгээд ийм бандан сандал дээр хэдэн цагаар суухаар маш их хүндрэлтэй байдаг. Тэгээд тэр болгон завсарлах боломж байдаггүй. Шүүгчид маань бол мэдээж зөөлөн сайхан сандал дээр сууж байдаг. Тэгэлгүй ч яах вэ. Гэтэл тэр шүүгдэгч, яллагдагчдад бол шүүлгэх хүний эрхийн…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Асуултууд байлаа. Эхлээд хэн хариулах вэ? Хүний эрхийн комисс хариулъя. Сая Баярмаа гишүүний асуугаад байгаа энэ асуулт бол би ингэж ойлголоо Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө байшинтай болох тухай асуудал биш байх тийм ээ. Хүний эрхийн төв гээд энэ Азид бас нэгдсэн нэг ийм төв байгуулах асуудал энэ олон улсын байгууллагын шугамаар Европын холбооны дэмжлэгтэйгээр ч билүү байгуулагдахаар ярьж байсан. Тэрийг ярьж байгаа юм болов уу тээ. Энийг тодруулаад хариулъя. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Хөрөнгө оруулалт гээд байшин барихаар 25.1 тэрбумыг төсөвлөсөн. Төсвийн төсөөллийг өргөн барьсан. 2023 оны Улсын Их Хурлын 114 дүгээр тогтоол гарсан юм Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан 75 жилийн ойд зориулаад. Түүгээр Ази, Номхон далайн бүсийн хүний эрхийн төвийг байгуулна гэдгийг ингэж үүрэг болгож Засгийн газартаа өгсөн. Энэний мөрөөр энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө бол бас орчихсон байдаг. Түүнээс гадна өнгөрсөн 5 дугаар сард Хүний эрхийн дээд комиссоор Фолькер Турк айлчлахад Засгийн газартай санамж бичиг гэж байгуулсан.

Ерөнхий утга нь Ази, Номхон далайн 27 улсуудын сургалтын төв, судалгааны төвийг Монгол Улсад байгуулна гэдэг. Яг тэр утгаар энэ барилга явж байгаа. Өөрөөр хэл манай 89 орон тоотой ийм байгууллага 21 нь аймагт ажилладаг. Ингээд энэний 67.7 нь үндсэн 6 гишүүн, нэмэх нь 1 эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх гишүүн 60 ийм албан хаагч төвд ажилладаг. Эд нарт зориулсан бол биш энэ хэсэг нь байх юм. Ази, Номхон далайн бүсийн орнуудад зориулаад сертификаттай. Ингээд сургалт судалгааны төв байгуулна гэдэг ийм утгаар явж байгаа заалт. Тэгээд 27 оны өргөн барьсан 25.1 тэрбумаас 7.2 тэрбум нь төсвийн төсөлд орсон байна. Өөрөөр хэлэх юм бол 30 хувь нь энэ барилгыг эхлүүлнэ гэдгээр ингэж тусгагдсан байна.

Л.Мөнхбаатар: Гэхдээ хариултуудаа авчхаад тодруулах уу тээ? Шүүхээс асуучихсан. Шүүхийн зөвлөлийнхөн хариулъя. Дээшээ ажлын хэсгийн 3 дугаар микрофон дээр очоод суучих. Баярмаа гишүүний асуултад хариулъя.

П.Золзаяа: Улсын хэмжээнд нийтдээ 88 шүүх байгаа. Шүүх хуралдааны танхим 150 танхим байгаа. Эдгээр танхимын бүгдэд нь хэргийн оролцогчийн хувьд бол вандан сандал бүгдэд нь байгаа юм биш. Тодорхой хэсэгт нь байгаа. Тэгээд үүнийг шийдвэрлэх зорилгоор 2026 онд тавилга авахаар төсөвлөсөн байсан боловч сая тодотголоор энэ 1.6 тэрбум нь бол хасагдсан. 2027 онд бол 27 оны энэ төсөвт 3.3 тэрбумаар тусгагдсан байна. Тэгэхээр үүнээсээ бол шийдэх бол бараг боломжтой байна.

Л.Мөнхбаатар: Баярмаа гишүүн тодруулж асууя. Тэмүүлэн сайд хариулаад дараа нь тодруулъя.

Г.Тэмүүлэн: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Манайхнаас саяын яг тодорхой энэ асуудлууд дээр томилолт, эд хогшил, сургалт, дадлага бэлтгэл гээд энэ зардлууд яагаад 3 тохиосон юм бэ гээд энэ дээр бас учир шалтгааныг нь бол тайлбарлаж өгөөрэй гэдэг зүйлийг бол хэлэх байна. Саяын камержилттай холбоотой бас асуудлыг асуусан.

Би таны шүүмжлэлтэй бол нэг талдаа санал нэг байгаа. Бид бүхний хувьд нэг талдаа ингээд урсгал зардал өөрөө нэмэгдээд байдаг. Ингээд тухайн зардлыг үр дүнтэй холбох асуудал бол ерөөсөө манай төрийн захиргааны бүх байгууллагууд дээр бол учир дутагдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр бид бүхний хувьд энэ үр дүнд суурилсан төсөвлөлтийг хийх, зардлын үр дүнг төлөвлөлттэй уялдуулах асуудал бол зайлшгүй шаардлагатай байгаа. Би энэ салбарт очсоных ямар ч бай салбарынхаа харьяа байгууллагуудын энэ зардлын үр дүн төлөвлөлтийн уялдаа холбоог хангах чиглэлээр бол идэвхийлэн бол ажиллана гэдгийг бол танд хэлэх байна.

Өнгөрсөн намайг Төсвийн байнгын хороонд байхад бол яг бид бүхний санаачилгаар…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн сайд гүйцээгээд хариулчихъя.

Г.Тэмүүлэн: Шүүхийн ерөнхий зөвлөл болоод аудит 2 бол хамгийн анх манлайлаад бол яг энэ үр дүнд суурилсан төсөвлөлт рүү бол шилжсэн байгаад байгаа. Энэнийхээ хэмжээгээр ч тодорхой төсөвтэйгөө үр дүнгээ уясан ажлын үр дүнгүүд бол бас нэлээн ахицтай гарч байна гэж бол би бас хараад байгаа. Үндсэндээ яг бүх л төрийн байгууллагуудаар төр захиргааны төрийн захиргаа болоод төв байгууллагуудаар гарч байгаа асуудал бол ерөөсөө төсөв өөрөө үр ашиггүй байна, үр дүн чиглээгүй байна, тэгээд аудитын байгууллагаас энэ чиглэлээр жил болгон дүгнэлтүүдийг бол гаргасаар байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар Сангийн яам ч гэсэн энэ асуудал дээр бол яг бодит дүн шинжилгээ хийгээд бүх байгууллагуудыг илүү үр дүнтэй нь энэ төсөв, төсвийг зардлыг уях бол зайлшгүй шаардлага бол байгаа. Тэгэхээр энэ дээр бол тодорхой яг дүн шинжилгээ хийж байж л танд нарийн задаргаа юмнуудыг хэлье. Манайхан тодорхой яагаад 3 дахин өмнөх жилээсээ өссөн бэ, задаргаа нь юу байна вэ, шалтгаан нь юу байна гэдэг талаар бас тодорхой тайлбараа одоогийн байдлаар хэлээдэх.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? 3 номерын микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулъя.

Н.Отгонбаяр: Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбаяр. Эд хогшил, урсгал засварын зардал 8.9 тэрбумаар өнгөрсөн оноос нэмэгдсэн. Манай салбарын хэмжээнд Хууль зүйн сайдын салбарын хэмжээнд бол нийт баланс тайлан гаргадаг нийт 232 салбар нэгж байдаг. Үнэхээр газар дээр нь очоод үзэхэд бол энэ урсгал зардал нь хаанаа ч хүрдэггүй. Энэ жил бол яг энэ шинэ хөрөнгө оруулалтаас илүү одоо энэ байгаа байгаа 232 аймаг нийслэлд нийлсэн ийм байгууллагуудынхаа засварыг удаа дараа гомдол гаргадаг иргэдээс ч гомдол ирдэг хуучин олон жил болсон байшингуудыг зурагтай, төсөвтэй тоон болон чанарын судалгаа хийчихсэн ийм зардлын өсөлт байгаа.

Сургалт, дадлага, бэлтгэл ажлын зардал гээд 10.6-гаар. Энэ нийтдээ манай бие бүрэлдэхүүн ойролцоогоор 27, 8 мянган…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчих Отгонбаяр аа. 3 номерын микрофон өгчихье. 3 номерын микрофон өгөөрэй байна. 3 номерын микрофон өгөөрэй.

Н.Отгонбаяр: Нийтдээ ойролцоогоор 28 мянган нийт албан хаагчтай. Үүнээс 90 хувь нь бол дандаа мөрдөстэй албан хаагчид. Энэнтэй сургалт, дадлага бэлтгэл ажиллагааны зардлыг нь бол энэ бол бас бүх байгууллагуудаас авсан шинжилгээ дээр тоон болон чанарын судалгаан дээр үндэслээд үүнээс гарсан шаардлагатай 10.6 тэрбумаар өмнөх оноос бол нэмэгдсэн байгаа юм. Энэ сургалт нь өөрөө яг өнөөдрийн тавьсан энэ зардал өөрөө бас яг ингээд сайн судлаад ингээд бүх юм ингээд өнөөдрийн энэ бид нарын тавиад төлөв төлөөд байгаа зардал чинь ч гэсэн бид нарын хүссэн одоо сургалт үйлдвэр, бэлтгэл ажиллагааны зардалд бас л ингээд л 70, 80 хувьтай л бид нар төлөвлөж байгаа байхгүй юу. 100 хувиар бас л төлөвлөж чадахгүй байгаа. Яагаад гэвэл бид нарын энэ төсвийн бас орлоготой холбоотой, мөн ингээд Сангийн яамтайгаа, бүх газартайгаа төсөв төлөвлөгөөгөө…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Тэгээд Ази Номхон далайн бүсийн сургалт судалгааны төв байгуулах гэж байгаа юм байна, санамж бичиг, гэрээ энэ тэр байгуулчихсан юм байна. Ер нь бол яг тийм олон улсын шинжтэй сургалт судалгааны төв байгуулснаар Монгол Улсын хүний эрхийн зөрчил хэр их буурах юм бэ? Ач холбогдол, үр дүн талаас нь хэлээд өгөөч. Одоо ер нь ийм даахгүй нохой булуу хураана гэгчээр Монгол Улс савсал гэвэл их олон улсын шинж чанартай том арга хэмжээ авах гэдэг, арга хэмжээ зохион байгуулах гэдэг. Сүүлдээ бас тийм бүүр барилга байгууламж барих руу орж байгаа юм байна. Би бол яах вэ яг тэр ач

холбогдол, үр дүнг нь бол сайн ойлгохгүй байгаа учир дахиад тэр талаас нь хэлээд.

Авлигатай тэмцэх газраас 1 асуулт байна. Энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гээд баталсан байгаа 20, 30 гээд. Тэгээд энэ дээр бол сонгуулийн бус үеийн санал худалдан авалттай тэмцэх гээд ийм зорилго, зорилт тусчихсан яваад байгаа. Ирэх жил 27 онд Ерөнхийлөгчийн сонгууль, 28 онд нөгөө Улсын Их Хурлын сонгууль маань

Л.Мөнхбаатар: Болчихсон уу? эхлээд эхлээд Хүний эрхийн Үндэсний Комисс 5 номерын микрофон өгье. Дараа нар Авлигатай тэмцэх газрынхан бэлтгэж байгаарай.

Д.Сүнжид: Манай Хүний эрхийн Үндэсний Комиссын үндсэн 9 хуулиар хүлээлгэсэн 20 чиг үүрэг байгаа. Тэр 20 чиг үүргийн нэгэнд нь боловсролыг түгээх гэж чиг үүрэг байна. Судалгаа хийх чиг үүрэг байна. Тэгээд хяналт шалгалт явуулах, гомдлыг шийдвэрлэх гээд. Тэгэхээр энэ нөгөө зөрчлийг таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх гэдэг нь нэг чиг үүрэг. Нөгөө 20 чиг үүргийн бид нарын нэг нь. Бид нар ер нь энэ Алсын хараа, тэр зорилго, зорилт хөгжлийн төлөвлөлт дээр яаж тавьдаг вэ гэхээр 11 шалгуур үзүүлэлтийг тавьдаг. Яг энэ саяын 20 чиг үүрэгтэй холбоотой тавьдаг.

Тэгэхээр таны асуултыг би комисстой л холбож ойлгоод байна л даа. Ямар үр дүн гарах юм бэ гэж. Тэгэхээр нөгөө 11 шалгуур үзүүлэлтийн хүрээнд аль болох ирж байгаа гомдлыг бүрэн дүүрэн хянан шийдвэрлэнэ, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтаа явуулна, хүртээмжтэй, хүрэлцээтэй байлгахыг эрмэлзэнэ, тоогоо нэмнэ, гарын авлага, нөлөөллийн ажлыг хийнэ. Ийм байдлаар бид нар тэр шалгуур үзүүлэлтээ оруулдаг.

Л.Мөнхбаатар: Сүнжид дарга наадах чинь яах вэ ойлгомжтой байна. Гол асуугаад байгаа нь ингээд байна. Ази, Номхон далайн хүний эрхийн төвийг байгуулсны ач холбогдол нь юу юм бэ гэж л асуугаад байна. Тэр дээр нь хариулчихъя. 5 номерын микрофон өгье. Ажлын хэсэг.

Д.Сүнжид: Энэ ийм л юм шүү дээ. Бүс нутагтаа бол ер нь нөгөө сургалт хийснээр манайхаас ирээд сертификаттай хүмүүс өөрсдөө зардлаа гаргаад тэгээд ийм сургалт явуулах боломжтой л болох юм. Өөрөөр хэл гэх юм бол Ази, Номхон далайн хувьд, бүсийнхээ хувьд 27 улсуудын хооронд манайх лицензтэй сургалт явуулах ийм боломжтой байгууллага л болох байхгүй юу. Бүс нутгийн хэмжээний манлайлал гэсэн үг. Бусад байгууллагууд байдаг. Бангкокт байдаг, хажууд Киргизстан, ...-ийн салбарууд байдаг. Энэ байдаг л үйл ажиллагаа. Монголд хүний эрхийн чиглэлээр байдаггүй, бий болгоё л гээд явж байгаа ийм л ажил юм.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг асуултаа асууя. АТГ хариулъя. Баасанням тийшээ 3 номер дээр суучих. Баасаннямын дараа асуулт, хариулт явагдана.

З.Баасанням: Авилагтай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга Баасанням байна. Гишүүний асуултад хариулъя. Нийтдээ энэ жилийн хувьд бол бид 68 сая төгрөгөөр сургалт, сурталчилгааны төсвөө оруулсан боловч 23 сая төгрөгөөр батлагдсан явж байгаа, санал явж байгаа. Энэ хүрээндээ таны ярьсан тэр

сонгуулийн санхүүжилт, санал хураалттай холбоотой үндэсний хөтөлбөрт сурсан сургалтын хүрээний хийгдэх ажлууд энэ хүрээндээ л төсөвтөө төсвийн хүрээнд л хийгдэж явна. л гэж ойлгогд болно.

Л.Мөнхбаатар: Болсон уу? Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Уг нь Сангийн сайдыгаа байлгаж байгаад л яг тулж асуумаар байсан юм. Тэгэхээр гол нь бид нар ингээд жилийн жилд яг ингээд Засгийн газар, Сангийн сайд ерөөсөө энэ шүүхийн хууль бид нарт хамаагүй гэдэг тайлбар хэлдэг байхгүй юу. Тэгэхээр энийг би бүр гайхаад байна. Хэрвээ ингээд төсөвт нь, Засгийн газарт нь Шүүхийн тухай хууль нь хамаагүй байдаг юм бол энэ Шүүхийн тухай хуулийнх нь дагуу энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийг хянаад явуулсан Байнгын хороо нь өөрөө бид нар тэгвэл хуулиа барих ёстой юм биш үү? Хэрвээ энэ Шүүхийн хуулийг зөрчөөд ороод ирчихсэн энэ төсвийг бид нар ер нь заавал авч хэлэлцэх ёстой ч юм уу үгүй ч юм уу гэдэг ийм асуултыг ер нь нь бол тавимаар байгаа юм. Өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оруулж ирсэн хаврын чуулганаар Хууль зүйн байнгын хороогоор бид нар хянаад явуулсан тэр төсөв 50 хувь буурчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 50 хувь буурна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Энэ дээр 195 орон тоо хасагдаж байна. Энэ хөрөнгийн зардал дээр буюу 209 тэрбум хасагдчихсан байна.

Дээрээс нь энэ дотор энэ урсгал шилжүүлэг гэдэг юм жишээлбэл 36 тэрбумаар хасагдсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ шүүхийн үйл ажиллагаа цаашдаа хэвийн явна гэдэг баталгаа байгаа юм уу? Өнөөдөр бид нар юу гэдэг юм тууз хайчлаад шинэ шүүхийн байрыг хүний эрхийг хангадаг боллоо, зориулалтын шүүхийн байрууд ашиглалтад орлоо гээд баярлаад байдаг. Гэтэл өнөөдөр тэрний чинь урсгал зардал байгаа юм уу? Өнөөдөр тэн дээр нэмэгдэх шүүгч, төрийн захиргааны албан хаагчид, үйлчилгээний байгууллага, үйлчилгээний төрийн албан хаагчид, эдгээрийн чинь тоо орон тоо хасагдчихаж байна шүү дээ. Тэгэхээр энэ бүх юм чинь байшин барилаа гээд бид тэр байшинд үйл ажиллагаа чинь явах ёстой. Өнөөдөр бид нар шүүхийн байрыг зүгээр шүүгч нарт зориулсан гэж харж болохгүй байхгүй юу. Өнөөдөр шүүхэд хэн очдог юм. Эрхээ хамгаалуулах гэж очдог. Өнөөдөр шүүх гэдэг чинь юу юм? Шүүх засаглал Засгийн газартай зэрэгцэн оршиж байгаа, Их Хуралтай зэрэгцэн оршиж байгаа гуравдагч эрх мэдэл. Гэтэл энэ дээр өнөөдөр бид нар Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөө даргыг энд ингээд бөнжгөнөтөл гүйлгээд сууж байгаа байхгүй юу. Үгүй 10 тэрбум өгчхөөч, 7 тэрбум өгчхөөч гээд сууж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ чинь өөрөө бид нар төсөв дээр нь ингэж чангалж байж өнөөдөр шүүхийн хараат бус байдал, нөгөө шүүгчийн хараат бус байдал энийгээ яаж ярих юм бэ? Энэ хараат бус байдлын чинь гол цөм нь өөрөө эдийн засгийн хараат бус байдал. Тэгэхээр ингээд жилийн жилд яг ингээд л төсөв хэлэлцэх үеэр үеэр үгүй энэ тэдэн төгрөг өгчхөөч, эдэн төгрөг өгчхөөч, шүүгчийнхээ цалинг тавьчих гэсэн юм шүүхийнхээ байрны сандлыг сольчих гэсэн юм гээд ингээд гуйгаад яваад байж байдаг байж болохгүй шүү дээ. Тэгээд ийм байлгахгүйн тулд бид нар Шүүхийн хуульд тусгайлан энэ заалтыг чинь оруулж ирээд 46.8 гэдэг чинь энийгээ зохицуулчихсан зохицуулалт байгаа байхгүй юу.

Гэтэл өнөөдөр Засгийн газар нь ч тэр, Сангийн сайд нь ч тэр тэр Шүүхийн хууль чинь бид нарт хамаагүй, бид нар хязгаартаа багтаасан гээд юу гэж байгаа

юм. Захиргааны байгууллагын хязгаар гээд төсвийн эрх хүрээний мэдэгдлийн захиргааны байгууллагын зардлын хязгаар гэнэ тэгээд шүүх тэр хязгаарт багтаж байх ёстой юм уу? Тэгвэл өнөөдөр төсвийн хүрээ чинь өөрөө 10 их наядаар нэмэгдчихсэн байгаа шүү дээ. Тэгвэл бусад юм нь хязгаартаа багтсан юм уу? Тэгэхээр би энэ болгоныг бүгдийг нь Сангийн сайдаас асуумаар байна. Сангийн яам энэ дээр тайлбар хэлмээр байна. Яг яагаад 50 хувь бууруулсан юм үндэслэлээ хэл? Үнэхээр тэр 195 хүний орон тоо хэрэггүй гэж байгаа юм уу, тэр шүүгч нар шаардлагагүй гэж байгаа юм уу? Өнөөдөр бид нар хэчнээн хууль дагнасан шүүхийн хуулиа баталчихлаа. Тэгээд нөгөө хүүхдийнхээ эрхийг хангах гээд байна, хүний эрхээ хангах гээд байна. Гэтэл тэрэнд чинь зардал байхгүй болчихлоо шүү дээ. Тэгээд энэ дээр тайлбараа өгмөөр байна.

Л.Мөнхбаатар: Сангийн сайдыг дууд. Сая энэ сууж байсан. Өөр хуралдаан руу орчхов уу? Сангийн яам дараа нь хариулчихъя тийм ээ? Өөр чиглэлийн асуулт байгаа юм уу? Тэгье Сангийн сайдыг дуудчих. Тэгээд тодорхой хариулт авъя. Дараагийн хүн асуулт асуугаад явж байя. Би дараа нь Сангийн сайдыг орж ирэхээр нь хариултыг нь авъя. Баасанжаргал гишүүнийх үү? Сангийн сайдтай холбогдоорой. Төлөөлөөд яах вэ Сангийн яамнаас хүн байна уу одоо? Сангийн яамнаас хэн байна? Ямар ч байсан хариулж байя, дараа нь Сангийн сайд ирээд нэмж хариулна биз. Гишүүдийн асуултад хариулчхаад тэгээд Сангийн сайд орж ирэхээрээ нэмж хариулна. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яамны Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ, Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Шүүхийн тухай хуулийн Хууль зүйн байнгын хороогоор хянагдаад яг Сангийн яаман дээр ирсэн дагуу ингээд нэгдсэн төсөвт нэгтгээд өргөн барь гэдэг энэ заалтыг бол хэрэгжүүлж чадахгүй байгаа нь бол үнэн. Тэрэнтэй бүрэн санал нийлнэ. Тэгэхдээ энэ зүгээр яг төсөв дээр ингээд хуваарилалт хийхэд бол бидний нийт зардлын хязгаарт хууль, шүүхийн салбараас гадна эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, нийгмийн халамж, дээрээс нь энэ бусад салбарууд гээд аягүй олон салбаруудын энэ хэрэгцээ шаардлагыг бид яг энэ 43 их наяд гэдэг төгрөгтөө л багтаах ийм шаардлагатай байдаг учраас. Тэгээд энэ дээрээ бол ингээд эрэмбэлээд төсвөө багтаагаад явдаг.

Төсвийн тухай хуулиар яг энэ төсвийн харилцаагаа зохицуулж байгаа учраас бид аль болох энэ байгаа жоохон эх үүсвэртээ бүх салбарынхаа энэ ирэх оны үйл ажиллагааг явуулахаар ингэж оруулж ирж байгаа.

Ер нь бол төсөв мөнгө бол ингээд хэзээ ч яг ийм хүрэлцээтэй сайн сайхан бол ер нь байдаггүй юм даа. Тэгээд л зардал бол ингээд л жил болгон л шаардлагатай байдаг. Тэгээд тэр хэрэгцээ шаардлага нь өндөр боловч бид нарын орлогын боломж маань хязгаартай. Тийм учраас тэгээд яг жил болгон энэ эрэмбээ тогтоогоод л энэндээ ингээд л тусгаад л оруулж ирээд л явж байгаа л даа. Хуваарилалтыг бол яг ингэж л хийж байгаа. Тэгээд энэ бол яах вэ яг Засгийн газрын зовлон.

Л.Мөнхбаатар: Баасанжаргал гишүүн асуултаа асууж байх уу? Үгээ хэлчихлээ. Энэ хооронд яах юм та яах юм тодруулах юм уу? Тэгье тэгье. Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би асуултаа асууя. Ингээд Засгийн газрынхаа аманд ороод л жил болгон ингээд ийм шүүхийн төсвийн тухай ийм асуудал яриад одоо

бүүр сүүлдээ би лав 3 дахь жилдээ энэ тухай яриад сууж байгаадаа ичээд л сууж байна. Яг үнэндээ бол манай Хуул зүйн байнгын хорооныхон яаж энэ шүүх эрх мэдлийн салбарынхаа нүүрийг харах юм байгаа юм? Ийм хүчгүй, ийм сул дорой. Тэгсэн мөртөө зам дээр хэчнээн тэрбумыг тавилаа та нар? Танаж болох өчнөөн олон зардал байгаа шүү дээ. Тэрийгээ танахгүй байж байж тэгээд танах болохоороо ингээд хамгийн түрүүнд шүүх эрх мэдэл рүү гараа дүрдэг бүүр ерөөсөө яг энэ эрэмбийн асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудал дээр манай Хууль зүйн байнгын хороо бүүр улс төрийн акц хийх ёстой гэдэг ийм байр суурьтай байна.

Миний гол асуулт нэгдүгээрт ийм асуулт байна. Энэ төсвийг, төсвийн хэлэлцүүлэг хийхээс өмнө манай Хүний эрхийн дэд хороо 2 том хэлэлцүүлэг хийлээ. Нэг нь сая энэ жил баталсан Хүүхэд, гэр бүлийн шүүхийн хуультай холбоотой, хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажилтай холбоотой нэг хэлэлцүүлэг хийсэн. Их Хурал энэ хуулийг батлаад тогтоол батлаад Засгийн газарт үүрэг өгсөн. Энэ тогтоол дээр тогтоолын 1 дүгээр зүйл дээр Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатын шүүхийн онцлог зориулалтад нийцсэн стандартын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барих байршил, газрын асуудлыг судалж шийдвэрлэх, 4 гэр бүл, хүүхдийн хэргийн хянан шийдвэрлэх энэ ажиллагаанд оролцох сэтгэл зүйчийг бэлтгэх, энэ үүнтэй холбоотой шаардлагатай төсвийг Монгол Улсын 27 оны төсвийн төсөлд тусган санхүүжүүлэх гээд ингээд ийм тогтоолыг Их Хурал баталчихсан байгаад байна. Энэ 2 тогтоол ерөөсөө биелэлтгүй орж ирж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ шүүх дээр ажиллах 32 сэтгэл зүйчийн орон тоог Сангийн яам руу явуулсан. Хасчихсан гэдэг мэдээлэл одоогийн байдлаар өгч байна. Энэ шүүх ажиллахгүй шүү дээ сэтгэл зүйч байхгүй бол. Энэ дээр тайлбар өгөөч. Сангийн яам яагаад хассан юм? Энийг өөр бусад байдлаар хэлэлцүүлгийн явцад өөрчлөх боломжтой юу, нэмэх боломжтой юу гэдэг нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр тэр “Оч” зуслан 1.6 тэрбум гээд Хууль зүйн яам хүүхдийн зуслангаар яах гэж байгаа юм? Тэр дор хүүхдийн тэр сургалт хүмүүжлийн байгууллагын барилгаа гүйцээхгүй юм уу? Өнгөрсөн жил Хүний эрхийн дэд хороо очиход энэ 26 онд ашиглалтад оруулна гэж байсан. Одоо болтол ашиглалтад ороогүй. Ирэх оны төсөв дээр дахиад л үлдэгдэл гээд л орж ирээд байна. Энэ барилга яагаад ашиглалтад ордоггүй юм? Хорихын хүүхдүүд болохоор та нар ингээд нүд үзүүрлээд байдаг юм уу? Та нар сэтгэл чинь зовохгүй байна уу? 2012 онд ашиглалтаас хасагдсан. 2020 онд ашиглах боломжгүй барилга. Үүнийгээ зогсоо гэдэг дүгнэлт гарсан барилга. Та нар хүүхдүүдээ тэнд 1 хоног ч байлгаж чадахгүй шүү дээ. Та нар өөрсдөө ч тэнд 1 хоног ч байж чадахгүй тийм газар байгаа шүү дээ хүүхдүүд. Энэ зуслангийнхаа мөнгийг тийш нь шилжүүл.

Гуравдугаарт манай хуулийн салбарынхан энэ хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлдог болмоор байна Эдийн засаг, хөгжлийн яам энэ салбарын энэ хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээр та хэд ажиллаад буцаагаад буцаагаад дахиж ажиллаад энийг нь шалгадаггүй юм уу? Өнгөрсөн жил манайх Хууль зүйн байнгын хороо бүтэн ажлын хэсэг гараад энэ дээр ажилласан. Ерөөсөө засагдаагүй дахиад хэвээрээ орж ирээд байна. Хүний гомдлыг, иргэний гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ гэдэг бол та нарын үүрэг болохоос биш хүрэх үр

дүн ерөөсөө биш. Төрийн байгууллага энэ ажлыг хийснээрээ, шүүх ажилласнаараа Хүний эрхийн Үндэсний Комисс ажилласнаараа, Улсын прокурор ажилласнаараа, Авлигатай тэмцэх газар ажилласнаараа иргэний амьдралд ямар өөрчлөлт гарах вэ гэдэг чинь та нарын үр дүн. Тэрнээс төрийн байгууллагын ажлыг хийсэн ажлаа энийгээ хийнэ гэдэг чинь үр дүн ерөөсөө биш. Энийг бүүр шинэчлэхгүй бол энэ бүүр дахиад яг өнгөрсөн жилийнх хэвээрээ тэр чигээрээ орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр манай Хүний эрхийн дэд хороо дахиж ажиллаад хүний эрхийн талаас нь бид нар саналаа гаргана. Байгууллагууд дахиад өөрсдөө дотооддоо ажилла, хүрэх үр дүнгээ өөрсдөө дахиад тодорхойл, өөрсдөө шалгуур үзүүлэлтээ дахиж гаргаж ир, зас, янзал өөрчил. Иргэнд ямар үр дүн авчрах гээд байгаа юм бэ та энэ төсвийг зарцуулснаараа гэдгээ бид нар болтол гаргаж ирж чадахгүй…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Авчих юм уу? Нэмэлт минут өгье Баасанжаргал гишүүнд.

Х.Баасанжаргал: Өчигдөр зарим яамнууд, зарим төрийн байгууллагууд бид нар хүний эрхтэй холбоотой ажил хийдэггүй, тийм төсөв манай дээр байхгүй гэсэн. Хүний эрхийг хангахын төлөө ажилладаггүй нэг ч төрийн байгууллага байх ёсгүй. Тэрийгээ ерөөсөө одоо болтол ойлгохгүй байгаа шүү дээ зарим яамнууд, зарим байгууллагууд.

Дараагийн асуулт Хууль зүйн сайдаас асууя. Энэ улс төрийн шинжтэй асуулт. Сая Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, хурандаа гэсэн үү, генерал гэсэн үү Намсамандыг сая танилцууллаа. Энэ хүн ажлаа хийсэн хэвээрээ байгаа юм байна гэж ойлгохоор байна. Тэгэхээр энэ хүн ямар мэдэгдэл хийсэн эсэхээс үл хамааралд төрийн хүчний байгууллага улс төрийн шинжтэй мэдэгдэл хийгээд бие бүрэлдэхүүн тэр чигээрээ гараад бүгдээрээ хувцас формтойгоо ийм үйл явдал болсон. Энэ төрийн байгууллага, тэр дундаа хууль хүчний байгууллагад энэ байж болох үзэгдэл юм уу? Цаашид энэ дээр ямар арга хэмжээ авах юм ямар төлөвлөгөө байгаа юм? Энэ дээр хариултаа авъя.

Л.Мөнхбаатар: Уянгахишиг гишүүн Сангийн сайдаас тодорхой асуултууд асуусан. Мэндсайхан сайд бэлтгэж байгаарай. Энэ хооронд Тэмүүлэн сайд тэгээд “Оч” зуслантай холбоотой асуудал яригдаж байна, мөн сая Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Дараа нь Уянгахишиг гишүүн тодруулж асуугаад 2 удаагийн хариулт байх нь байна Мэндсайхан сайдын. Баасанжаргал гишүүний хариулт. Дараачид нь Уянга гишүүний асуултад хариулах юм шиг байна. Тэмүүлэн сайд “Оч” зуслангийн талаар та мэдээлэлтэй байгаа юу? Ажлын хэсэг байвал яачих хэн Отгонбаяр байна уу? “Оч” зуслангийн тэр 6.5 тэрбум төгрөг тавьчихсан байна гээд байна шүү дээ. Тэрийгээ тайлбарла. Ямархуу үндэслэлээр төсөвт тавьсан юм бэ гэдгээ. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон өгье.

Н.Отгонбаяр: “Оч” Зуслангийн цэцэрлэг төсвийн төсөл дээрээс хасагдсан байгаа.

Л.Мөнхбаатар: Яасан гэнэ ээ? Сая хасагдсан юм уу тээ? Өчигдөр манай Хүний эрхийн дэд хорооноос бас энэ хүний эрхэд суурилсан энэ төсвийн бодлоготой холбогдуулж бас хэлэлцүүлгүүд хийгдсэн. Тэр үед бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрынхан танилцуулсан учраас Хууль зүйн яамнаас та танилцуулсан учраас бас манай гишүүд асуугаад байгаа юм шүү. Саяынхыг хасагдсан байхгүй юм байна гэж ойлголоо. Дараагийн асуулт нь яах уу Тэмүүлэн

сайд товч хариулах уу? Сангийн сайдын дараа болох юм уу? Сангийн сайд хариулчихъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

З.Мэндсайхан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Би сая энэ зэрэгцээ Байнгын хорооны хуралд байсан учраас хоцроод ороод ирлээ. Ер нь зүгээр яах вэ бид нар гишүүдийн гаргаж байгаа саналуудыг ойлгож байгаа. Гол асуудал бид нарт нэг л зовлон байгаа. Бид нарт орлогын хязгаар гэж зүйл байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам төсвийн хүрээг батлахдаа бид нар олж болох орлогынхоо дээд хэмжээгээр баталчих, доод хэмжээгээр. Энэ нөгөө боломжит орлогын хүрээнд бид нар зардлаа төлөвлөж орж ирж байгаа.

Жишээлбэл, энэ жилийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирсэн нийт санал бол төсвийн хязгаараас 17.5 их наядаар давж ирж байгаа юм. Төсвийн хөрөнгө оруулалт гэхэд бид нарт байгаа орон зай 3.4 их наяд. Ирсэн санал 9.5 их наядын санал ирж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ зовлон бол эндээ л байгаа. Тэгэхээр бид нар орж байгаа орлогодоо л тааруулж байгаа. Зөвхөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн салбараас гадна Монгол Улсын төсөв гэдэг бол Монгол Улсын бүх л салбарын зовлон, бэрхшээл тэр. Тэрний цаана хүний хөгжил, хүний амьдралын л асуудал байгаа.

Тэгэхээр бид нар энэ болгоныгоо бүх л салбартаа хамгийн эрэмбээ тогтоогоод л тэр эрэмбийнх нь хүрээнд нь аль боломжтой бүхэнд нь хүргэх тэр боломжийнх нь хүрээнд орлогодоо таарсан олж байгаа орлогынхоо хэмжээнд л бид нар зарлагаа төлөвлөж байгаа. 27 оны 1 сараас эхлээд хэрэгжих нийтдээ 14 хууль байгаа. Энэ хуулиудын зөвхөн төрийн албан хаагч болон төрийн захиргаа энэ ажилчид хүмүүсийнхээ Засгийн газар цалингийн бодлогыг хэрэгжүүлээд явъя гэхэд энэ нийгмийн даатгал, цалин, тэтгэвэртэй холбоотой энэ жил зөвхөн нэмэгдэж байгаа хуульчлагдсан зардал гэхэд 7.6 их наяд байгаа. Энэ бүхэн төсвийн хязгаар батлагдсанаас хойш гарсан хуулийн үр дагавраар гарч ирж байгаа юм. Тэгээд энэ бүхэн дээр Сангийн яам боломжит орлогынхоо хүрээнд зардлаа төлөвлөөд л ороод ирж байгаа ийм л асуудал. Түүнээс биш юу гэдэг юм Шүүх засаглалын хараат бус байдал руу бид нар хөрөнгө оруулалтыг нь татчихъя, таначихъя, үйл ажиллагааг нь доголдуулах ийм төсөв хийчихье гэдэг бодлогоор Сангийн яам төлөвлөлт хийдэггүй гэдгийг албан ёсоор хэлье.

Л.Мөнхбаатар: Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Харин би тайлбарлах гээд хичээгээд байна шүү дээ. Өнөөдөр бид нар гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдэл гэж хуваадаг. Тэгвэл гүйцэтгэх эрх мэдлийнхээ байгууллагын дотоод асуудлаа та бүхэн өөрөө тэрүүгээрээ шийд л дээ. Шүүх эрх мэдэл дээр чинь энд төсвийг чинь тодорхой байлгах гээд хуульчилчхаад байна шүү дээ. Тэгээд яагаад шүүх эрх мэдэл рүүгээ ингээд довтлоод байдаг юм. Энэ чинь зүгээр төрийн захиргааны аппарат биш шүү дээ. Зүгээр яам биш. Энэ чинь Засгийн газрын буюу гүйцэтгэх засаглалын зэрэгцээ оршиж байгаа шүүх эрх мэдэл.

Гэтэл шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахын тулд энэ төсөв чинь өөрөө байнгын Их Хурлаараа ороод, хянагдаад тэгээд тэрийг ямар нэгэн байдлаар хөдөлгөөнгүйгээр төсөвт нэгтгэх ёстой шүү гэдэг ийм хуультай шүү дээ. Тэгэхээр өнөөдөр бид нар Засгийн газар үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна, гүйцэтгэх засаглал үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна, мөнгө байхгүй

байна. Тэгэхээр нь шүүх эрх мэдлийн төсвөөс нь хасаад явчхаж байгаа юм гээд ийм тайлбар чинь болохгүй байгаа байхгүй юу даа. Тэгэхээр энэ дээр Байнгын хороо ажлаа хий.

Л.Мөнхбаатар: Сангийн сайд хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

З.Мэндсайхан: Уянгахишиг гишүүн ээ Засгийн газар үйл ажиллагаа явуулах гээд доголдохоор нь шүүх засаглалынхаа зардлыг танаж байгаа асуудал огт биш шүү. Яагаад гэхээр бид нар хуульчлагдсан зардлууд зөндөө байгаа. Би хэлээд байна шүү дээ 27 оны 1 сараас жишээлбэл хэрэгжих гэж байгаа шинэ 14 хууль байна. Боловсролын салбар нийт төсвийн зардлын 20 хувийг эзлэх ёстой, эрүүл мэндийн салбар 5 хувийг эзлэх ёстой, шүүх засаглал баталсан хуулийнхаа хүрээнд явах ёстой гээд ингээд хуульчилчихсан юмнууд бүгд байна. Тэр зорилт түвшин рүү нь хүргэхийн төлөө бид нар орлогодоо таарсан зарлагаа л төлөвлөж байгаа юм.

Түүнээс биш юу гэдэг юм энэ хуультай, тэр нь хуультай, тэрийг нь, хуулийг нь хаячих, Засгийн газрын үйл ажиллагаа явуулахын тулд шүүхийн үйл ажиллагааг үйл ажиллагааг доголдуулъя гэдэг бодлого байхгүй гэдгийг л би, бид нар л бодитоор нь хэлээд байна шүү дээ. Бидэнд байгаа орлогынхоо хэмжээгээр зарлагаа төлөвлөж яваа. Монгол Улсын төсөв гэдэг бол Монгол Улсын бүх салбарын төсөв шүү дээ. Бид нар онцгойлоод нэгийг нь ингээд байгаа асуудал байхгүй. Аль болох бид нар тэргүүн эрэмбийг нь шийдээд аль асуудал нь илүү тулгамдаж байна тэр рүү нь төвлөрүүлье гэдэг…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Хүүхэд, гэр бүлийн сэтгэл зүйчийн орон тоо гэж асуусан юм байна. Тэнд Сангийн яам хариулчих. Баасанжаргал гишүүний асуусан. Хэн хариулах юм Бат-Эрдэнэ хариулах юм уу хэн хариулах юм? Хүүхэд гэр бүлийн шүүхийн сэтгэл зүйчийн орон тооны асуудал. 32 орон тоо хасагдсан байгаа юм байна. Шүүх хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч байна гэж байна. Энд хариулт авъя. 3 номерын микрофон өгье.

П.Бат-Эрдэнэ: Сангийн яам Зарлагын хэлтэс Бат-Эрдэнэ, Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. 27 оны төсвийн төсөл дээр ер нь яг энэ орон тоотой холбоотой ер нь их олон салбар дээр орон тооны юугаа авч чадаагүй. Ирсэн хэрэгцээ, шаардлага бол асар өндөр байгаа. Бид бол 2027 оны төсөв дээр энэ Гэр бүлийн энэ хуультай холбоотойгоор энэ Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх энэ шүүхийн энэ орон тоо, цалингийн сангийн зардлыг бол тусгаад явсан байгаа. тэр сэтгэл зүйчийн орон тоог бол аваагүй.

Л.Мөнхбаатар: Тэн дээр хариулт өгөөрэй. Наадхыгаа явж бай. Би бас энэ дээр гишүүд бас сая хэлсэн үгэн дээрээ хэлчихье. Ер нь энэ Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн төсвийг Хууль зүйн байнгын хороо ингээд хянаж байгаа. Гэхдээ мэдээж шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл бол мэдээж хийгдэх шаардлагатай байгаа бүхий л асуудлуудаа оруулаад ирдэг. Үүнийг нь Хууль зүйн байнгын хороо бол ерөөсөө бууруулахгүйгээр, хасахгүйгээр л ингээд бас хянаад явуулдаг. Сангийн яам болон Засгийн газар өргөн мэдүүлэхдээ хасаж орж ирсэнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороон дээр ийм маргаантай асуудлууд үүсээд байгаа юм. Ийм учраас ер нь бол мэдээж аль аль талынхаа л ажил, талынхаа зовлонг бол бүгдээрээ мэднэ.

Тэгэхээр Сангийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хянасан төсөв өргөн барих өргөн барихынхаа өмнө хоорондоо сайн ойлголцож орж ирмээр байгаа юм. Нэн шаардлагатай хөрөнгө оруулалтуудаа эрэмбэлээд хоорондоо ойлголцоод ингэхгүй бол сүүлд нь Хууль зүйн байнгын хороог ийм төвөгтэй нөхцөл байдал руу тулгаж тавиад манай гишүүд бол энэ дээр бол өөрсдийнхөө хянасан төсвийнхөө хүрээнд байх ёстой гэдэг шаардлага тавина. Энэ зүй ёсны. Гэтэл Сангийн яам хасагдсан энэ шалтгаан нь бол ерөөсөө зөвхөн төсвийн хүндрэлтэй нөхцөл байдал гээд тодорхой ганцхан зүйл хэлчихдэг. Энэ хооронд болоод байна.

Тийм учраас ер нь бол өөрийнхөө төсөв болоод хөрөнгө оруулалтынхаа төлөө Шүүхийн ерөнхий зөвлөл маань бас идэвхтэй сайн ажилла, Сангийн яамтайгаа тодорхой хэмжээнд ойлголцож төсвөө өргөн барьж байвал энэ асуудал бол шийдэгдээд явах боломжтой шүү гэдгийг хэлье.

Гэхдээ манай гишүүдийн хувьд бол зарчмын зөрүүтэй санал гаргах эрх нь нээлттэй байгаа. Энэ хоёрдугаар хэлэлцүүлэг бол төсвийг танилцуулж байна. Төсвийн байнгын хороонд бид саналаа хүргүүлнэ. Гуравдугаар хэлэлцүүлэг дээр бол зарчмын зөрүүтэй санал гаргаад тодорхой төсвүүдээ нэмэгдүүлэх асуудлыг явуулаад, дэмжүүлээд, дэмжлэг авах юм бол энэ асуудал шийдэгдээд явах бүрэн боломжтой байгаа шүү гэдгийг хэлье. Үлдэгдэл дээр нь юугаа хариулчих. Хариулчих ажлын хэсгийн гурав дугаар микрофоноо өгчих.

П.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Шүүхийн ерөнхий зөвлөл дээр 2027 оны төсөв дээр энэ ер нь нийт орон тоог нь 190-ээр нэмэгдүүлсэн юм. Тэгээд энэ 190-ийн орон тоо болон 190-ийн орон тооны цалин хөлс болох 14.8 тэрбум төгрөгийг бол төсөл дээр нэмж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол бас зохицуулалтаа хийгээд энэ тодорхой хэмжээнд сэтгэл зүйчээ тодорхой хэмжээнд шүүгч нар ажиллуулаад энэ зохицуулалт хийгээд явах боломжтой гэж бид бол үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Сангийн яам хэлэлцүүлгийн явцад Төсвийн ажлын хэсэг байгуулагдана. Энэ үедээ сая энэ хуульд заагдсан энэ байгууллага, шүүх хэвийн үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх асуудал дээр ойлголцолд өртөгдөж ажиллах ёстой шүү. Ер нь бол зарчмын зөрүүтэй саналууд гишүүд гаргах байх. Тэр дээр нь төсвийн орон зай гаргаад ингээд явах нь зүйтэй гэдгийг бас та бүгдэд хэлье.

Ер нь бол Сангийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөл бол энэ төсөв өргөн барихынхаа өмнө уулзаж, энэ асуудлуудаа ойлголцож, оруулж ирж байх нь зүйтэй гэдгийг бас энд та бүгдэд бас анхааруулан хэлье. Ингээд хэн хүүхдийн хорих гэж хэн хариулах юм? Цэргийнхүү хариулчих. Цэргийнхэн 2 номерын микрофон дээр суучих.

Г.Цэргийнхүү: Гишүүний асуултад хариулъя. 2024 оноос он дамжаад хүүхдийн хорихын Сургалт, хүмүүжлийн Төвийн барилга тодорхой төсвүүд тавигдаад одоо гүйцэтгэл 87 хувьтай байгаа. 2027 оны төсвийн төсөөлөлд 1.8 тэрбум төгрөг тавигдсан. Одоо үндсэн барилга бол үндсэндээ дууссан. Спорт цогцолбор, уурын зуухны барилгын бас байгууламж дутуу гүйцэтгэлтэй явж байна. Тийм. 26 онд харин төсөв дутуу тавигдаад одоо энэ төсвийн 27 оны юун дээр дутуу төсөв тавиад 1.8 тэрбум тавигдахаар ороод ирчихсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Үлдэгдэл санхүүжилт нь төсөв туссан юм байна гэж ойлголоо. Ойлголоо. Өөр хэн хариулах юм? Эдийн засаг, хөгжлийн яам хүн байна уу? Хариулт өгөх хүн байна уу? Төсвийн төлөвлөлт болон хүрэх үр дүнгийн талаар л асуугаад байна шүү дээ. Төрийн нарийн дарга энэ мэдээллээ Баасанжаргал гишүүнд та бүхэн бичгээр асуултад нь хариулж албан албан бичгээр хандаж хариулна шүү.

Тэмүүлэн сайд асуултад хариулъя.

Г.Тэмүүлэн: Сүүлийн үед Хууль зүй, дотоод хэргийн яамтай холбоотой, манай яамны харьяа байгууллагуудтай холбоотой хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тодорхой эргэлзээтэй нийгэмд бас тодорхой бухимдал үүсгэсэн хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй энэ асуудал үүссэн. Энэ асуудлаар бол би тодорхой нэр холбогдсон эрх бүхий албан тушаалтнууд буюу агентлагийн дэд дарга нарыг Засгийн газрын тухай хуульд заасан тэр дүрэм, журмынх нь дагуу эрхлэх асуудлынхаа хүрээнд нэр холбогдсон эрх бүхий албан тушаалтнуудыг бол чөлөөлсөн байгаа бүгдийг нь. 2 агентлагийн 6 дэд даргын асуудал.

Агентлагийн даргын асуудал бол энэ Засгийн газрынхаа тухай хуулиараа Засгийн газрын хуралдаанаар Засгийн газрын тогтоолоор шийдвэрлэгдэх асуудал байдаг. Одоогийн байдлаар бол миний гар дээр ямар нэг тогтоол, шийдвэр ирсэн зүйл бол байхгүй байна. Хуул зүй, дотоод хэргийн яамнаас энэ асуудлаар бас мөн шалгах үйл ажиллагаа явуулаад ажлын хэсгийн шалгалтын үйл ажиллагаа бас ид үргэлжилж байгаа. Тун удахгүй өнөө маргааш

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэн юм бэ? Баасанжаргал гишүүн. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал үг хэлнэ.

Х.Баасанжаргал: Энэ хүүхэд гэр бүлийн шүүхийн тухай хууль хэрэгжихэд шаардлагатай төсөв, санхүүгийн асуудлыг Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам гээд ингээд энэ бусад эдийн засгийн бодлого барьдаг газрууд сайн ойлгож өгөхгүй байх шиг байна. Та бүхэн энэ шүүхийн үйл ажиллагаатай 11 сарын 01-нд албан ёсоор нээгдээд тэнд ямар хэрэг маргаан шийддэг, тэнд ямар хүүхдүүд очдог, тэнд гэр бүлүүд юу ярь очдог вэ гэдгийг та бүхэн очиж албан ёсоор айлчилж бас танилцаарай гэж хүсье. Тэгж байж бас энэ шүүхийн мөн чанарыг ойлгох болов уу гэж бодож байна.

Бусад улс орны жишгээр бол мэдээж Хүүхэд, гэр бүлийн шүүх бол хамгийн өндөр зардалтай шүүхүүдийн нэг байдаг хэдий ч хэзээ ч хүүхэд, гэр бүлээс мөнгөө харамлах ёсгүй учраас үйл ажиллагааных нь тогтвортой, байнгын найдвартай, мэргэжлийн байдлыг нь хангахад онцгой анхаардаг. Тэгэхээр энэ хуулийг батлахад Их Хурал яг энэ өнцгөөр нь бид Их Хурал энэ хуулийг баталсан тогтоолыг баталсан. Харамсалтай нь төсөв үүнийг баталгаажуулаагүй. Төсөв хүүхдийн эрхийг хамгаалахад төсөв гэр бүлийн сайн сайхан байдлыг хамгаалахад Засгийн газар үйлдэл хийж байна уу, үгүй юү гэдгийг чинь төсөв дээр байгаа дүнгүүд чинь харуулдаг. Төсөв дээр юугаа зарцуулж байна? Замд мөнгөө зарцуулж байна. Засгийн газар замд анхаарч байна гэсэн үг. Хүндээ биш гэсэн үг.

Тэгэхээр энэ бодлогоо та бүхнийг олж эргэж хараад энэ асуудлыг ерөөсөө нэг углуургаар нь, мөн чанараар нь, уг үндсээр нь олж хараасай ойлгоосой гэж хүсэж байна.

Хоёрдугаарт энэ манай хууль зүйн салбар яамнууд Хууль зүйн байнгын хороон дээр хамаарах байгууллагуудаас гадна бусад төрийн яам, байгууллагууд ч гэсэн бүгдэд нь энэ хамаатай энэ хүрэх үр дүн, зорилго, шалгуур үзүүлэлтүүдээ тавьж байгааг нь харахлаар жишээ нь Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны чанар, тэгш хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх, иргэний эрхийг хангаж, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ гэж байна. Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэг маргааныг хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэнэ гэж байна. Хүний эрхийн Үндэсний Комисс хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдлыг хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэнэ. Улсын Ерөнхий прокурор бас яг адилхан гарсан гомдлыг хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэнэ гээд. Энийг болохгүй байна. гээд өнгөрсөн жил бол нэлээн ул суурьтай яриад нэлээн бас олон улсын байгууллага төсөл, хөтөлбөрүүд бас энэ дээр сургалт үйл ажиллагаа явуулдаг гээд ингээд уг нь яригдсан байгаад байгаа юм.

Тэгээд Засгийн газар чинь тэр чигээрээ үр дүнд суурилсан байдлаар үйл ажил гагаа төлөвлөдөг болно гэсэн чинь орж ирж байгаа үр дүн нь зүгээр тэр төрийн байгууллагын үйл ажиллагааны л үр дүн болохоос биш иргэнд очиж байгаа үр дүнг бид нар ерөөсөө тодорхойлж чадахгүй байна. Энийг бүүр дахиад засах ажлыг хийнэ. Энэ төсвийн хэлэлцүүлгийн үеэр. Өнгөрсөн жил Их Хурлын байнгын хороо ажлын хэсэг өөрсдөө ажиллаж зассан бол энэ удаа төрийн байгууллагууд өөрсдөө засаж орж ирнэ. Засгийн газрын өмнөөс одоод бид нар та нарын ажлыг хийхгүй. Засгийн газар өөрөө ажлаа сайжруулж орж ирнэ. Энэ орон зайг нь олох ёстой гэж бодож байна.

Гуравдугаарт би яагаад тэр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагуудын хийсэн хэвлэлийн хурлын талаар асуусан бэ гэвэл энэ төрийн хүчний байгууллага улс төрийн эрх мэдэлтэй зөрчилдөхдөө ямар хил хязгаар давах ёсгүй ямар шугамыг давсан бэ гэдгийг бүгд харах, ойлгох ёстой. Энэ сургамж олох ёстой. Тэрнээс энэ хэвийн үзэгдэл байж болохгүй.

Цаашид улс төрийн албан тушаалтан хэний, төрийн тусгай албан тушаалтан нь хэний ямар захирах захирагдах ёс байдаг юм. Хэрвээ хууль зөрчсөн шийдвэр чиг, чиглэл хэрвээ өгсөн бол түүнийг хууль ёсны дагуу яаж шийдвэрлүүлэх ёстой юм бэ гэдгийг мэдэх ёстой. Энэ дээр Хууль зүйн яам тодорхой бодлогын шийдвэр гаргах ёстой. Одоо тэгээд бүүр сайхан бусад байгууллага, бусад иргэний нийгмийн байгууллагуудтай адил…/минут дуусав./

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Нэг мэдээлэл хэлчихье. Маргааш өглөө 8 цаг 30 минутаас гадаад улсын зарим иргэний холбогдсон гэмт хэрэгт Монгол Улсын талаар дурдагдсан асуудлын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах сэдэвт ерөнхий хяналтын сонсгол хийгдэнэ. Энд Байнгын хорооны гишүүдийн олонх ирснээр ирц бүрдэж, уг сонсгол эхэлнэ. Тийм учраас идэвхтэй оролцоорой.

Ингээд Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай,

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Төсвийн байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Ажлын хэсэгт баярлалаа.

18.14 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР